In the second Joint Coordinating Committee (hereinafter referred to as “JCC”) on April 14, 2017, Mongolian side submitted the member list of the C/P WG that was amended from the member list approved in the first JCC on December 7, 2016 in order to take their share of responsibility for each sub-WG activity and work closely with JICA Expert team. JCC members agreed the members of WG as shown below.

WG	Member	Job title
WG1: Disaster Management Plan	D.Bazarragchaa (Coordinator for WG1)	Policy Coordination and Cooperation Department, NEMA
	D.Serjmyadag	Law Enforcement University of Mongolia
	P.Amarzaya	Disaster Research Institute, NEMA
	B.Batbayar	Disaster Risk Management Department, NEMA
	B.Bayanmunkh	Policy Coordination and Cooperation Department, NEMA
	B.Myagmardorj	Disaster Operation Department, NEMA
	Ch.Otgontugs	Fire Department, NEMA
	B.Khishigbaatar	Disaster Operation Department, NEMA
	E.Batbayar	EMDC
	B.Purevnyam	Disaster Operation Department, NEMA
	D.Badamsuren	Disaster Research Institute, NEMA
	D. Sodnomragchaa	Disaster Research Institute, NEMA
	B.Boldkhuu	Disaster Operation Department, NEMA
	E.Altankhishig	Policy Coordination And Cooperation Department, NEMA
B.Duvshin	Disaster Risk Management Department, NEMA	
WG2: Seismic	D.Zanabazar	MCUD

## Monitoring Sheet Summary

WG	Member	Job title
Resistance	(Coordinator for WG2)	
	Z.Battulga (Coordinator for WG2)	Disaster Operation Department, NEMA
	Sh.Uranchimeg	Inspection Agency
	B.Tsend-Ayush	Master Planning Agency of Capital City, Construction Quality and Safety Department
	G.Saruultuya	Construction Development Center
	T.Galbadrakh	Finance and Logistics Department, NEMA
	G.Erkhembayar	MCUD
	B.Gantulga	Land Management, Survey and Mapping Agency, MCUD
	M.Oyunchimeg	Mongolian University of Science and Technology
	B.Munkhsaikhan	Inspection Agency
WG3: Education	D.Munkhbat (Coordinator for WG3)	Disaster Prevention Department, NEMA
	J.Myagmar	MECSS
	Ch.Gantsetseg	MECSS
	P.Baljinnyam	MECSS
	Ts.Chimedlkham	MECSS
	G.Mongolkhatan	Education Research Institute, MECSS
	B.Erdenechimeg	Education Research Institute, MECSS
	A.Enkhtogtokh	Education Research Institute, MECSS
	O.Tsend-Ayush	Disaster Prevention Department, NEMA
	D.Bat-Erdene	Disaster Prevention Department, NEMA
	B.Uuriingegee	EMDC
	B.Unenbaatar	EMDC
	D.Dulamsuren	Public Information Center, Disaster Prevention Department, NEMA
	S.Amgalan	Administrative Management Department, NEMA
M.Amartungalag	MECSS	
WG for the Survey of Procuring Equipment	S.Amgalan (Double as WG3)	Administrative Management Department, NEMA
	T.Galbadrakh (Double as WG2)	Finance and Logistics Department, NEMA
	Khurelbaatar	DRR Training Center, EMDC

### 1-2 Үйл ажиллагааны явц

#### (1) Төслийн тухай ерөнхий мэдээлэл

##### 1) Хамтарсан Зохицуулах Хорооны хурал

Уг төслийн ХЗХ-ны хурлыг тус хугацаанд 2016 оны 12 сарын 7 өдөр, 2017 оны 4 сарын 14 өдрүүдэд 2 удаа зохион байгуулсан болно.

ХЗХ-ны 1 дүгээр хуралдаан Монголын болон Японы талаас нийт 28 оролцогчтойгоор зохион байгуулагдав. Тус хурлаар Төслийн ажлын төлөвлөгөө, Хяналтын хуудас I, II-ын “Хувилбар 1”, Ажлын хэсгийн гишүүд болон Төслийн захирал өөрчлөгдсөнтэй холбоотой асуудлыг хэлэлцэж Хурлын тэмдэглэлд (Хавсралт-1) гарын үсэг зурав.

ХЗХ-ны 2 дугаар хуралдаанд Монголын болон Японы талаас нийт 37 төлөөлөгч оролцов. Тус хурлаар Ажлын хэсгийн гишүүдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, Төслийн захирал өөрчлөгдсөнтэй холбогдуулж Хэлэлцүүлгийн тэмдэглэлд тусгах, нийлүүлэх тоног төхөөрөмж болон Япон дахь сургалтын тухай хэлэлцэж Хурлын тэмдэглэлд (Хавсралт-2) гарын үсэг зурав.

## **2) Нийлүүлэх тоног төхөөрөмжийн тухай**

ХЗХ-ны 1 дүгээр хуралдаанаар батлагдсан Төслийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсанаар газар хөдлөлтийн тэсвэржилтийг хэмжих багаж хэрэгсэл ба Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвд суурилуулах газар хөдлөлтийн чичирхийллийг мэдрүүлэх төхөөрөмжийг ЖАЙКА-аас хүлээлгэн өгөх төлөвлөгөөтэй байна.

Уг төхөөрөмжийг суурилуулахтай холбогдуулан Монголын тал Ашиглалт үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулж ОБЕГ-ын даргын албан бичгийн хамт ЖАЙКА-н Монгол дахь төлөөлөгчийн газарт хүлээлгэн өгсөн.

ХЗХ-ны 2 дугаар хурлаар уг асуудалтай холбогдуулан тус төхөөрөмжийг Монгол улсад нэвтрүүлэхэд гамшгийн эрсдэлийг бууруулах бодлогын угтвар нөхцлийн талаар нэмж тайлбарлах болон Ашиглалт үйлчилгээний үйл ажиллагааг хариуцах гол байгууллагуудыг тодорхой болгох шаардлагатайг Японы талаас цохон дурдав. Үүний дагуу, ЖАЙКА нь Ашиглалт үйлчилгээний төлөвлөгөөтэй холбоотой нэмэлт мэдээлэл оруулахыг хүссэн тухай албан бичгийг хүргүүлэх талаар тайлбарлан дурдав.

## **3) Япон болон гуравдагч орон дахь сургалт**

“Гамшгийн эрсдэлийг бууруулах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх” сэдэвт Япон дахь сургалт 2017 оны 3 сарын 20 өдрөөс 29 өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулагдав. Уг сургалтад Монголын талаас 15 хүн оролцохоор байсан боловч 3 оролцогч сургалт эхлэхээс өмнөхөн ямарваа нэгэн дэлгэрэнгүй тайлбар өгөлгүйгээр сургалтад оролцоогүй учраас 12 оролцогчтойгоор зохион байгуулагдав.

Япон дахь сургалтын үр дүнд хүлээн авсан мэдээлэл, сургамжийг Ажлын хэсгийн гишүүд, ОБЕГ болон холбогдох байгууллагын мэргэжилтнүүдтэй хуваалцах

зорилгоор Ажлын хэсэг тус бүрээс сургалтад оролцсон гишүүд сургалтын үеэр олж авсан мэдлэг, туршлага, мөн цаашид Ажлын хэсгийн үйл ажиллагаанд үүнийг хэрхэн тусгах талаар 2017 оны 4 сарын 17 өдөр зохион байгуулагдсан Удирдах хорооны хурал дээр танилцуулга хийв. Энэхүү хуралд ЖАЙКА-ын Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга болон бусад холбогдох албан тушаалтан оролцож энэхүү танилцуулгын талаар мэдээлэл авсан болно.

Монголын тал Япон дахь 2 дугаар сургалтын тухайд Ажлын хэсэг тус бүр дээр журам заавар, санамж бичиг, сургалтын хөтөлбөр гэх зэргийг боловсруулахад шууд тусгах тухайлсан мэдлэг болон техник аргачлал, арга зүйн талаар суралцах нь зүйтэй гэсэн санал дэвшүүлсэн. Монголын талын санал болгосон агуулгын тухайд Японы тал нь сургалтаар олж авсан мэдлэг туршлагыг юуны түрүүнд Ажлын хэсгийн үйл ажиллагаанд тусгах хэрэгтэй бөгөөд дараагийн сургалтын агуулгын талаар Ажлын хэсэг тус бүр дээр санал солилцон 2017 оны 6 сард зохион байгуулагдах ээлжит ХЗХ-ны хурлын өмнө шийдэж тодорхой болгох гэж дурдав.

## **(2) Үр дүн 1**

### **Үйл ажиллагаа 1.1.1 Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжүүлэлтэд тулгарч буй асуудлыг тодорхойлох**

WG examined existing status of formulation of guidelines and manuals for disaster management plan and gathered information about rules and regulations for disaster risk reduction in order to reveal a plan to develop guidelines in the Project. As a result,

Монгол улсад гамшгийн шуурхай удирдлагын төлөвлөгөөтэй холбоотой журам, дүрэм зонхилдог бөгөөд гамшгаас урьдчилан сэргийлэх, хойшлуулшгүй сэргээн босголт, гамшгийн дараах сэргээн босголтын үйл ажиллагаатай холбоотой журам, дүрэм хангалтгүй байдгийг нягталж тодорхой болгосон. Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилттэй холбоотойгоор ОБЕГ нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөний журам, дүрэм шинээр боловсруулах, шинэчлэх шаардлагатай байгаа. Мөн, гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах тухайд “Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загварыг ашиглах заавар” (ОБЕГ-ын даргын 2013 оны тушаалын 2 дугаар хавсралт)-ын дагуу боловсруулдаг боловч зааврын агуулга нь хэт ерөнхий бөгөөд гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахад үндэс суурь нь болохуйц шинэ заавар шаардлагатай байгаа гэж үзэв.

### **Үйл ажиллагаа 1.1.2 Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж, төлөвлөлт, төлөвлөгөөний үялдаа холбоог сайжруулах, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгийн мэдээллийн сангийн журам заавар боловсруулах**

Эрсдэлийн үнэлгээний журам зааврын тухайд Ажлын хэсэг дээр журам зааврын хүрээ, бүтэц зохион байгуулалтын талаар тодорхой болгов. ОБЕГ-т Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг хангахын тулд “Гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх журам”(Засгийн газрын 2006 оны 176 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт)-ыг шинэчлэх ажил явагдаж байна. Уг төслийн хүрээнд боловсруулах заавар журам болон дээрх журам хоорондын уялдаа холбоог хангах тухай Ажлын хэсэг дээр үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний журам зааврын тухайд Ажлын хэсэг дээр журам зааварт тусгах үндсэн агуулгын тухай нягталж хэлэлцэв. Үйл ажиллагаа 1.1.1 дээр тодорхой болгосны дагуу гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахад ашигладаг заавар болох “Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загварыг ашиглах заавар” (ОБЕГ-ын даргын 2013 оны тушаалын 2 дугаар хавсралт)-т тулгуурлан аймаг, нийслэл, сум, дүүрэг, ААН байгууллага гамшгаас хамгаалах төлөвлөгөөгөө боловсруулдаг. Уг баримт бичигт гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүтэц болон төлөвлөгөөнд тусгавал зохих бүлэг заалтын талаар заасан байдаг боловч гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай, зохистой гарын авлага байдаггүй бөгөөд дан ганц уг заавраар орон нутгийн нэгж болон байгууллагын төвшинд гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахад хүндрэлтэй болох нь мэдэгдсэн. Иймээс, Ажлын хэсэг дээр уг зааврын оронд гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулахад үндэс суурь нь болохуйц заавар боловсруулж, ОБЕГ-ын даргаар батлуулах чиглэлтэй ажиллаж байна.

Төслийн эхлэх үеийн төлөвлөгөөнд Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үе шатанд боловсруулсан Төслийн төлөвлөлтийн матриц (Project Design Matrix)-ын агуулгад үндэслэн Бэлэн байдлын төлөвлөгөөний заавар, Гамшгаас хамгаалах хяналтын заавар боловсруулах ажлыг Үйл ажиллагаа 1.1.2-т төлөвлөж байсан бөгөөд Бэлэн байдлын төлөвлөгөөний заавар нь бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, бэлэн байдлын зэрэг тус бүрт авах арга хэмжээг тусгасан баримт бичиг, Гамшгаас хамгаалах хяналтын заавар нь голчлон газар хөдлөлтийн үед төсөөлөгдөх хохирлыг бууруулахад чиглэгдсэн хөрөнгө оруулалтыг хянах тухай баримт бичиг гэсэн ойлголттой байв. Гэвч, батлагдсан Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга дахь зүйл заалт, шинээр боловсруулах журам, дүрмийн агуулгыг нягталж үзсэний үр дүнд дээрх хоёр төрлийн зааврын угтвар нөхцөл болох хуулийн зүйл заалт болон журам, дүрмийн агуулгад өөрчлөлт орж, боловсруулах зааврын зорилго, түүний агуулгын чиглэлийг өөрчлөх шаардлагатай гэж үзэж байна. Одоогийн байдлаар Бэлэн байдлын төлөвлөгөөний заавар, Гамшгаас хамгаалах хяналтын заавар боловсруулах чиглэлийн тухайд Ажлын хэсэг

дээр үргэлжлүүлэн санал солилцон хэлэлцэж байна.

Мэдээллийн сангийн зааврын тухайд Үйл ажиллагаа 1.3.3-ын хүрээнд бүрдүүлэх Гамшгаас хамгаалах мэдээллийн удирдлагын системийг удирдах тогтолцоо, мэдээллийн сангийн техникийн нөхцөл, холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцох тогтолцооны талаар заавар болгож нэгтгэх талаар нягтлав.

**Үйл ажиллагаа 1.1.3 Гамшгаас хамгаалах тухай хууль хэрэгжүүлэхтэй холбогдон гарах баримт бичгийг шинэчлэх төсөл, шаардлагатай баримт бичгийн санал боловсруулах**

Үйл ажиллагаа 1.1.1-ийн дагуу Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасан ОБЕГ-ын эрх, үүрэгт үндэслэн журам, дүрэм шинээр боловсруулах болон шинэчлэх шаардлагатай болсон. Ажлын хэсэг дээр эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөө, бэлэн байдлын төлөвлөгөө, гамшгаас хамгаалах хяналт талаас нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын зүйл заалтуудын талаар судалж шинээр боловсруулах болон шинэчлэх шаардлагатай журам, дүрмийн талаар судалгаа хийв. Үүний үр дүнд 11 журам, дүрмийг шинээр боловсруулах, шинэчлэх шаардлагатайг нягталж тогтоов. Мөн, тухайн журам, дүрмийн үндсэн ойлголтын тухай судалж ОБЕГ-ын хувьд шинээр боловсруулах, шинэчлэх журам, дүрэм тодорхой болсон байгаа. “Гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх журам” (Засгийн газрын 2006 оны 176 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт)-ын тухайд, ОБЕГ шинэчлэх ажлыг эхлүүлсэн байгаа бөгөөд шинэчлэх агуулгатай холбоотойгоор ЖАЙКА-ын мэргэжилтний багаас Японы арга туршлагад үндэслэсэн мэдээллийг өгөх ажил явагдсан.

Журам, дүрэм шинээр боловсруулах, шинэчлэх ажлыг ОБЕГ удирдан хэрэгжүүлж байгаа бөгөөд ЖАЙКА-ын мэргэжилтний баг нь шаардлага хэрэгцээнд нийцүүлэн мэдээлэл өгөх ажлыг үргэлжлүүлэн явуулж байна. Нөгөөтэйгүүр, журам дүрмийн хэрэгжилтийг бодитоор гүйцэлдүүлэн хангахад чиглэгдсэн зааврын тухайд Ажлын хэсэг нь голчлон боловсруулах ажлыг хэрэгжүүлэх чиглэлийг баримталж байна.

**Үйл ажиллагаа 1.2.1 ОБЕГ болон гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч байгууллагын харилцан ажиллагааны санамж бичгийн төсөл боловсруулах**

ОБЕГ-ын байгуулах харилцан ажиллагааны санамж бичгийн тухайд, Ажлын хэсэг дээр хамаарах салбарын талаарх мэдээллийг эмхтгэж төрийн болон олон нийтийн 27 байгууллагатай 25 санамж бичиг байгуулах шаардлагатай байгааг тодорхой

болгов. Байгуулах санамж бичгийн төрөл болон агуулга, олон төрлийн салбар хамарсан байгаа байдлаас үүдэж юуны түрүүнд санамж бичгийн эх төсөл боловсруулах шат дарааллыг эмхтгэх зорилгоор Монгол улс болон Япон улс тус тусын урьд өмнө нь байгуулсан санамж бичигт харьцуулалт, задлан шинжилгээ хийж “Санамж бичиг боловсруулах гарын авлага” болгож эмхтгэсэн болно.

Үүний зэрэгцээ, Ажлын хэсэг дээр харилцаа холбооны салбарыг санамж бичиг байгуулах салбар болгон сонгон авч холбогдох байгууллагатай санал солилцон “Санамж бичиг боловсруулах гарын авлага”-ын дагуу санамж бичиг боловсруулах ажлыг хэрэгжүүлж буй үе шатанд байна.

**Үйл ажиллагаа 1.3.1 Улс болон орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй холбоотой асуудлыг тодорхойлох, үг төлөвлөгөөг сайжруулан шинэчлэх**

Үйл ажиллагаа 1.1.1-д дурдсанчлан, Ажлын хэсэг дээр Улс, Нийслэл, Аймаг болон Сумын төвшинд газар хөдлөлтийн гамшгийг голчилж гамшгаас хамгаалах төлөвлөгөөний одоогийн нөхцөл байдлын талаар судалж тулгарч буй асуудлыг эмхтгэж тодорхой болгов.

Одоогийн хүчин төгөлдөр Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тухайд, гамшгийн төрөл тус бүрээр шуурхай удирдлагын агуулгын талаар голчлон тусгасан байгаа бөгөөд урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах талаар дурдагдаагүй тул ЖАЙКА мэргэжилтний багаас Японы гамшгаас хамгаалах үндсэн төлөвлөгөөний Гамшгийн төрөл тус бүрийн нийтлэг арга хэмжээ буюу Нийтлэг үндэслэлийг мэдээлэл болгож хүлээлгэн өгөв. Японы Гамшгаас хамгаалах үндсэн төлөвлөгөөний бүтцийг авч үзэн, урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах үйл ажиллагаа талаас нь авч үзэн Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгавал зохих агуулгын талаар судалж байна.

Нийслэл, аймаг болон сумын төвшний Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь Үйл ажиллагаа 1.1.1-д авч үзсэний дагуу, үндсэндээ “Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загварыг ашиглах заавар” (ОБЕГ-ын даргын 2013 оны тушаалын 2 дугаар хавсралт)-т үндэслэн боловсруулагддаг. Уг зааврын тухайд агуулга нь хэт ерөнхий бөгөөд эмх цэгцтэй төлөвлөгөө боловсруулахад учир дутагдалтай гэсэн асуудал байгаа. Үйл ажиллагаа 1.1.2-т дурдсаны дагуу, Ажлын хэсэг дээр гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахад үндэс суурь нь болохуйц заавар боловсруулах ажил явагдаж байгаа бөгөөд энэхүү зааварт тулгуурлан орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн сайжруулах чиглэлтэй байгааг нягталсан.



**Үйл ажиллагаа 1.3.2 1.3.1-д дурдсан төлөвлөгөөг шинэчлэн сайжруулах гарын авлага боловсруулах**

Үйл ажиллагаа 1.3.1-д дурдсаны дагуу, Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тухайд Японы Гамшгаас хамгаалах үндсэн төлөвлөгөөний бүтцийн талаарх мэдээллийг ашиглан урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах талаарх агуулгыг нэмж оруулах ажлыг Ажлын хэсэг дээр эхлүүлсэн болно.

**Үйл ажиллагаа 1.3.3 Гамшгаас хамгаалах мэдээллийн сан, мэдээлэл цуглуулах, задлан шинжилгээ хийх одоогийн системийг шинэчлэн сайжруулах**

Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын 14 дүгээр зүйл “Гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх”-д ОБЕГ нь гамшгийн мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлнэ гэж заасан байгаа. Одоогоор, Гамшиг судлалын хүрээлэн гамшгийн түүхчилсэн өгөгдөл мэдээллийг хуримтлуулах, удирдах ажлыг хэрэгжүүлж байгаа боловч Гамшгаас хамгаалах төлөвлөгөө болон Гамшгаас хамгаалах Цагаан ном боловсруулахад ашиглах боломжтой мэдээллийн сангийн төрөл зүйл хязгаарлагдмал байна. Мөн, орон нутгийн гамшгаас хамгаалах газар хэлтэс болон холбогдох байгууллагатай мэдээлэл солилцох, мэдээллийн сангийн уялдаа холбоо, бусад байгууллагад мэдээлэл дамжуулан хүргэх үйл ажиллагаа хангалттай хэрэгжихгүй нөхцөл байдалтай байгааг тодорхой болгож авсан.

Ажлын хэсэг дээр одоогийн байгаа системийг шинэчлэн сайжруулах талаар санал солилцож хэлэлцсэний үр дүнд Монголын талаас газрын зургийн мэдээлэл дээр үндэслэн мэдээлэл солилцох тухай хүсэлт гарсан бөгөөд уг төслийн хүрээнд газар зүйн мэдээллийн систем (GIS)-д суурилсан гамшгийн мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг өрнүүлэх ажлын чиглэлтэй байгааг нягталсан болно. ЖАЙКА мэргэжилтний багаас Японы Гамшгаас хамгаалах шинжлэх ухаан технологийн хүрээлэнгийн боловсруулсан “И-коми мап” (ГХШУТХ-ийн боловсруулсан вэб-д суурилсан газар зүйн мэдээллийн систем)-ыг танилцуулж Газар зүйн мэдээллийн системд суурилсан байдлаар туршилтын журмаар нэвтрүүлэх ажлыг өрнүүлж байна. ОБЕГ-ын хувьд системийн удирдлагыг тасралтгүй үргэлжлүүлэх байдлыг хангах, сүлжээний орчинд мэдээлэл солилцох тогтвортой байдал ба аюулгүй байдлыг хангах талаас нь Монгол улсын Үндэсний дата төвөөс “И-коми мап” системийг суурилуулахаар шийдвэрлэж, одоогийн байдлаар системийг суурилуулах ажлыг гүйцэтгэж буй үе шатанд явж байна.

**Үйл ажиллагаа 1.3.4 Гамшгаас хамгаалах Цагаан ном боловсруулах**

Ажлын хэсэг дээр Японы гамшгаас хамгаалах цагаан номын бүтцийг судалж үзээд Монгол улсын Гамшгаас хамгаалах Цагаан номын бүтцийн төслийг боловсруулах ажлыг хэрэгжүүлэв. Уг бүтцийн төсөл дээр үндэслэн Монголын тал нь Гамшгаас хамгаалах Цагаан ном боловсруулах ажлын төлөвлөгөөг боловсруулж ОБЕГ-ын даргаар батлуулсан болно. Уг ажлын төлөвлөгөөнд Цагаан номын бүлэг тус бүрийг хариуцах газар болон мэдээлэл, материал цуглуулах хуваарийг тодорхой тусгаж, хариуцах газрын дарга нарт мэдээлэл, материал цуглуулах тухай чиглэлийн талаарх мэдээлэл хүргэгдэнэ.

### (3) Үр дүн 2

Үйл ажиллагаа 2.1.1. Барилга, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээ хийх зааврыг боловсронгуй болгох санал боловсруулах.

Баригдсан барилгын газар хөдлөлтийн тэсвэржилтийг үнэлэхтэй холбоотой одоо ашиглагдаж буй заавруудын хүндрэл бэрхшээлтэй тал болон түүнийг боловсронгуй болгох саналыг ажлын хэсгийн зүгээс нэгтгэн боловсруулав. Барилгын үнэлгээ хийхтэй холбоотой “Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар” /БД 31-102-00/ болон “Газар хөдлөлтийн бүсэд барьсан барилгын паспортжуулалтын аргачилсан заавар” /БД 31-103-00/-ууд дах хүндрэл бэрхшээлтэй талыг судалсан болно. Дээрх зааврууд нь голчлон барилгын элэгдэл, угсралтын чанар зэргийг харгалзан үзсэн, үнэлгээ хийж буй инженерийн чадвараас хамаарч өөр өөр үр дүн гарч болзошгүй, агуулгын хувьд одоогийн нөхцөл байдлыг тусгаж чадахааргүй болсон зэрэг хүндрэл бэрхшээлүүд тулгарч байна. Боловсронгуй болгох саналын хувьд Японы газар хөдлөлт тэсвэржилтийн нормд үндэслэсэн тоон үзүүлэлтээр илэрхийлэх боломжтой, хялбарчилсан биет судалгааны үр дүнгээс бүтээцийн төрөл тус бүрээр тооцоог хийх боломжтой газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээний аргачлалыг нэвтрүүлэх гэж үзэв.

Инженерийн шугам сүлжээний хувьд “Барилга байгууламж инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм” /БНБД 13-04-03/, МХЕГ-ын эмзэг байдлын эрсдэлийн үнэлгээний тайлан болон хяналтын хуудас зэргийг үндэслэн судлав. Дээрх норм нь агуулгын хувьд ашиглалтын хугацаанд үндэслэн элэгдлийг үнэлэхэд зориулагдсан бөгөөд газар хөдлөлт тэсвэрлэх чадварын үнэлгээг хийхэд зориулагдаагүй байна. Нөгөө талаар Монголын дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнүүд нь их хэмжээний элэгдэлд орсон бөгөөд элэгдлийн түвшин нь газар хөдлөлт тэсвэрлэх чадвартай шууд хамааралтай. Тиймээс

боловсронгуй болгох саналын хувьд /БНБД 13-04-03/-д үндэслэн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтөөс учрах хохирлыг тогтоох нормыг шинээр боловсруулах гэж үзэв.

**Үйл ажиллагаа 2.1.2. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээ хийх аргачлал, тоног төхөөрөмжийн ашиглалтын аргачлалын тухай заавар боловсруулах**

Үйл ажиллагаа 2.1.1-ийн үр дүнд үндэслэн барилга (Төмөр бетон бүтээц, угсармал хавтгаалжин бүтээц, өрөгт бүтээц)-ын болон инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээний аргачлалын үндсэн чиглэл, зарчмыг ажлын хэсэг дээр судалж төслийг боловсруулав.

Боловсруулж буй заавруудыг (Барилга: газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээний норм, инженерийн шугам сүлжээ: газар хөдлөлтийн хохирлыг тооцох норм) норм нормативын бичиг баримт болгохын тулд Барилга хот байгуулалтын яамны норм норматив боловсруулах, хянах, баталгаажуулах шат дарааллаар гүйцэтгэх шаардлагатай. Норм нормативын боловсруулалтыг зөвлөх үйлчилгээний багаар сонгон шалгаруулж гүйцэтгүүлдэг бөгөөд тус багийг сонгон шалгаруулахын өмнө техникийн даалгавар боловсруулах, мэргэжлийн зөвлөлөөр батлуулах шаардлагатай байдаг. Одоогоор ажлын хэсгийн зүгээс техникийн даалгаврыг боловсруулсан, мэргэжлийн зөвлөлийн хурлаар дэмжигдсэн, БХБЯ-ны зөвлөх үйлчилгээний багийн сонгон шалгаруулалтыг хүлээж байгаа нөхцөл байдалд байна. Мөн төслийн Япон талын мэргэжилтнүүдийн зүгээс ажлын хэсгийн гишүүд болон сонгон шалгаруулалтад оролцохоор нэрээ өгөөд байгаа зөвлөх үйлчилгээний байгууллагад зориулж боловсруулах гэж буй барилгын газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээний зарчим, аргачлалын талаар семинар зохион байгуулсан болно. Дээрх нөхцөл байдлыг бодолцож ажлын хэсгээс эдгээр нормуудыг боловсруулахтай холбоотой технологи дамжуулалтын тухай санал солилцсон. Ажлын хэсэг болон зөвлөх үйлчилгээний баг нь нормуудыг хамтран боловсруулах замаар ажлын хэсгийн гишүүдэд технологи дамжуулалтыг хийхээр боллоо.

**Үйл ажиллагаа 2.2.1. Барилга байгууламжийг хүчитгэх, шинэчлэн барих тухай заавар боловсруулах**

Барилгыг хүчитгэх, шинэчлэн барисан жишээ Монголд бараг байхгүй. Тиймээс ажлын хэсгийн гишүүд болон сонгон шалгаруулалтад оролцох зөвлөх үйлчилгээний байгууллагад зориулж Япон талын мэргэжилтнүүдийн зүгээс барилгын хүчитгэлийн зарчим, аргачлалын тухай семинар зохион байгуулсан.

**(4) Үр дүн 3****Үйл ажиллагаа 3.1.1 Цэцэрлэг, сургуулийн гамшгаас хамгаалах суралцахуйн удирдамж боловсруулах**

Төсөл эхлэх үеэр ажлын хэсгээрээ төлөвлөж зөвшилцсөн сургуулийн гамшгаас хамгаалах суралцахуйн удирдамж боловсруулах ажлын явцын төлөвлөгөөний дагуу уг удирдамжийг боловсруулах ажил үргэлжлэн явагдаж байна.

Ажлын хэсэг, Японы сургуулийн гамшгаас хамгаалах боловсролын удирдамж, сургалтын хөтөлбөр болон сурах бичгүүд дэх гамшгаас хамгаалах боловсролын холбогдолтой хэсгүүд, мөн тэдгээр агуулгуудыг заах жишээнүүдийг тус бүр нэг хавтгайд нэгтгэсэн байдлаар цэгцэлсэн материал бэлдлээ. Ажлын хэсгийн гишүүд эдгээр материалаа ашиглан, Монгол улс дахь гамшгаас хамгаалах боловсролын өнөөгийн байдал ямар байгаа талаар судалж нэгтгэн, дутуу, шаардлагатай хэсгүүд юу байгааг тодруулж, сургуулийн гамшгаас хамгаалах боловсролын суралцахуйн удирдамжийн ерөнхий болон нарийвчилсан агуулга ямар байвал зохих талаар судлах ажил хийж байна.

Мөн, БСШУСЯ-ны Боловсролын бодлогын газрын Сургуулийн өмнөх, бага боловсролын хэлтсийн дарга Мягмараас, Япон дахь сургалтад оролцсоноор сургуулийн гамшгаас хамгаалах боловсролын суралцахуйн удирдамжийг боловсруулахын хамтаар түүнийг зааж хүргэх багш нарын заах аргыг төлөвшүүлэх шаардлага, холбогдох байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа чухал шаардлагатай болохыг үзэж мэдсэн талаараа ажлын хэсгийн бусад гишүүдэд танилцуулга хийлээ.

**Үйл ажиллагаа 3.2.1 Төв болон орон нутгийн гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааны ажлын нэгдсэн график төлөвлөгөө боловсруулах**

Янз бүрийн байгууллагуудын хэрэгжүүлж буй гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны ажлыг нэгдмэл байдлаар хянах, тэдгээр байгууллагуудтай энэ талаар мэдээлэл солилцох ажлыг илүү үр дүнтэй болгох зорилгоор Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны цогц төлөвлөгөө (энэ тайлан дотор цаашид “цогц төлөвлөгөө” гэх, 2017 оны 1-2 сарын тайланд Гамшгаас хамгаалах боловсрол, сургалт, сурталчилгааны ажлын нэгдсэн график төлөвлөгөө гэсэн нэрээр оруулж байсан)-г хянаж ажиллуулах бүтэц бий болгох талаар судалж эхлэн, голлох үүрэгтэй оролцох байгууллагуудтай энэ талаар ярилцаж тохиролцох ажлыг эхлүүлсэн. Цогц төлөвлөгөөг ОБЕГ-ын ГУСССХ хянаж, удирдан ажиллуулахаар болсон бөгөөд Вэб сайтын хувьд Монгол улсад энэ чиглэлээр төстэй үйл ажиллагаа явуулж ирсэн

Азийн гамшгийн бэлэн байдлын төв (ADPC)-ийн хийсэн вэб сайтыг тохируулж өөрчлөн ашиглахаар боллоо. Ажлын хэсэг энэхүү зориулалтын вэб сайтыг сайжруулж тохируулах, мэдээлэл солилцох и-мэйл групп үүсгэж ажиллуулах ажлыг үргэлжлүүлэн хийж байна.

**Үйл ажиллагаа 3.2.2 Гамшгаас хамгаалах боловсрол олгох сургалт, сурталчилгааны материал боловсруулж, зорилтот бүлгийн сургалтыг сонгогдсон бус нутагт зохион байгуулах**

Ажлын хэсэг, одоо бэлтгэгдсэн байгаа гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны сургалтын материалуудтай танилцахын тулд НҮБХХ (UNDP), Дэлхийн зөн Монгол байгууллагуудын бэлтгэсэн материалуудын талаар голчлон мэдээлэл цуглуулсан. Үүний үр дүнд, НҮБХХ-ийн сургалтын хөтөлбөр нь ОБЕГ-ын даргын тушаалаар батлагдсан байгаа болон Дэлхийн зөн Монгол байгууллага энэхүү хөтөлбөрт үндэслэн сургалтын материал боловсруулах ажилдаа ороод байгаа талаар олж мэдлээ. Энэ байдлыг харгалзан ажлын хэсэг, тус төслийн үйл ажиллагааны чиглэлийн талаар хэлэлцэж, Дэлхийн зөн Монгол байгууллагатай сургалтын материал боловсруулах ажлыг хэрхэн хувааж хариуцахаа тодорхойлж, НҮБХХ-ийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийн мэдлэг, ойлголтыг сайжруулах сургалтын материал боловсруулах чиглэлээр ажиллахаар боллоо. ОБЕГ-ын ГУСССХ-ээр ахлуулан Дэлхийн зөн Монгол байгууллагатай хамтарч ажиллах үйл ажиллагааны агуулгыг зохицуулах ажил үргэлжлэн явагдаж байна.

**Үйл ажиллагаа 3.2.3 Сургалтын төвд урьдчилан сэргийлэх, гамшгийн нөхцөл байдлыг биеэр мэдрүүлэх сургалт, сурталчилгааны хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах**

НОБГ-ын Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн одоогийн сургалтын хөтөлбөрийн агуулгатай танилцаж, шийдвэрлэвэл зохих асуудлын талаар хэлэлцэх ажлыг эхлүүлээд байна. Цаашид, сургалтын хөтөлбөрийн өнөөгийн байдал, хэрхэн сайжруулах шаардлагатай талаар тайлан гаргахаар тохиролцлоо.

**1-3 Achievement of Output**

**(1) Үр дүн 1**

Төслийн төлөвлөлтийн матрицын дагуу Үр дүн 1-ийн үйл ажиллагааны явцыг үнэлэх доорх 3 шалгуур байна.

**1.1 Боловсруулсан заавар, дүрэм, журмын тоо.**

Хүрсэн үр дүн: Эрсдэлийн үнэлгээний заавар болон Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний зааврын ерөнхий бүтцийг боловсруулж гаргасан ба тоон үзүүлэлт бүхий шалгуураар үнэлгээ хийх үе шатанд хараахан хүрээгүй байна.

1.2 Боловсруулсан санамж бичгийн төслийн тоо, харилцан ажиллагааны санамж бичгийн талаар зохион байгуулагдах сургалтад оролцсон хүний тоо

Хүрсэн үр дүн: “Санамж бичиг боловсруулах гарын авлага”-ыг боловсруулж, харилцаа холбооны салбартай холбоотой санамж бичиг боловсруулах ажил явагдаж эхэлсэн.

1.3 Гамшгаас хамгаалах Цагаан ном

Хүрсэн үр дүн: Цагаан ном боловсруулах ажлын төлөвлөгөөг ОБЕГ-ын даргаар батлуулсан.

**(2) Үр дүн 2**

Төсөл төлөвлөлтийн матрицад үндэслэн үр дүн 2-ын явцыг дараах 2 үзүүлэлтээр дүгнэв.

2.1. Газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээний заавар: Газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээний тухай семинарт оролцогсдын тоо.

Хүрсэн үр дүн: Зааврыг боловсруулж эхэлсэн. Японы газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээний технологийг дамжуулах зорилгоор 2017 оны 4-р сарын 20-ны өдөр семинар зохион байгуулав. Семинарт 25 хүн оролцсон.

2.2. Барилгыг хүчитгэх заавар: Барилгыг хүчитгэх тухай семинарт оролцогсдын тоо.

Хүрсэн үр дүн: Зааврыг боловсруулж эхэлсэн. Японы барилгын хүчитгэлийн технологийг дамжуулах зорилгоор 2017 оны 5-р сарын 3-ны өдөр семинар зохион байгуулав. Семинарт 22 хүн оролцсон.

**(3) Үр дүн 3**

Төслийн төлөвлөлтийн матрицад үндэслэсэн Үр дүн 3-ын ажлын үйл ажиллагааны явцыг үнэлэх доорх 2 шалгуур байна.

3.1 The number of the cases of delivering classes on disaster risk reduction based on the activities of the Project

Achievement in this term: Сургуулийн гамшгаас хамгаалах боловсролын суралцахуйн удирдамж болон сургалтын материал боловсруулах ажил нь эхлэлийн үе шатандаа

явж байгаа ба тоон үзүүлэлт бүхий шалгуураар үнэлгээ хийх үе шатанд хараахан хүрээгүй байна.

### 3.2 The number of visitors in Training Center

Achievement in this term: Удирдамж болон сургалтын материал боловсруулах ажил нь эхний үе шатандаа явж байгаа ба тоон үзүүлэлт бүхий шалгуураар үнэлгээ хийх үе шатанд хараахан хүрээгүй байна.

#### **1-4 Төслийн зорилтод хүрсэн үр дүн**

Төслийн төлөвлөлтийн матрицын дагуу Төслийн үйл ажиллагааны явцыг үнэлэх доорх 2 шалгуур байна.

##### 1. Батлагдсан заавар, санамж бичгийн тоо

##### 2. The number of the data on disaster risk reduction which newly established and improved

Хүрсэн үр дүн: Үр дүн тус бүрийн тухайд одоогийн нөхцөл байдлын задлан шинжилгээн дээр үндэслэн тулгамдаж буй асуудлыг тодорхой болгосны дараа Ажлын хэсэг тус бүр дээрх заавар, санамж бичиг, норм, сургалтын материал зэргийг боловсруулах ажил эхэлсэн байгаа. Төсөл хэрэгжиж дууссаны дараах бие даан хөгжих байдлыг хангахын тулд ОБЕГ болон БХБЯ, БСШУСЯ дээр холбогдох журмын дагуу норм, заавар, удирдамж гэх зэргийг батлуулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

#### **1-5 Changes of Risks and Actions for Mitigation**

##### Үйл ажиллагаа 1.1.2 Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж, төлөвлөлт, төлөвлөгөөний үялдаа холбоог сайжруулах, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгийн мэдээллийн сангийн журам заавар боловсруулах

Төслийн эхлэх үеийн төлөвлөгөөнд Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үе шатанд боловсруулсан Төслийн төлөвлөлтийн матриц (Project Design Matrix)-ын агуулгад үндэслэн Бэлэн байдлын төлөвлөгөөний заавар, Гамшгаас хамгаалах хяналтын заавар боловсруулах ажлыг Үйл ажиллагаа 1.1.2-т төлөвлөж байсан болно. Гэвч, 1-2-т дурдсанчлан Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсаны дараа дээрх 2 журам заавартай холбоотой хуулийн зүйл заалтын агуулгад өөрчлөлт орж, журам зааврын хувьд ямар хамааралтай байх болон тухайн агуулгын тухайд өөрчлөлт хийх шаардлагатай болж

байна. Өөрчлөлт хийх тохиолдолд, Төслийн төлөвлөлтийн матриц дахь дараахь агуулга болох:

*Note: 1-1) Amended Law of Disaster Protection "8.2 Rules of risk evaluation", "9.3 Guidelines and methodologies to develop disaster management plan", "12.1 Guidelines for preparation system", and "13.2 Rules and regulations of disaster management", and etc..гэх зэрэг агуулгад өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг нягталж тодорхой болгоно.*

**Үйл ажиллагаа 1.3.1 Улс болон орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй холбоотой асуудлыг тодорхойлох, үг төлөвлөгөөг сайжруулан шинэчлэх**

Ажлын хэсэг 1-ийн Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн сайжруулах ажлын хүрээнд туршилтын орон нутаг болох 2 аймгийг сонгон авахаар төлөвлөж байгаа боловч одоогоор тодорхойгүй байна. Үүний тухайд Ажлын хэсэг дээр санал солилцож Удирдах хороо болон ХЗХ-ны хурлаар батлуулах төлөвлөгөөтэй байна.

**Үйл ажиллагаа 2.2.1. Барилга байгууламжийг хүчитгэх, шинэчлэн барих тухай заавар боловсруулах**

Барилгын газар хөдлөлтийг нэмэгдүүлж хүчитгэсэн жишээ Монголд байхгүй тул хүчитгэх, шинэчлэн барих тухай заавар боловсруулахад жишээ болгох зорилгоор тодорхой барилгыг сонговол үр дүнтэй. Үүний тулд үйл ажиллагаа 2.2.2 болох “Орон сууц, цэцэрлэг, сургууль, эмнэлэг, төрийн байгууллагуудаас тус бүр 1 барилгыг шинэчлэн барих, хүчитгэх ажлын загвар зураг төсөл боловсруулах” ажлыг төлөвлөгөөт хугацаанаас урагшлуулахаар судалж байна.

**Үйл ажиллагаа 3.2.2 Гамшгаас хамгаалах боловсрол олгох сургалт, сурталчилгааны материал боловсруулж, зорилтот бүлгийн сургалтыг сонгогдсон бүс нутагт зохион байгуулах**

Иргэдэд чиглэсэн гамшгаас хамгаалах сургалт явуулах туршилтын бүс нутгаар, Улаанбаатар хотын төвийн бүс, гэр хороолол, хөдөө орон нутаг гэсэн 3 газраас сонгохоор төлөвлөж байгаа ба одоогоор нарийвчилсан байдлаар сонгох үе шатандаа ороогүй байна. Ажлын хэсгээс санал гаргаж, Удирдах хороо болон ХЗХ-р батлуулна.

**1-6 Progress of Actions undertaken by JICA**

N/A



## **1-7 Progress of Actions undertaken by Gov. of Mongolia**

### **(1) Үр дүн 1**

Уг төслийн хүрээнд боловсруулах Бэлэн байдлын төлөвлөгөөний зааврыг Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний зааврын нэг хэсэг болгон нэгтгэж оруулах шаардлагатай эсэх талаар Монголын талтай болон ХЗХ-ны хурлаар хэлэлцэнэ.

Үйл ажиллагаа 1.3.1-ийн туршилтын бүс нутгийн хувьд, ОБЕГ-аас Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг, Хэнтий аймгийг санал болгосон. Уг саналыг ХЗХ-ны хурлаар хэлэлцэнэ.

### **(2) Үр дүн 2**

ОБЕГ болон БХБЯ, Барилгын хөгжлийн төвөөс Монголын Барилгын инженерүүдийн холбоо гэх мэт зөвлөх үйлчилгээний багийг сонгон шалгаруулахад шаардлагатай Теникийн даалгаврыг боловсруулсан болно. Мөн, Үйл ажиллагаа 2.2.2-ыг төлөвлөгөөт хугацаанаас өмнө эхлүүлэхээр төлөвлөж байна.

## **1-8 Progress of Environmental and Social Considerations (if applicable)**

N/A

## **1-9 Progress of Considerations on Gender/Peace Building/Poverty Reduction (if applicable)**

N/A

## **1-10 Other remarkable/considerable issues related/affect to the project (such as other JICA's projects, activities of counterparts, other donors, private sectors, NGOs etc.)**

Үр дүн 2: Дэлхийн банкнаас Улаанбаатар хотын сургуулийн барилгуудыг үнэлэх, хүчитгэхтэй холбоотой төсөл хэрэгжиж байгаа. Үр дүн 2-ын үйл ажиллагаатай хамааралтай тул холбогдох мэдээллүүдийг тогтмол цуглуулахын зэрэгцээ Дэлхийн банкны төслийн үр дүнг боловсруулах нормын ашиглах материал болгож ишлэлд ашиглана.

Үр дүн 3: БСШУСЯ нь Дэлхийн зөн Монгол зэрэг байгууллагуудтай хамтран, Сургуулийн гамшгаас хамгаалах боловсролын холбоотой үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын мэдээлэл солилцох платформ байгуулахаар ажиллаж байна. Мэдээлэл солилцох зорилгоор ЖАЙКА-н мэргэжилтний баг ажиглагчийн үүрэгтэйгээр оролцох боломжийг судалж байна.

Үр дүн 3: Иргэдэд зориулсан гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны материал боловсруулах чиглэлээр Дэлхийн зөн Монгол байгууллага ижил төстэй үйл ажиллагаа явуулж байгааг олж мэдлээ. Гамшгийн төрөл тус бүрээр сургалт, сурталчилгааны материал боловсруулах ажлаас нэг хэсгийг авч хийх боломжийг судалж, ОБЕГ-ын хамтаар цаашид үргэлжлүүлэн хамтарч ажиллана.

## **2. Ажлын төлөвлөгөө хойшлогдох бөгөөд/эсвэл асуудал үүсэх тохиолдолд**

### **2-1 Агуулга**

Ажлын хэсгийн гишүүд ажил ихтэй байхаас шалтгаалан Японы мэргэжилтнүүд томилолтоор ирж ажиллах үед Ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулах боломжгүй болж хойшлогдох, Монголын талын хариуцаж буй мэргэжилтнүүдийн ажил хоцрох эрсдэл гарч эхэлж байна.

### **2-2 Шалтгаан**

Өөрийн харьяагдаж байгаа газар хэлтсийн ажлын нөхцөл байдал, арга хэмжээ зохион байгуулагдах, бусад хандивлагч улс орнуудын зохион байгуулж буй гадаад дахь сургалтад оролцох зэрэг.

### **2-3 Шийдэл арга хэмжээ**

ЖАЙКА мэргэжилтний багаас Монголын талын гишүүдийн харьяагдаж буй байгууллага, газар хэлтсийн удирдах албан тушаалтанд уг төслийн үйл ажиллагааны ач холбогдол, төсөл хамтран хэрэгжүүлж буй байгууллагад гарах үр өгөөжийн талаар харилцан ойлголцлыг бий болгохын зэрэгцээ зохион байгуулагдах үйл ажиллагаа, арга хэмжээний талаар урьдчилан мэдээлэл солилцох. Төсөлд оролцож байгаа Монголын талын гишүүдийн үйл ажиллагааны нөхцөл байдал, хариуцаж буй ажлын явцыг тогтмол дүгнэлт хийж нягтлах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

### **2-4 Roles of Responsible Persons/Organization (JICA, Gov. of Mongolia, etc.)**

N/A

## **3. Modification of the Project Implementation Plan**

### **3-1 PO**

N/A

### 3-2 Other modifications on detailed implementation plan

(Remarks: The amendment of R/D and PDM (title of the project, duration, project site(s), target group(s), implementation structure, overall goal, project purpose, outputs, activities, and input) should be authorized by JICA HDQs. If the project team deems it necessary to modify any part of R/D and PDM, the team may propose the draft.)

N/A

### 4. Төсөл хэрэгжиж дууссаны дараа Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлэх бэлтгэл ажил (Preparation of Gov. of Mongolia toward after completion of the Project)

Уг тайлант хугацаанд одоогийн байдлаар тодорхой үйл ажиллагаа, тухайн чиглэлийн талаар хэлэлцүүлэг хийгдээгүй байна.

## II. Project Monitoring Sheet I & II *as Attached*

**Project Monitoring Sheet I (Version.2 as of May 31, 2017)**

**Version 2**  
**Dated June 29, 2017**

**Project Title: Project for Strengthening the National Capacity of Earthquake Disaster Protection and Prevention in Mongolia**

**Implementing Agency: National Emergency Management Agency (NEMA)**

**Target Group: NEMA, Ministry of Construction and Urban Development, Ministry of Education, Culture and Science, General State Inspection Agency, Emergency Management Department of the Capital City (EMDC), Construction Quality and Safety Department, Master Planning Agency of Capital City**

**Period of Project: December 2016 to November 2019**

**Project Site: Mongolia**

Narrative Summary	Objectively Verifiable Indicators	Means of Verification	Important Assumption	Achievement	Remarks
<p><b>Overall Goal</b> Seismic risk will be reduced.</p>	<ol style="list-style-type: none"> <li>Number of the approved guideline, rules, provisions</li> <li>Number of white paper open to public</li> <li>Number of the executed seismic assessment</li> <li>Number of the seismic strengthened building</li> <li>Number of implemented activities on disaster risk reduction education</li> </ol>	<p>Study by NEMA</p>	<p>The policy on disaster risk reduction will not be changed in Mongolia.</p>		
<p><b>Project Purpose</b> The Capacity of National Emergency Management Agency will be enhanced through the activities for strengthening the countermeasures for seismic risk.</p>	<ol style="list-style-type: none"> <li>The number of the approved guidelines and agreement</li> <li>The number of the data on disaster risk reduction which newly established and improved</li> </ol>	<p>Project report</p>	<p>NEMA expands the pilot activities in other aimags and sums.</p>	<p>After grasping the issues and challenges of the current status of legal frameworks of DRR in Mongolia for each Output, development of guidelines, agreements, standards of seismic diagnosis and strengthening, teaching materials has been just started at each WG.</p>	<p>In order to ensure sustainability after the Project, each WG makes it a goal to get an approval of guidelines and other related outputs which will be developed in the Project from NEMA, MUCD or MECSS through their standard procedures.</p>
<p><b>Outputs</b> 1. Capacity for data collection on disaster risk reduction and coordination among related organizations will be enhanced.  2. Capacity of public administration officer related with the seismic assessment and seismic strengthening for buildings will be enhanced.</p>	<ol style="list-style-type: none"> <li>The number of guidelines, operational rules, provisions which are developed.                             <ol style="list-style-type: none"> <li>The number of the draft of agreement, developed and participants who participated in the training programs on agreements</li> <li>White paper on disaster risk reduction</li> </ol> </li> <li>Guideline for seismic assessment The number of the participants in the training program on seismic assessment</li> <li>Guideline for seismic strengthening The number of the training program on seismic strengthening</li> </ol>	<p>Project report</p>	<ol style="list-style-type: none"> <li>The counterparts from NEMA, the Ministry of Construction and Urban Development and the Ministry of Education continue to work in the same position.</li> <li>Participants in training programs continue to work in the same position.</li> <li>The relation among related organizations is maintained.</li> <li>Exchange information is maintained among the related organizations.</li> </ol>	<p>The WG1 has just created the basic frameworks of the guideline of risk assessment and the guideline of disaster management plan. The WG1 has created the draft manual of agreement preparation procedure and started to create an agreement on the field of information and communication. The WG1 has gotten an approval of the work plan to prepare the white paper from Head of NEMA.  The WG2 has just started to develop the guideline for seismic assessment. For the purpose of technical transfer of seismic diagnosis in Japan, the first seminar was held on April 20th, 2017. There are 25 attendees at this seminar. The WG2 has just started to develop the guideline for seismic strengthening. For the purpose of technical transfer of seismic strengthening in Japan, the first seminar was held on May 3rd, 2017. There are 22 attendees at this seminar.</p>	
<p>3. Implementing plan on disaster risk reduction education and awareness raising activities will be developed and realized.</p>	<ol style="list-style-type: none"> <li>The number of the cases of delivering classes on disaster risk reduction based on the activities of the Project</li> <li>The number of visits in Training Center</li> </ol>	<p>Ordinance of Ministry of Education, Culture and Science  Ordinance of NEMA</p>		<p>The WG3 has just started to prepare the guidelines and teaching materials for DRR education and raising awareness.</p>	

Activities	Inputs	Important Assumption
<p>1.1.1 To identify problems and challenges on implementation of legal frameworks of disaster risk reduction</p> <p>1.1.2 To develop guidelines on improvement of legal frameworks and plans, assessment of disaster risk and database on disaster risk reduction</p> <p>1.1.3 To develop new regulation and the drafts(note 1-1)) of revised version of regulation on implementation of Law of disaster protection</p> <p>1.2.1 To develop the draft of the agreement (note 1-2)) which shows the coordination and cooperation among NEMA and related organizations</p> <p>1.2.2 To realize training programs for disseminating the agreement mentioned in 1.2.1 and strengthening the coordination structure among organizations related with disaster risk reduction</p> <p>1.3.1 To identify problems and challenge of monitoring, report, evaluation and disclosure of disaster protection plan at national and local levels (note 1-3))</p> <p>1.3.2 To revise these plans and make a manual for the revision of disaster protection plan</p> <p>1.3.3 To improve the present system (note 1-4)) which collect and analyze information on disaster risk reduction</p> <p>1.3.4 To develop white paper on disaster risk reduction which let the Mongolian people know the progress on implementation, monitoring, evaluation of disaster risk reduction plan at national and local levels through the activities of 1.3.1 to 1.3.3</p> <p>1.3.5 To improve the system of database on seismic strength of buildings, infrastructure and lifeline (note 1-5))</p>	<p><b>The Mongolian Side</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Assignment of counterparts</li> <li>- Project Director</li> <li>- Project Managers</li> <li>- Project Coordinator</li> <li>- Project Members</li> </ul> <p>For Output 1</p> <ul style="list-style-type: none"> <li>- Policy Coordination and Cooperation Department, NEMA</li> <li>- Disaster Operational Department, NEMA</li> <li>- Disaster Prevention Department, NEMA</li> <li>- Disaster Research Institute, NEMA</li> <li>- Emergency Management Department of Capital City (EMDC)</li> </ul> <p>Provision of Equipment</p> <ul style="list-style-type: none"> <li>- Equipment for seismic assessment</li> <li>- Earthquake simulation experience equipment for Training Center such as shaking table</li> </ul> <p>Training in Japan and/or the third countries</p>	<p><b>The Japanese Side</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Dispatch of Experts</li> <li>- Leader</li> <li>- Disaster Risk Management</li> <li>- Disaster Risk Reduction Framework</li> <li>- Disaster Risk Reduction Information</li> <li>- Seismic Strengthening Assessment</li> <li>- Seismic Strengthening Method</li> <li>- Seismic Strengthening Design</li> <li>- Disaster Risk Reduction Education</li> <li>- Disaster Risk Reduction at Community Level</li> <li>- Educational Material Development</li> </ul>
<p>2.1.1 To analyze the manual of seismic assessment of buildings and lifeline (note 2-1)) based on the context of the Law of Disaster Protection and develop the draft of revised version</p> <p>2.1.2 To develop guidelines-methodologies (note 2-2)) which show the method for implementing seismic assessment for buildings and lifelines, and how to use equipment</p> <p>2.1.3 To implement training programs (note 2-3)) for enhancing the knowledge and capacity of experts who assess the seismic strength of buildings and lifeline</p> <p>2.2.1 To develop guidelines-methodologies on seismic strengthening and reconstruction of buildings</p> <p>2.2.2 To support the introduction and dissemination of seismic strengthening techniques for reconstructing collective housing, kindergarten, schools, hospital, national buildings and design the reconstruction and seismic strengthening of each type of buildings a pilot</p> <p>2.2.3 To realize training programs with the participation of NEMA for enhancing knowledge and capacity of the experts who implement seismic strengthening of buildings</p>	<p>For Output 2</p> <ul style="list-style-type: none"> <li>- Disaster Operational Department, NEMA</li> <li>- Disaster Prevention Department, NEMA</li> <li>- Ministry of Construction and Urban Development</li> <li>- Master Planning Agency of Capital City</li> <li>- General State Inspection Agency</li> </ul>	<p><b>Pre-Conditions</b></p>



<p>3.1.1 To develop a guideline which shows contents, method and implementation way of disaster risk reduction education in kindergaten and schools based on Law of Disaster Protection</p> <p>3.1.2 To develop textbooks, supplementary readers and educational materials related with disaster risk reduction education in kindergaten and primary and secondary schools</p> <p>3.1.3 To implement training programs for the instructors (note 3-1)) of Teacher Training Institutes and experts of educational department in local governments, using the guideline and materials developed in 3.1.1 and 3.1.2 respectively</p> <p>3.1.4 To implement the training program for teachers by the instructors and experts who received the training programs mentioned in 3.1.3</p> <p>3.2.1 To develop comprehensive work plan (note 3-2)) for disaster risk reduction education and raising awareness at national and local levels</p> <p>3.2.2 To develop materials for the training on disaster risk reduction education and raising awareness, and implement the training for the target groups (note 3-3)) in pilot areas</p> <p>3.2.3 To develop and implement educational and training program for implementing disaster prevention and simulation program in Training Center</p>	<p>For Output 3</p> <ul style="list-style-type: none"> <li>- Disaster Prevention Department, NEMA</li> <li>- Ministry of Education, Culture and Science</li> <li>- Teacher Training Institute</li> <li>- Educational Research Institute</li> <li>- Emergency Management Department at aimag level</li> </ul>	<p>&lt;Issues and countermeasures&gt;</p> <p>The delay of each WG activity is concerned due to the busy schedule of WG members. The WG meetings were sometimes postponed by concentration of works and events which Mongolian side C/P has to deal with for each organization.</p> <p>The JET explains the significance of the activities in the Project and effects of the output at each organization to supervisors of each Mongolian side C/P continuously in order to get their understanding of the Project. And also the JET requests the sharing of event schedule adequately.</p>
--	--	--

Notes

- 1-1) Amended Law of Disaster Protection "8.2 Rules of risk evaluation", "9.3 Guidelines and methodologies to develop disaster management plan", "12.1 Guidelines for preparation system", and "13.2 Rules and regulations of disaster management", and etc..
- 1-2) Contracts, cooperation plan and MoU are equivalent to agreement mentioned in the PDM
- 1-3) National level, UB city and two provinces are the target areas
- 1-4) Improvement of existing "Disaster Information Sharing System"
- 1-5) Improve existing database for sharing with related agencies (Components of the database system of UB city are under investigation)
- 2-1) Buildings: Buildings, Road and Bridge Lifeline: Warm water pipeline, Water supply and sewerage, electric transmission and distribution facilities
- 2-2) Guidelines are regarded as operational guidelines by Resolution of Minister
- 2-3) Target: Ministry of Construction and Urban Development, Ministry of Education, Culture and Science, UB city, General State Inspection Agency, province level officers in charge of buildings, infrastructure and lifeline, association of architects, association of design engineers etc.
- 3-1) Instructors of Institute of Teacher's Professional Development, experts of training departments of provinces and cities, and certificated teacher's instructors
- 3-2) A document to clarify the targets, implementers and instructors of public education and training, and the contents of required education and training activities for the purpose of ensuring of nationwide implementation of education and training program to all the necessary target stakeholders
- 3-3) Target groups: (1) Staff of NEMA Disaster Prevention Department/ Emergency Operation Department, Training Center, and Emergency Management Departments of Cities, Provinces, and Districts, (2) Members in charge of disaster prevention in Disaster Protection Services at National, Province and City levels, (3) Heads of governor's offices of Provinces, Soms, and Districts (4) Heads of Bags and Khoroos, (5) Coordinators of civil activities in Provinces, Districts, and Khoroos and (6\*) Volunteers (\*only in pilot areas)
- 3-4) The facility that the EMDC is constructing and preparing for providing DRR training and education to the citizens in Khan Uul district in UB city.









Activity	Start	End	Progress	Responsible Party	Status	Remarks
2.2.2.1 To support the introduction and dissemination of seismic strengthening techniques for reconstructing collective housing, kindergarten, schools, hospital, national buildings and design the reconstruction and seismic strengthening of each type of buildings a study design.					Plan	
2.2.2.2 To design of rebuilding and strengthening on target buildings					Actual	
2.2.3 To realize training programs with the participation of the target beneficiaries and capacity of the experts who implement seismic strengthening of buildings					Plan	
2.2.3.1 To plan training program					Actual	
2.2.3.2 To implement training program					Plan	
2.2.3.2 To implement training program					Actual	
<b>Output 3:</b>						
3.1.1 To develop a guideline which shows contents, method and implementation way of disaster risk reduction (DRR) education in kindergarten and primary and secondary schools based on Law of Disaster Prevention					Plan	
3.1.1.1 To review current situation of DRR education in kindergarten and primary and secondary schools comparing with Japanese practices					Actual	
3.1.1.2 To develop the guideline through the analysis of the SDRR-DRR Education Working Group (WG)					Plan	
3.1.1.2 To develop the guideline through the analysis of the SDRR-DRR Education Working Group (WG)					Actual	
3.1.2 To develop educational materials such as textbooks and supplementary readers for DRR education in kindergarten, primary and secondary schools					Plan	
3.1.2.1 To collect and review existing educational materials through the WG activities					Actual	
3.1.2.2 To establish Task Forces for the development of the educational materials through the WG activities					Plan	
3.1.2.2 To establish Task Forces for the development of the educational materials through the WG activities					Actual	
3.1.2.3 To organize workshops and discuss and decide the contents of educational materials to be developed					Plan	
3.1.2.3 To organize workshops and discuss and decide the contents of educational materials to be developed					Actual	
3.1.2.4 To develop and finalize the educational materials through the Task Forces and the WG activities					Plan	
3.1.2.4 To develop and finalize the educational materials through the Task Forces and the WG activities					Actual	
3.1.3 To implement training programs for the instructors of Teacher-Training Institutes and experts of educational institutions and professionals developed in 3.1.1 and 3.1.2 respectively					Plan	
3.1.3.1 To formulate the training programs through workshops and the WG activities					Actual	
3.1.3.2 To implement pilot training					Plan	
3.1.3.2 To implement pilot training					Actual	
3.1.3.3 To review the training and formulate training manuals					Plan	
3.1.3.3 To review the training and formulate training manuals					Actual	
3.1.4 To implement the training program for teachers by the instructors and experts who received the training programs mentioned in 3.1.3					Plan	
3.1.4.1 To support the training for teachers					Actual	
3.1.4.2 To review the result of the training of 3.1.3 and 3.1.4 through workshops and the WG activities and complete lessons learnt					Plan	
3.1.4.2 To review the result of the training of 3.1.3 and 3.1.4 through workshops and the WG activities and complete lessons learnt					Actual	

Activity	Status	Remarks	2017				2018				2019				2020					
			Q1	Q2	Q3	Q4	Q1	Q2	Q3	Q4	Q1	Q2	Q3	Q4	Q1	Q2	Q3	Q4		
3.2.1 To develop comprehensive work plan for disaster risk reduction education and raising awareness at national and local levels	Plan																			
3.2.1.1 To interview related organizations about coordination and cooperation	Actual	Δ Δ Δ Δ																		
3.2.1.2 To examine framework for NEMA to conduct integrated management	Plan																			
3.2.1.3 To implement regular meetings	Actual	Δ Δ Δ Δ																		
3.2.1.4 To create a website for the information among the relevant organizations	Plan																			
3.2.2 To develop materials for the training on disaster risk reduction education and raising awareness among the relevant organizations	Actual	Δ Δ Δ Δ																		
3.2.2.1 To review existing textbooks of DRR education for communities	Plan																			
3.2.2.2 To discuss and develop training materials	Actual	Δ Δ Δ Δ																		
3.2.2.3 To implement Training of Trainers workshop	Plan																			
3.2.2.4 To implement workshops in the pilot area	Actual	Δ Δ Δ Δ																		
3.2.3 To develop and implement educational and training program for implementing disaster education and simulation program in Training Center	Plan																			
3.2.3.1 To examine and consider a study program for the training center	Actual	Δ Δ Δ Δ																		
3.2.3.2 To examine materials and equipment for improvement of training center	Plan																			
3.2.3.3 To support procurement of equipment	Actual	Δ Δ Δ Δ																		
3.2.3.4 To develop educational materials such as movie, exhibition, etc.	Plan																			
3.2.3.5 To operate training program	Actual	Δ Δ Δ Δ																		
3.2.3.6 To examine expansion to other regions	Plan																			
	Actual	Δ Δ Δ Δ																		

Activity	Status	Remarks	2017				2018				2019				2020						
			Q1	Q2	Q3	Q4	Q1	Q2	Q3	Q4	Q1	Q2	Q3	Q4	Q1	Q2	Q3	Q4			
Duration / Phasing	Plan																				
Actual	Actual																				
Monitoring Plan	Year																				
Monitoring	Actual																				
Joint Coordinating Committee	Plan																				
Set-up the Detailed Plan of Operation	Actual																				
Submission of Monitoring Sheet	Plan																				
Report Documents	Actual																				
Work Plan / Project Interim Report	Plan																				
Project Completion Report	Actual																				
Public Relations	Plan																				
	Actual																				
	Plan																				
	Actual																				

**ЖАЙКА-гийн Монгол дахь төлөөлөгчийн газрын даргад****ТӨСЛИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС****Төслийн нэр : Монгол Улсын Газар Хөдлөлтийн Гамшгаас Хамгаалах****Чадавхийг Бэхжүүлэх Төсөл****Хяналтын хуудсын хувилбар: Ver. 3.0****(Хугацаа: 2017 оны 6-р сар - 2017 оны 11-р сар)****Нэр: Д. Батсайхан****Албан тушаал: ОБЕГ-ын Гамшгаас  
урьдчилан сэргийлэх газрын дарга****Нэр: Киётака Овада****Албан тушаал: Багийн ахлагч /  
Нэгдсэн гамшгийн удирдлага I****Хүлээлгэж өгөх өдөр:****2017 оны 12-р сарын ХХ****I. Тойм****1. Төслийн үйл ажиллагааны явц****1-1 Төсөл хэрэгжүүлэх зохион байгуулалтын явц****(1) Мэргэжилтнүүдийн томилгоо**

Энэхүү хяналтын хугацаанд Японы талаас дараах мэргэжилтнүүдийг томилов.

	Хариуцсан үйл ажиллагаа	Нэр	Томилгооны хугацаа
Төслийн удирдлагын баг	Багийн ахлагч / Гамшгийн нэгдсэн удирдлага 1	Киётака ОВАДА	14/06/2017 – 09/07/2017 04/09/2017 – 03/10/2017 22/11/2017 – 30/11/2017
	Багийн дэд ахлагч / Гамшгийн нэгдсэн удирдлага 2	Акихиро ФҮРҮТА	01/06/2017 – 17/06/2017 30/10/2017 – 25/11/2017
Үр дүн 1: Гамшгаас хамгаалах төлөвлөгөө/ засаглал	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө 1	Осаму НИШИИ	12/06/2017 – 01/07/2017 30/10/2017 – 11/11/2017
	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө 2	Кэнсүкэ ИЧИКАВА	10/09/2017 – 10/10/2017
	Гамшгаас хамгаалах тогтолцоо 1	Ёшитака ЯМАЗАКИ	31/08/2017 – 19/09/2017
	Гамшгаас хамгаалах тогтолцоо 2	Широ МАКИТА	08/06/2017 – 23/06/2017
	Гамшгаас хамгаалах мэдээлэл 1	Тадаши ИСЭ	05/06/2017 – 14/06/2017
	Гамшгаас хамгаалах мэдээлэл 2	Акихиро ФҮРҮТА	—
Үр дүн 2: Барилгын	Газар хөдлөлтийн тэсвэржилт	Сэйичиро ФҮКҮШИМА	13/06/2017 – 01/07/2017 29/11/2017 – 30/11/2017

	Хариуцсан үйл ажиллагаа	Нэр	Томилгооны хугацаа
газар хөдлөлтийн тэсвэржилт	Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний тэсвэржилтийн үнэлгээ	Жүн МАТЦҮО	01/06/2017 – 22/06/2017 23/10/2017 – 11/11/2017
	Барилгын тэсвэржилтийн үнэлгээ / Барилгын хүчитгэлийн зураг төсөл 1 (Төмөр бетон, Угсармал)	Масахидэ АОКИ	24/08/2017 – 12/09/2017
	Барилгын тэсвэржилтийн үнэлгээ / Барилгын хүчитгэлийн зураг төсөл 2 (өрөгт бүтээц)	Шигэки КИТА	30/10/2017 – 08/11/2017
	Газар хөдлөлт тэсвэржилтийн зураг төсөл	Хидэто ОМИНЭ	13/08/2017 – 30/08/2017
Үр дүн 3: Гамшгаас хамгаалах боловсрол	Гамшгаас хамгаалах боловсрол 1	Мики КОДАМА	10/09/2017 – 23/09/2017 16/11/2017 – 29/11/2017
	Гамшгаас хамгаалах боловсрол 2	Юүжиро ОГАВА	11/06/2017 – 23/06/2017 27/11/2017 – 30/11/2017
	Орон нутгийн гамшгаас хамгаалах боловсрол / Төслийн зохицуулалт 1	Тошиказү ХИВАКИ	13/06/2017 – 02/07/2017 22/11/2017 – 30/11/2017
	Гамшгаас хамгаалах сургалтын материал боловсруулах 1	Ёоко ОТА	07/08/2017 – 18/08/2017
	Гамшгаас хамгаалах сургалтын материал боловсруулах 2 / Төслийн зохицуулалт 2	Амаржаргал НАЯНБААТАР	13/06/2017 – 29/06/2017 08/08/2017 – 16/08/2017 14/09/2017 – 28/09/2017 17/11/2017 – 28/11/2017 * Эдгээр хугацаануудад тохиолдлын чанартай бусад ажил нэмэгдэж болно

## (2) Төсөл хамтран хэрэгжүүлэгч талын томилгоо

Монгол Улсын Газар Хөдлөлтийн Гамшгаас Хамгаалах Чадавхийг Бэхжүүлэх Төслийн (цаашид "Төсөл" гэх) одоогийн удирдлагын баг нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

(а) Төслийн захирал:

Д.Батсайхан, ОБЕГ-ын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын дарга

(б) Төслийн менежер:

Л.Өлзийбаяр, ОБЕГ-ын Бодлого зохицуулалт, хамтын ажиллагааны газрын дарга

(в) Төслийн зохицуулагчид:

З.Баттулга, ОБЕГ-ын Гамшгийн шуурхай удирдлагын газар

А.Энхбат, ОБЕГ-ын Бодлого зохицуулалт, хамтын ажиллагааны газар

ОБЕГ-ын дотоод бүтцийн өөрчлөлтийн улмаас Төслийн удирдагч болон Төслийн зохицуулагч нар өөрчлөгдсөн болно. Шинээр томилогдсон ОБЕГ-ын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын дарга Д.Батсайхан нь ОБЕГ-ын дэд даргаар

томилогдсон Б.Ууганбаярын оронд Төслийн удирдагчаар томилогдов. ОБЕГ-ын Бодлого зохицуулалт, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн А.Энхбат нь Гамшгийн эрсдэлийн удирдлагын газарт томилогдсон ахлах мэргэжилтэн Д.Базаррагчаагийн оронд Төслийн зохицуулагчаар томилогдов.

Хэлэлцүүлгийн тэмдэглэлд (цаашид "Х/Т" гэх) заасны дагуу Монголын талаас төслийг хамтран хэрэгжүүлж буй (цаашид "Х/Х" гэх) тал нь төслийн үйл ажиллагааг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхийн тулд ажлын хэсгүүдийг (цаашид "А/Х" гэх) зохион байгуулж ажиллана.

Төслийг хамтран хэрэгжүүлж буй талын А/Х-ийн гишүүдийн жагсаалтыг 2017 оны 4-р сарын 14-ний өдөр зохион байгуулагдсан Хамтарсан зохицуулах хорооны (цаашид "ХЗХ" гэх) 2-р хурлаар баталсан бөгөөд 2017 оны 6-р сарын 29-ний өдөр зохион байгуулагдсан ХЗХ-ны 3-р хурал болон 2017 оны 9-р сарын 28-ны өдөр зохион байгуулагдсан Удирдах хорооны (цаашид "У/Х" гэх) 4-р хурлын үеэр шинэчлэн батлав. 11-р сарын эцсийн байдлаар А/Х-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлт орохоор төлөвлөгдөж байна. Үүнд:

(а) А/Х 1-ийн дэд А/Х-үүдийн гишүүд (2017 оны 11-р сарын байдлаар)

Дэд А/Х	Нэр	Албан тушаал	А/Х-ны гишүүнээр томилогдож А/Х-ийн хүрээнд ажил гүйцэтгэсэн хугацаа		
			3-р ХЗХ 2017 оны 6-р сар	4-р ХЗХ 2017 оны 9-р сар	5-р ХЗХ 2017 оны 11-р сар
А/Х 1-ийн зохицуулагч	Д. Базаррагчаа	ГЭУГ, ОБЕГ	○	○	○
Гамшгийн эрсдэлийн үнэлгээ	Д. Сэржмядаг	ГСХ, ОБЕГ	○	○	○
	П. Амарзаяа	ГСХ, ОБЕГ	○	○	○
	Д. Базаррагчаа	ГЭУГ, ОБЕГ	○	○	○
	Б. Батбаяр	ГЭУГ, ОБЕГ	○	○	○
	Б. Хишигбаатар	ГШУГ, ОБЕГ			○
Гамшгаас хамгаалах төлөвлөгөө	С. Базаррагчаа	ГСХ, ОБЕГ			○
	Б. Баянмөнх	БЗХАГ, ОБЕГ	○	○	○
	Б. Мягмардорж	ГШУГ, ОБЕГ	○	○	○
	Т. Төрбилэг	ГШУГ, ОБЕГ		○	○
	Ч. Отгонтөгс	ГТТГ, ОБЕГ	○	○	○
	Э. Батбаяр	НОБГ	○	○	○
Санамж бичиг	А. Дашням	НОБГ	○	○	○
	Б. Дөвшин	ГЭУГ, ОБЕГ	○	○	○
Цагаан ном	Э. Алтанхишиг	БЗХАГ, ОБЕГ	○		
	О. Цэнд-Аюуш	ГУСГ, ОБЕГ		○	○
Гамшгаас	Б. Пүрэвням	ГШУГЗМТөв, ОБЕГ	○	○	○

Хяналтын хуудсын тайлан

Дэд А/Х	Нэр	Албан тушаал	А/Х-ны гишүүнээр томилогдож А/Х-ийн хүрээнд ажил гүйцэтгэсэн хугацаа		
			3-р ХЗХ 2017 оны 6-р сар	4-р ХЗХ 2017 оны 9-р сар	5-р ХЗХ 2017 оны 11-р сар
хамгаалах мэдээллийн сан	Д. Бадамсүрэн	ГСХ, ОБЕГ	○	○	
	Д. Содномрагчаа	ГСХ, ОБЕГ	○	○	○
	Б. Болдхүү	ГШУГЗМТөв, ОБЕГ	○	○	○
	Д. Баярбаатар	ГШУГЗМТөв, ОБЕГ			○

(б) А/Х 2-ын дэд А/Х-үүдийн гишүүд (2017 оны 11-р сарын байдлаар)

Дэд А/Х	Нэр	Албан тушаал	А/Х-ны гишүүнээр томилогдож А/Х-ийн хүрээнд ажил гүйцэтгэсэн хугацаа		
			3-р ХЗХ 2017 оны 6-р сар	4-р ХЗХ 2017 оны 9-р сар	5-р ХЗХ 2017 оны 11-р сар
А/Х 2-ийн зохицуулагч	Д. Занабазар	Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ)	○		
	Б. Соёмбоо	БХБЯ			○
	З. Баттулга	ГШУГ, ОБЕГ	○	○	○
Барилга байгууламжийн газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээ	Д. Занабазар	БХБЯ	○		
	Б. Соёмбоо	БХБЯ			○
	Г. Эрхэмбаяр	БХБЯ	○	○	○
	Б. Гантулга	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, БХБЯ	○	○	○
	Ш. Уранчимэг	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар (МХЕГ)	○	○	○
	Н. Ганчимэг	МХЕГ	○	○	○
	Б. Цэнд-Аюуш	Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар	○	○	○
	Ц. Хулан	Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар	○	○	○
	Г. Саруултуяа	Барилга хөгжлийн төв	○	○	○
	З. Баттулга	ГШУГ, ОБЕГ	○	○	○
Т. Галбадрах	СХХОГ, ОБЕГ		○	○	
Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээ	Д. Занабазар	БХБЯ	○		
	Б. Соёмбоо	БХБЯ			○
	Б. Гантулга	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, БХБЯ	○	○	○
	Ш. Уранчимэг	МХЕГ	○		
	Н. Ганчимэг	МХЕГ	○	○	○
	Б. Мөнхсайхан	МХЕГ	○	○	○
	З. Баттулга	ГШУГ, ОБЕГ	○	○	○
Т. Галбадрах	СХХОГ, ОБЕГ	○	○	○	

Дэд А/Х	Нэр	Албан тушаал	А/Х-ны гишүүнээр томилогдож А/Х-ийн хүрээнд ажил гүйцэтгэсэн хугацаа		
			3-р ХЗХ 2017 оны 6-р сар	4-р ХЗХ 2017 оны 9-р сар	5-р ХЗХ 2017 оны 11-р сар
Хүчитгэлийн загвар, зураг төсөл	Д. Занабазар	БХБЯ	○		
	Б. Соёмбоо	БХБЯ			○
	Г. Эрхэмбаяр	БХБЯ	○	○	○
	Б. Цэнд-Аюуш	Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар	○	○	○
	Ц. Хулан	Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар	○	○	○
	Г. Саруултуяа	Барилга хөгжлийн төв	○	○	○
	З. Баттулга	ГШУГ, ОБЕГ	○	○	○

(с) А/Х 2-ын дэд А/Х-үүдийн гишүүд (2017 оны 11-р сарын байдлаар)

Дэд А/Х	Нэр	Албан тушаал	А/Х-ны гишүүнээр томилогдож А/Х-ийн хүрээнд ажил гүйцэтгэсэн хугацаа		
			3-р ХЗХ 2017 оны 6-р сар	4-р ХЗХ 2017 оны 9-р сар	5-р ХЗХ 2017 оны 11-р сар
А/Х 3-ийн зохицуулагч	Д. Мөнхбат	ГУССС, ОБЕГ	○	○	○
Сургуулийн гамшгаас хамгаалах боловсрол (А/Х 3-1)	Ж. Мягмар	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам (БСШУСЯ)	○	○	○
	Ч. Ганцэцэг	БСШУСЯ	○	○	○
	П. Балжинням	БСШУСЯ	○	○	○
	А. Энхтогтох	Боловсролын хүрээлэн, БСШУСЯ	○	○	○
	Б. Эрдэнэчимэг	Боловсролын хүрээлэн, БСШУСЯ	○	○	○
	Г. Монголхатан	Боловсролын хүрээлэн, БСШУСЯ	○	○	○
	Г. Халиун	Боловсролын хүрээлэн, БСШУСЯ	○	○	○
	Мөнхбаяр	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт	○	○	○
	Д. Мөнхбат	ГУССС, ОБЕГ	○	○	○
	О. Цэнд-Аюуш	ГУССС, ОБЕГ	○		
Л. Мөнхчимэг	ГУССС, ОБЕГ			○	
Иргэдийн гамшгаас хамгаалах боловсрол (А/Х 3-2)	Д. Мөнхбат	ГУССС, ОБЕГ	○	○	○
	Д. Бат-Эрдэнэ	ГУССС, ОБЕГ	○	○	○
	Д. Дуламсүрэн	Олон нийттэй харилцах төв, ОБЕГ	○	○	○
	С. Амгалан	ЗУГ, ОБЕГ	○	○	○
	С. Должинсүрэн	НОБГ			○
	Б. Чинбат	НОБГ	○	○	○
	Б. Үүрийнгэгээ	Иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга	○	○	○



Хяналтын хуудсын тайлан

Дэд А/Х	Нэр	Албан тушаал	А/Х-ны гишүүнээр томилогдож А/Х-ийн хүрээнд ажил гүйцэтгэсэн хугацаа		
			3-р ХЗХ 2017 оны 6-р сар	4-р ХЗХ 2017 оны 9-р сар	5-р ХЗХ 2017 оны 11-р сар
		зүйн төв, НОБГ			
	Б. Ариунчимэг	Насан туршийн боловсролын үндэсний төв		○	○
	М. Амартунгалаг	БСШУСЯ	○		

**1-2 Үйл ажиллагааны явц****(1) Төслийн ерөнхий үйл ажиллагаа****1) УХ болон ХЗХ-ны хурлын зохион байгуулалтын талаар**

Энэхүү хяналтын хугацаанд гурван (3) УХ-ны хурал болон гурав дахь ХЗХ-ны хурлыг зохион байгуулсан байна.

Хурал	Он, сар, өдөр	Оролцогчид	Хэлэлцсэн асуудал
3-р УХ-ны хурал	2017 оны 6-р сарын 20	ОБЕГ, Үр дүн тус бүрийн А/Х-ийн гишүүд	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол улсын газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны талаарх баримтат кино</li> <li>- Хяналтын хуудас 2-р хувилбар</li> <li>- Тоног төхөөрөмжийн нийлүүлэлт</li> <li>- Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн сайжруулах үйл ажиллагааны хүрээнд сонгох туршилтын орон нутаг</li> <li>- Гамшгаас хамгаалах боловсрол, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг турших орон нутаг</li> <li>- Дараагийн Япон дахь сургалтын агуулга болон оролцогчид</li> </ul>
3-р ХЗХ	2017 оны 6-р сарын 29	ОБЕГ, БХБЯ, БСШУСЯ, МХЕГ, Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтэс, г.м. Нийт: 42 оролцогчид	<ul style="list-style-type: none"> <li>- Төслийн хяналтын хуудас I ба II-ын 2-дугаар хувилбар</li> <li>- А/Х бүрийн үйл ажиллагааны явц</li> <li>- Япон дахь 2-р сургалт</li> <li>- Тоног төхөөрөмжийн нийлүүлэлт</li> </ul>
4-р УХ	2017 оны 9-р сарын 28	ОБЕГ, Үр дүн тус бүрийн А/Х-ийн гишүүн	<ul style="list-style-type: none"> <li>- А/Х-ийн гишүүд</li> <li>- Тоног төхөөрөмжийн нийлүүлэлт</li> <li>- Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг сайжруулах үйл ажиллагааны хүрээнд сонгох туршилтын орон нутаг</li> <li>- Гамшгаас хамгаалах боловсрол, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг турших орон нутаг</li> </ul>
5-р УЗ	2017 оны 11-р сарын 24	ОБЕГ, Үр дүн тус бүрийн А/Х-ийн гишүүн	<ul style="list-style-type: none"> <li>- А/Х-ийн гишүүдийн бүрэлдэхүүний өөрчлөлт</li> <li>- Тоног төхөөрөмжийн нийлүүлэлт</li> <li>- Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг сайжруулах үйл ажиллагааны хүрээнд сонгох туршилтын орон нутаг</li> </ul>

**2) Тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн талаар**

Анхны ХЗХ-ны хурлаар баталсан Төслийн ажлын төлөвлөгөөнд тусгасны дагуу Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвийн газар

хөдлөлтийн чичирхийллийг биеэр мэдрүүлэх төхөөрөмж болон газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээ хийх багажуудыг ЖАЙКА нийлүүлнэ.

Газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээ хийх багажуудын хувьд, Монголын тал нь Үр дүн 2-ыг хариуцсан А/Х дээр тоног төхөөрөмжийн ашиглалтын сургалтын хөтөлбөрийг боловсруулсан бөгөөд энэхүү хөтөлбөрийг Үйл ажиллагаа болон засвар үйлчилгээний (цаашид "ҮА/ЗА") төлөвлөгөөнд тусгаж, уг төлөвлөгөөг ЖАЙКА-гийн Монгол улс дахь төлөөлөгчийн газарт хүргүүлэв.

Газар хөдлөлтийн чичирхийллийг биеэр мэдрүүлэх тоног төхөөрөмжийн хувьд, Монголын тал нь Үр дүн 3-ыг хариуцсан А/Х дээр Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв дээрх тоног төхөөрөмжийн ашиглалтын сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Хөтөлбөрт зарим нэг өөрчлөлт оруулсаны дараа энэхүү хөтөлбөрийг ҮА/ЗА төлөвлөгөөнд тусгасан байна. Уг төлөвлөгөөг ЖАЙКА-гийн Монгол улс дахь төлөөлөгчийн газарт хүргүүлсэн болно. Дээрх үйл явцын үр дүнд, газар хөдлөлтийн чичирхийллийг биеэр мэдрүүлэх тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн үйл ажиллагааг ЖАЙКА-гийн төв дээр эхлүүлсэн байна.

### **3) Япон дахь сургалтын талаар**

Монголын тал нь А/Х тус бүрийн хариуцсан заавар, санамж бичиг, сургалтын хөтөлбөр зэргийг боловсруулахад шууд ашиглах техник аргачлал болон тухайлсан мэдлэг туршлагын талаар суралцах зорилготойгоор Япон дахь 2-р сургалтыг зохион байгуулах тухай хүсэлт гаргасан. Энэхүү хүсэлтийн хариуд, Японы тал нь дээр дурьдсан сургалтын хүрээнд олж авах мэдлэг, туршлагыг эхэлж А/Х-үүдийн үйл ажиллагаанд тусгах хүсэлтийг гаргасан бөгөөд А/Х тус бүрт шаардлагатай сургалтын дэлгэрэнгүй агуулгыг 2017 оны 6-р сард зохион байгуулагдах 3-р ХЗХ-ны хурлаас өмнө бэлтгэсэн байхыг хүссэн.

3-р ХЗХ-ны хурлын үеэр А/Х-үүдийн гишүүд Япон дахь сургалтаар олж авсан мэдлэг туршлагын үндсэн дээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа талаар танилцуулж, мэдлэгээ илүү сайжруулахын тулд дараагийн Япон дахь сургалтын хүрээнд суралцах сэдвүүдийн талаар санал дэвшүүлсэн байна.

А/Х-үүдийн гишүүдийн танилцуулга дээр үндэслэн, Японы тал болон Монголын тал нь Япон дахь 2-р сургалтыг явуулахыг хүлээн зөвшөөрч, энэхүү сургалтыг гурван (3) Үр дүн тус бүрт нь хуваарь гаргаж зохион байгуулахаар шийдсэн байна.

Үр дүн 3-ын арван (10) гишүүн хамрагдсан "Гамшгаас хамгаалах боловсролын

таниулан сурталчлах ажлын чадавхийг дээшлүүлэх" сэдэвтэй сургалтыг 2017 оны 10-р сарын 29-ний өдрөөс 11-р сарын 11-ний өдөр хүртэл хэрэгжүүлэв. Үүний дараа, Үр дүн 2-ын есөн (9) гишүүн хамрагдсан "Газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээ болон барилгын хүчитгэлийн чадавхийг дээшлүүлэх" сэдэвтэй сургалтыг 2017 оны 11-р сарын 12-ны өдрөөс 22-ны өдөр хүртэл хэрэгжүүлэв. Үр дүн 1-ийн арван гурван (13) гишүүн хамрагдсан "Гамшгаас хамгаалах төлөвлөлтийн чадавхийг дээшлүүлэх" сэдэвтэй сургалтыг 2017 оны 12-р сарын 6-ны өдрөөс 16-ны өдөр хүртэл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

**(2) Үр дүн 1****Үйл ажиллагаа 1.1.1 Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжүүлэлтэд тулгарч буй асуудлуудыг тодорхойлох**

Хүснэгт 1.1.1 дээр Төслийн хүрээнд төлөвлөгдөж буй Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасан дүрэм, журам болон холбогдох журмуудыг тусгасан байна. Шинэчилсэн Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8.3-т гамшгаас хамгаалах зааврыг тодорхойлсон байна. Одоогийн хэрэгжиж буй “Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загварыг ашиглах заавар” (ОБЕГ-ын даргын 2013 оны тушаалаар батлагдсан) нь энэхүү заавартай дүйж байгаа юм. Гэвч “Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загварыг ашиглах заавар”-ын агуулга нь хэт энгийн бөгөөд үүний дагуу гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах нь хүндрэлтэй юм. Иймээс, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний шинэ заавар боловсруулах шаардлагатай юм.

**Хүснэгт 1.1.1 Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасан дүрэм, журам болон Төслийн хүрээнд боловсруулагдах холбогдох зааврууд**

<b>Шинэчилсэн хуулийн зүйл заалт болон түүнд заасан журам</b>	<b>Холбогдох заавар</b>
7.4 Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам	Эрсдэлийн үнэлгээний заавар
8.3 Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний заавар
10.2 Гамшгийн бэлэн байдлыг хангах үзлэг, шалгалт явуулах журам	Бэлэн байдлын заавар
10.8 Ажлын тусгай горимоор ажиллах журам	Бэлэн байдлын заавар
11.1 Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх албан шийдвэр	Бэлэн байдлын заавар
12.2 Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх журам	Гамшгаас хамгаалах хяналтын заавар
15.3 Эрэн хайх, аврах үйл ажиллагааг зохион байгуулах нийтлэг журам	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний заавар
16.5 Гамшгийн зарлан мэдээлэл, түүнийг дамжуулах журам	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний заавар
18.2 Шуурхай бүлгийн тухай дүрэм, журам	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний заавар
19.2 Хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх журам	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний заавар
20.3 Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний заавар
20.4 Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг хуулийн этгээдэд нөхөн олгох журам	Төслийн хүрээнд боловсруулах заавар байхгүй

Үйл ажиллагаа 1.1.2 Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж, төлөвлөлт, төлөвлөгөөний уялдаа холбоог сайжруулах, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгийн мэдээллийн сангийн журам заавар боловсруулах

**(1) Гамшгийн эрсдэлийн үнэлгээний заавар**

Эрсдэлийн үнэлгээний зааврын хүрээ, бүтэц зохион байгуулалтыг А/Х 1 тодорхой болгосон байна. ОБЕГ одоогоор “Гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх журам” (Засгийн газрын 2006 оны 176 дугаар тогтоолын хавсралт)-ыг шинэчлэх ажлыг явуулж байна. Энэхүү шинэчилсэн журамд эрсдэлийн ерөнхий үнэлгээний удирдлагын тогтолцоог голчлон заасан байна. Шинэчилсэн журам нь зургаан (6) хавсралттай бөгөөд Хавсралт 4 буюу "Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний техникийн заавар"-ыг Төслийн хүрээнд боловсруулахаар авч үзэж байна.

ЖАЙКА-гийн Турк улсад хэрэгжүүлсэн төслийн хүрээнд боловсруулсан "Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн техникийн заавар"-ыг А/Х 1 дээр Монголын нөхцөл байдалд нийцүүлэх ажлыг хийсэн байна. Энэхүү заавар дээр үндэслэн А/Х 1 хоёр (2) зааврыг боловсруулахаар болсон байна. Үүнд: 1) Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний заавар (Засгийн газар, холбогдох яам, агентлаг болон орон нутгийн засаг захиргааны байгууллагад зориулсан) ба 2) Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний заавар (холбогдох байгууллагын мэргэжилтэн, судлаач нарт зориулсан).

Орон нутгийн түвшинд онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах албадын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах үндэслэлийг бүрдүүлэх газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийх аргазүйн удирдамжаар хангах зорилго бүхий Газар хөдлөлтийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх зааврын төслийг боловсруулсан.

**(2) Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар**

А/Х 1-ийн гишүүд дараах гурван (3) зааврын төслийг боловсруулсан байна. Үүнд: Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, Аймаг/сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар ба УБ хот/дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, зэрэг орно. Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зааврын төсөл нь боловсруулагдах үе шатанд явж байна. Эдгээр зааврын төслүүдийг ЖАЙКА-гийн мэргэжлийн багийн (цаашид "ЖМБ" гэх) хүлээлгэж өгсөн мэдээллийн дагуу, Япон улсын Гамшгаас хамгаалах үндсэн төлөвлөгөө, Япон улсын хэд хэдэн яамдын гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөө болон Саппоро хотын Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө зэргийг үндэслэж боловсруулсан.

Энэхүү заавар нь ОБЕГ-ын даргын 2013 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан зааврыг орлохгүй бөгөөд зөвхөн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар юм. ОБЕГ-ын даргын 2013 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зааврыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг томилогдсон бөгөөд энэхүү газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавартай уялдуулан бусад төрлийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө хэрхэн боловсруулах талаар тусгасан заавар байх юм. Учир нь одоогийн боловсруулж байгаа заавраар Монгол Улсад тохиолдож байгаа гамшиг, ослоос хамгаалах төлөвлөгөө боловсруулах боломжгүй юм.

### **(3) Гамшгаас хамгаалах мэдээллийн сангийн заавар**

Гамшгаас хамгаалах мэдээллийн сангийн заавар нь гамшгийн мэдээллийн удирдлагын системийн үйл ажиллагааны хүрээ, мэдээллийн сангийн техникийн шаардлага болон холбогдох байгууллагуудтай мэдээлэл хамтран ашиглах зэрэг Үйл ажиллагаа 1.3.3-ын хүрээнд боловсруулах заавар болгож нэгтгэх зорилгыг тодорхой болгосон.

#### **Үйл ажиллагаа 1.1.3 Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжүүлэлттэй холбоотой журам шинээр болон шинэчлэн сайжруулах журмын төслийг боловсруулах**

А/Х 1-ийн гишүүд Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах, гамшгаас урьдчилан сэргийлэх талаас нь нягталж үзсэн бөгөөд шинэ дүрэм, журам боловсруулах эсвэл одоогийн дүрэм, журамд өөрчлөлт оруулах шаардлага байгаа эсэхийн талаар судлав. Үүний үр дүнд, арван нэгэн (11) дүрэм, журмыг шинэчлэн сайжруулах шаардлагатай гэж тодорхойлов. Үйл ажиллагаа 1.1.2-т заасны дагуу, “Гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх журам” (Засгийн газрын 2006 оны 176 дугаар тогтоолын хавсралт)-ыг шинэчлэх үйл ажиллагааг ОБЕГ аль хэдийн эхлүүлсэн байгаа бөгөөд журмын төслийн гол агуулга нь бэлэн болсон байна. Энэхүү журмын хавсралтанд Төслийн хүрээнд боловсруулах газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний зааврыг хавсаргана. Журмын хавсралтууд одоогоор боловсруулалтын үе шатанд явж байна.

#### **Үйл ажиллагаа 1.2.1 ОБЕГ болон гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч байгууллагын харилцан ажиллагааг хангах гэрээ, санамж бичгийн төсөл боловсруулах**

АХ-ийн гишүүд Монгол Улс болон Япон Улсад хэрэглэгдэж буй гэрээ, санамж бичгүүдэд

харьцуулалт, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр "Санамж бичиг боловсруулах гарын авлага"-ын төслийг боловсруулсан. Энэхүү гарын авлага нь ерөнхий агуулгын хувьд: (i) одоогийн нөхцөл байдлыг тодорхой болгох, (ii) санамж бичгийн хүрээг судлах, (iii) санамж бичгийн агуулгад дүн шинжилгээ хийх, (iv) санамж бичгийн хүрээний талаар тохиролцох, ба (v) санамж бичгийн төсөл гэсэн байна. А/Х 1 тухайлсан санамж бичгийн төслийг боловсруулах явцад гарын авлагыг шинэчилсэн бөгөөд одоогоор 0.8-дугаар хувилбар болон шинэчлэгдээд байна.

А/Х 1 дээр хэлэлцсэний үр дүнд "Мэдээлэл, харилцаа холбоо", "Түлш, шатахуун", "Эм бэлдмэл" гэсэн гурван (3) салбарыг сонгон авч төслийн хугацаанд санамж бичиг байгуулахаар ажиллаж байна. Мөн түүнчлэн, гарын авлагын "(i) одоогийн нөхцөл байдлыг тодорхой болгох" гэсэн хэсгийг авч үзэхдээ багийн гишүүд хоорондоо "брэйнсторминг" хэлбэрээр санал бодлоо солилцох байдлаар судалсан.

< Мэдээлэл / харилцаа холбооны чиглэлээр >

АХ нь гамшгийн үед харилцаа холбооны найдвартай ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийн байгуулах боломжийг судлах зорилгоор Мэдээлэл, харилцаа холбооны зохицуулах хороо, үүрэн телефоны оператор дөрвөн (4) компанитай санал солилцох уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтын үр дүнд "Харилцаа холбооны газар"-тай гамшгийн үед ажиллах нөөц шугам ашиглах тухай гэрээ, санамж бичгийг байгуулахаар тохирч, төслийг боловсруулан хүргүүлсэн бөгөөд 2018 оны 02-р сард гэрээ, санамж бичгийг байгуулахаар төлөвлөж байна.

< Түлш, шатахууны чиглэлээр >

Улсын нөөцийн бараа бүтээгдэхүүний талаарх мэдээлэл улсын нууцад хамаардаг учир, А/Х 1 нь зөвхөн түлш, шатахуун импортлодог хувийн компаниудын болон тэдгээрийн нөөц болон хангамжийн талаарх судалгааг холбогдох мэргэжилтнээс гаргуулан авч, гэрээ, санамж бичиг байгуулах боломжийг судалсан.

А/Х 1 нь ОБЕГ, Ашигт малтмал, газрын тосны газар болон түлш шатахуун импортлодог хувийн аж ахуй нэгжтэй гамшгийн үед үүрэг гүйцэтгэж буй онцгой байдлын албаны техник, хэрэгсэлийг нэн тэргүүнд түлш шатахуунаар хангах тухай гэрээ, санамж бичгийн төслийг боловсруулсан. Гэрээ, санамж бичгийг 2018 онд байгуулах боломжийг судлаж байна.

< Эм бэлдмэл >



Эрүүл мэндийн яамаас (цаашид "ЭМЯ" гэх) Монгол Улсын эм, боох материалыг импортлогч аж ахуй нэгжүүд болон хуваарилалтын талаарх мэдээллийг гаргуулан авсан. АХ нь ЭМЯ-ны Гамшгаас хамгаалах улсын албаны төлөвлөгөөний хавсралт болон батлагдах Гамшгийн үед эм, бэлдмэлээр хангах тухай гэрээ, санамж бичгийг ЭМЯ болон холбогдох аж ахуйн нэгжтэй байгуулах талаар санал солилцох уулзалтыг тус яамны ажилтнуудтай зохион байгуулсан. Энэхүү уулзалтын хүрээнд Эрүүл мэндийн улсын албаны сургалтыг 2018 оны 03 дугаар сард зохион байгуулж, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг турших, гэрээ, санамж бичиг байгуулах асуудлыг турших үзэхээр төлөвлөж байна.

< Бусад салбарууд >

Ажлын хэсэг нь "хүнс", "түр хоргодох байр/түр сууц" болон "цэвэр, бохир ус" зэрэг асуудалтай холбоотой гэрээ, санамж бичиг байгуулах боломжийг судлаж байна. Энэ хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам, Барилга, хот байгуулалтын яам болон Ус сувгийн удирдах газартай гэрээ, санамж бичгийн талаар санал солилцох уулзалтыг зохион байгуулсан.

**Үйл ажиллагаа 1.3.1 Улс болон орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хяналт, тайлан, үнэлгээ хийх болон нийтлэхтэй холбоотой асуудлыг тодорхойлох**

Монгол улсын одоогийн мөрдөгдөж буй Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд гамшгийн төрөл тус бүрийн үеийн шуурхай удирдлагыг түлхүү авч үзсэн байдаг бөгөөд гамшгаас урьдчилан сэргийлэх болон бэлэн байдлыг хангах талаар мэдээлэл цөөн байдаг учир ЖМБ-аас Японы гамшгаас хамгаалах үндсэн төлөвлөгөөний Гамшгийн төрөл тус бүрийн нийтлэг арга хэмжээний талаар А/Х 1-т мэдээллийг хүлээлгэн өгөв.

Нийслэл, аймаг болон сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь Үйл ажиллагаа 1.1.1-д дурдсан "Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загварыг ашиглах заавар" (ОБЕГ-ын даргын 2013 оны тушаал)-т үндэслэн боловсруулагддаг. Үйл ажиллагаа 1.1.2-т тусгасны дагуу шинэ зааврын төслийг А/Х 1 дээр боловсруулж дууссан бөгөөд орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг энэхүү зааврын дагуу шинэчлэн сайжруулах тухай чиглэлийг тодорхой болгов.

**Үйл ажиллагаа 1.3.2 1.3.1-д дурдсан төлөвлөгөөг шинэчлэн сайжруулах гарын авлага боловсруулах**

Үйл ажиллагаа 1.1.2-ын хүрээнд А/Х 1-ийн гишүүд Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, Аймаг/сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөө

боловсруулах заавар болон УБ хот/дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зааврын төслийг боловсруулсан байна. Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний заавар нь одоогоор боловсруулагдаж байгаа.

2017 оны 11-р сарын 24-ний өдөр зохион байгуулсан 4-р УХ-ны хурлын үеэр одоогийн мөрдөж буй газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн сайжруулах зорилгоор Дархан-Уул аймаг болон Өмнөговь аймгийг туршилтын орон нутаг болгон сонгож, УБ хотын Чингэлтэй дүүрэг болон Баянгол дүүргийг туршилтын дүүргүүдээр сонгов.

А/Х 1 нь эдгээр шинээр боловсруулах зааварт үндэслэн шинэчлэн сайжруулах ажлыг эхлүүлнэ.

### **Үйл ажиллагаа 1.3.3 Гамшгаас хамгаалах мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх одоогийн системийг шинэчлэн сайжруулах**

Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын 14 дүгээр зүйл "Гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх"-д ОБЕГ нь гамшгийн мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлнэ гэж заасан. ОБЕГ-ын дээр дурьдсан хуулийн дагуу гүйцэтгэх үүрэг болон "Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ"-ний тэргүүлэх чиглэлүүдийг Монгол улсад хэрэгжүүлэхэд оруулах хувь нэмэр зэрэг үйл ажиллагааны хүрээнд А/Х 1 дээр өнөөгийн тогтолцоог шинэчлэн сайжруулах бодлогын талаар авч үзэж санал солилцов. Ийнхүү санал солилцсоны үр дүнд, ОБЕГ, орон нутгийн онцгой байдлын байгууллага болон холбогдох байгууллага хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор, гамшгаас хамгаалах мэдээллийн санг шинэчлэн сайжруулах болон ОБЕГ-т мэдээлэл хамтран ашиглах системийг шинээр суурилуулах үйл ажиллагааны ерөнхий хүрээг тодорхойлсон байна. А/Х-ийн гишүүд ОБЕГ-ын гамшгаас хамгаалах үйл ажиллагааг дэмжих үндсэн систем болгож газар зүйн мэдээллийн системд (GIS) тулгуурласан гамшгийн орон зайн мэдээллийн санг шинээр байгуулах талаар ойлголтоо нягталсан байна.

2017 оны 6-р сарын байдлаар "И-коми мап" (Японы ГХШУТХ-ийн боловсруулсан вэб-д суурилсан газар зүйн мэдээллийн систем)-ыг Монголын Үндэсний дата төвийн серверт суурилуулах ажлыг гүйцэтгэсэн байна.

ОБЕГ-ын Гамшгийн шуурхай удирдлага, Зарлан мэдээллийн төвийн гамшгийн өдөр тутмын мэдээ мэдээллийн системийг шинээр нэвтрүүлж буй гамшгийн орон зайн мэдээллийн сан руу хөрвүүлэхэд зориулсан програм хангамж болон мэдээллийн төрөл, агуулга, хэлбэрийг тодорхойлж мэдээллийн сан байгуулах ажлыг А/Х 1-ийн

гишүүд ЖМБ-ийн техникийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэж байна.

Шинэ орон зайн мэдээллийн санг үр дүнтэйгээр ашиглахын тулд ОБЕГ нь системийг ашиглахтай холбоотой дүрэм, журам боловсруулах шаардлагатай бөгөөд орон зайн мэдээллийн сангийн удирдлага зохион байгуулалт, түүний тогтвортой ажиллагаа, ОБЕГ-ын үйл ажиллагаатай уялдаа холбоог хангахын тулд боловсон хүчний чадавхийг сайжруулах шаардлагатай байна. 2017 оны 8-р сарын 1-ний өдөр, А/Х 1-ийн гишүүд Төслийн хүрээнд хэрэгжүүлж буй мэдээллийн санг шинэчлэн сайжруулах үйл ажиллагааны явцын талаар ОБЕГ-ын удирдлагад танилцуулж, орон зайн мэдээллийн сангийн удирдлага зохион байгуулалтыг хангахын тулд боловсон хүчний чадавхийг дээшлүүлж, сервер гэх зэрэг техник тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах шаардлагатайг тайлбарласан байна. Мэдээллийн сангийн удирдлага зохион байгуулалтыг дагнан хариуцаж ажиллах Гамшгийн шуурхай удирдлага, Зарлан мэдээллийн төвийн боловсон хүчний чадавхийг сайжруулах болон ОБЕГ-т шинэ сервер худалдан авах төсвийг төлөвлөх чиглэлийн тухай ОБЕГ-ын дарга дурдсан байна.

Системийн тогтвортой үйл ажиллагаа болон удирдлага зохион байгуулалтаар хангахад чиглэсэн зохистой арга хэмжээний талаар Мэдээллийн сангийн заавар болон Үйл ажиллагааны гарын авлагыг боловсруулах явцад А/Х 1-ийн гишүүдтэй ярилцав. 2017 оны 11-р сарын дундуур А/Х 1 нэг өдрийн ажлын вакуумжсан цугларалт зохион байгуулж Мэдээллийн сангийн зааврын төсөл боловсруулав.

**Үйл ажиллагаа 1.3.4 Үйл ажиллагаа 1.3.1 болон 1.3.2-т заасан улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжүүлэлт, хяналт, үнэлгээ зэрэг үйл ажиллагааны талаар Монгол улсын иргэдэд мэдээлэх зорилго бүхий гамшгаас хамгаалах цагаан номыг боловсруулах**

А/Х 1 нь цагаан номыг боловсруулах төлөвлөгөөг ОБЕГ-ын арван (10) газрын хариуцсан мэргэжилтэнд тайлбарлаж, шаардлагатай цуглуулах материалуудын агуулга болон хүлээлгэж өгөх хугацааны талаар мэдээлэл өгсөн байна. Тайлбарлаж танилцуулсан агуулга нь Цагаан ном боловсруулах гарын авлагын төсөл болгож боловсруулна.

Цагаан номыг хариуцах мэргэжилтэн өөрчлөгдсөн бөгөөд 10-р сарын эцсийн байдлаар мэдээлэл цуглуулах ажлын явц дараах байдалтай байна.

**Хүснэгт 1.3.4 Цагаан номын боловсруулалтын үйл ажиллагаан дахь мэдээлэл цуглуулалтын байдал**

ОБЕГ-ын газар	Цуглуулах шаардлагатай материалын тоо	10-р сарын сүүлээр цуглуулах материал	Үр дүн
БЗХАГ	7	4	3
ГУСГ	4	1	1
ГЭУГ	2	1	0
ГШУГ	10	6	1
ГТТГ	3	2	0
УНХТГ	3	2	0
ЗУГ	1	0	0
СХХОГ	1	0	0
ГСХ	3	0	2
НОБГ	1	0	0
Нийт	39	16	7

### (3) Үр дүн 2

#### Үйл ажиллагаа 2.1.1 Гамшгаас хамгаалах тухай хуулийн хүрээнд, Барилга, Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнд газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ хийх журам, зааварт дүн шинжилгээ хийж шинэчилсэн заавар боловсруулах

А/Х 2-ын гишүүд барилга, байгууламжийн газар хөдлөлт тэсвэрлэлттэй холбоотой үнэлгээний одоогийн норм, нормативын бичиг баримтуудыг судлан үзэж, эдгээр бичиг баримт бичгүүдэд тусгагдаагүй асуудлуудыг тодорхойлж, нэмэлтээр оруулах агуулгыг судалсан. Судалгааны үр дүнд, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй барилгын үнэлгээтэй холбоотой бичиг баримтууд нь ихэвчлэн барилгын физик элэгдэл, барилгад биет судалгаанд зориулсан агуулгатай байна гэсэн дүгнэлтэд хүрсэн. Иймээс, А/Х 2 нь төслийн хүрээнд барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх аргачлалыг шинээр боловсруулахаар төлөвлөсөн.

Тус ажлын хүрээнд газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээтэй холбоотой мэргэжлийн байгууллагуудын мэргэжилтнүүдтэй уулзалт хийсэн. Эдгээр уулзалтуудад олон тооны барилга, байгууламжууд хуучирч элэгдэлд орсон, насжилт өндөртөй байгааг тодруулсан бөгөөд эдгээр барилгыг хүчитгэх, шинэчлэн барих шаардлага зайлшгүй тулгарч буй талаар онцгойлон хөндөгдөж байсан. Үүний улмаас А/Х 2 нь тодорхой тооны барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээг хийх, түүнчлэн одоо ашиглагдаж буй инженерийн шугам сүлжээний хяналтын хуудсыг боловсронгуй болгох, нэмэлт зүйл заалт оруулах зэрэг ажлыг төлөвлөсөн болно.

#### Үйл ажиллагаа 2.1.2 Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлал, Үнэлгээнд хэрэглэгдэх хэмжилтийн багаж төхөөрөмжийг ашиглах заавар боловсруулах

Шинээр боловсруулж буй аргачлалыг практикт өргөнөөр нэвтрүүлэх зорилгоор Зураг 2.1-т заасан Монгол улсын норм, норматив боловсруулах журмын дагуу барилгын дүрэм болгохоор шийдсэн.

Төслийн хүрээнд 4-н төрлийн барилгын дүрэм боловсруулахаар шийдвэрлэсэн. Үүнд:

- 1) Цутгамал төмөр бетон бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал (БД);
- 2) Угсармал том хавтгаалжин бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал(БД); ;

3) Тоосгон өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал (БД);

4) “Авто зам, гүүр, инженер хангамжийн сүлжээнд газар хөдлөлтийн эрсдэлийг үнэлэх аргачлал” (БД) болно.

Японы үнэлгээний аргачлал, хүчитгэлийн технологийг Монгол Улсын төрийн байгууллагын албан хаагчдад танилцуулах, мэдлэг чадварыг дээшлүүлэхийн тулд хүснэгт 2.1-т заасан бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна. А/Х 2-ын гишүүд харилцан мэдлэг мэдээллээ хуваалцаж байх зарчмаар ажиллаж байгаа.

**Бүдүүвч 2.1 Барилгын дүрэм боловсруулах ажлын дараалал**



БХБЯ: Барилга, хот байгуулалтын яам

**Хүснэгт 2.1 Барилгын дүрэм боловсруулах бүрэлдэхүүн**

		Төмөр бетон барилга	Угсармал хавтгаалжин барилга	Тоосгон өрөгт барилга	Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ
Зөвлөх үйлчилгээний баг	Байгууллага	МБИХ			“Сарт-Шарайд” ХХК
	Ахлагч	Ганзориг			“Сарт-Шарайд” ХХК
	Нарийн бичиг	Ганбаяр			
	Гишүүд	Тулга Төрбат Базарсад	Дүйнхэржав Баасанжав Одбаяр	Мөнхбаяр Шараа Жавхлан	
ЖАЙКА баг	Ахлагч	Фүкүшима			
	Гишүүд	Аоки	Аоки	Кита	Мацүо
Ажлын хэсэг-2	Ахлагч	Соёмбоо			
	Гишүүд	Гантулга	Саруултуяа	Цэнд-Аюуш	Баттулга

		Эрхэмбаяр Ганчимэг	Галбадрах	Хулан	Мөнхсайхан
--	--	-----------------------	-----------	-------	------------

### **1) Барилга, байгууламжийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлал боловсруулах**

А/Х 2 нь барилга, байгууламжийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээг хийх аргачлалын талаар хэлэлцэж үнэлгээний хялбарчилсан ба нарийвчилсан гэсэн 2 түвшинд аргачлалыг боловсруулахаар шийдсэн. Үнэлгээний аргачлал нь тухайн барилга байгууламжийн түвэгшил, хариуцлагын зэрэг, эдийн засгийн үр ашиг зэргээс хамаарна. Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлгээг 2 түвшний аргачлалд хуваан авч үзсэнээр зөвхөн барилгын мэргэшсэн инженер төдийгүй техникийн ажилтан ч барилгыг хялбарчилсан үнэлгээгээр үнэлэх боломжтой болно. Нарийвчилсан аргачлалын тухайд, барилга бүтээцийн тооцоо болон хүчитгэлийн талаар нарийн мэдлэг бүхий инженер, мэргэжилтэн үнэлгээг хийх шаардлагатай.

А/Х 2 нь Зөвлөх-тай хамтран Японы газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ болон барилгыг хүчитгэх норм, нормативт үндэслэн, цутгамал төмөр бетон, угсармал том хавтгаалжин, тоосгон өрөгт бүтээцтэй барилгын дүрмийн төслийг боловсруулсан. Барилгын дүрмийн төслийг боловсруулахад тулгарсан зарим нэгэн асуудлын талаар Зөвлөх үйлчилгээний багтай (цаашид "ЗҮБ" гэх) хамтран ажиллаж, ЗҮБ-аар дамжуулан барилгын дүрмийн анхны төслийг Барилгын Хөгжлийн Төвд (цаашид "БХТ" гэх) хүргүүлсэн байна. Одоогоор БХТ-өөс аргачлалын төслийг дахин нягталж байна.

### **2) “Авто зам, гүүр, инженер хангамжийн сүлжээнд газар хөдлөлтийн эрсдэлийг үнэлэх аргачлал” барилгын дүрэм боловсруулах**

А/Х 2 дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний арга зүйн талаар хэлэлцсэний үр дүнд, эмзэг байдлыг муруйн функцийг ашигласан арга зүйг ашиглах нь тохиромжтой гэсэн шийдвэрт хүрсэн. Эмзэг байдлыг муруйд төслийн 1-р үе шатны судалгааны үр дүнг ашигласан. Дүрмийн төслийг БХТ-д хянуулахаар хүргүүлсэн бөгөөд уг төслийг холбогдох мэргэжлийн зөвлөл дэмжсэн.

Мөн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын (цаашид "МХЕГ" гэх) хүсэлтийн дагуу хяналтын хуудасны загварыг боловсруулж дуусган хүргүүлсэн болно. Энэхүү хяналтын хуудсын үнэлгээг Excel программ дээр тооцох боломжтойгоор боловсруулсан.

**Үйл ажиллагаа 2.1.3: Барилга, байгууламж болон шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээг хийх мэргэжилтнүүдийн мэдлэг, үр чадварыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах**

Барилга, байгууламжийн хялбарчилсан үнэлгээ болон дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний хяналтын Excel хүснэгтүүдийг боловсруулсан. Эдгээр материалуудыг ЗҮБ-ын гишүүдэд өнөөгийн Японы норм, нормативуудыг ойлгуулах зориулалттайгаар боловсруулсан бөгөөд газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний барилгын дүрмийн төсөл хэвлэгдсэний дараа тэдгээрийг шинэчлэн сайжруулах шаардлагатай юм.

Мөн А/Х 2 нь төслийн хүрээнд төлөвлөгдөж буй сургалтаар заах сэдэв агуулгыг тодорхойлохын тулд дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний Excel хүснэгтүүдийг ашиглан урьдчилсан сургалт зохион байгуулсан.

**Үйл ажиллагаа 2.2.1 Барилга байгууламжийг хүчитгэх, шинэчлэн барих тухай заавар аргачлал боловсруулах**

А/Х 2 газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ, барилга, байгууламжийн хүчитгэл зэргийг нэгтгэж, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнээс гадна барилгын төрөл бүрд нэг заавар боловсруулахаар шийдсэн. Учир нь газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ нь барилгын хүчитгэлтэй шууд холбоотой.

А/Х 2 нь ЗҮБ-тэй хамтарч Японы барилга, байгууламжийн хүчитгэлийн норм, нормативуудад тусгагдсан хүчитгэлийн арга зүйг судалсан. А/Х 2 болон Монголын мэргэжилтнүүд Монгол улсад ашиглагдаж байгаа барилгын материал болон технологид тохирсон хүчитгэлийн аргачлалыг сонгосон. Хуучин Зөвлөлт холбоот улсын угсармал бүтээцтэй барилгуудад тохирох аргачлалыг судалж байна.

**Үйл ажиллагаа 2.2.2: Орон сууц, цэцэрлэг, сургууль, эмнэлэг, төрийн захиргааны барилга, байгууламж зэргийг хүчитгэх, загвар зураг төсөл боловсруулах**

А/Х 2 нь барилгын бүтээцийн төрөл, зориулалт зэрэг үзүүлэлтийг үндэслэн хүчитгэлийн загвар зураг төсөл боловсруулах барилгуудыг сонгохоор хэлэлцсэн байна. Үүний үр дүнд А/Х 2 нь ажлын төлөвлөгөөнд заасан зориулалт бүрд нэг маягийн зурагтай барилгуудыг сонгохоор шийдвэрлэсэн байна.

Барилга, хот байгуулалтын яамны (цаашид "БХБЯ" гэх) газрын дарга томилогдоогүй байсны улмаас АХ 2-ын ахлагчаар эцсийн шийдвэрийг баталгаажуулаагүй. Шинэ А/Х 2-ын томилогдсоны дараа эцсийн шийдвэрийг гаргана.



**(4) Үр дүн 3**

**Үйл ажиллагаа 3.1.1 Гамшгаас хамгаалах тухай хуультай уялдсан цэцэрлэг, сургуулийн гамшгаас хамгаалах боловсролын агуулга, арга зүй, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон удирдамж боловсруулах**

**(1) Сургуулийн гамшгаас хамгаалах боловсролын хөтөлбөр боловсруулахтай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх бодлого**

Монголын талын хамтран ажиллагсадтай нарийвчлан ярилцсаны үр дүнд анх төлөвлөж байсан хөтөлбөр боловсруулах зөвлөлийг байгуулах шаардлагагүй бөгөөд АХЗ-1 гишүүд хөтөлбөр боловсруулах үндсэн ажлыг гүйцэтгэж, гадны экспертүүдээс техникийн зөвлөгөө болон санал авч, явцын хэлэлцүүлэг явуулах замаар хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн.

Мөн түүнчлэн боловсруулах хөтөлбөрийн агуулга нь зөвхөн газар хөдлөлтийн гамшгаар хязгаарлагдахгүй, сургуулийн гамшгаас хамгаалах цогц сургалтын зорилтот гамшиг болох Монгол улсад тохиолддог бүх төрлийн гамшиг байх нь зүйтэй гэж үзсэн.

Хөтөлбөр боловсруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг Хүснэгт 3.1-д үзүүлсэн байдлаар боловсруулсан.

**Хүснэгт 3.1 Хөтөлбөр боловсруулах ажлын төлөвлөгөө**

		Mar.				Apr.				May				Jun.				Jul.				Aug.				Sep.				Oct.				Nov.				Dec.							
		I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV								
	<b>Working Group Meetings</b>	★					★				★				★																														
1	Understanding of Basic Implementation Policy																																												
2	Working Plan Development																																												
3	Collection, Translation, and Studying of Reference Documents																																												
4	Analysis of Current DRR Education in Schools																																												
5	Participation in the Training in Japan/ Training by Japanese Experts																																												
6	Development of Draft Contents of the Guideline																																												
7	Getting Comments from Relevant Organizations and Professional Experts																																												
8	Final Improvement and Completion of the Guideline																																												
9	Getting Approval of the Guideline																																												

## **(2) Японы удирдамж болон холбогдох материалуудыг танилцуулсан**

Хөтөлбөр боловсруулах ажил эхлэхийн өмнө Японы Боловсрол, Соёл, Спорт, Шинжлэх Ухаан, Технологийн Яам (цаашид “Японы Боловсролын яам” гэх)-наас боловсруулсан “Сургуулийн гамшгаас хамгаалах сургалтын удирдамж: Амьдрах чадварыг хөгжүүлэх гамшгаас хамгаалах боловсролыг хэрэгжүүлэх нь” товхимлыг ашиглан Японы сургуулийн гамшгаас хамгаалах боловсролын үндсэн санаа болон тогтолцооны талаар танилцуулсан. Мөн Японы муж болон хотуудын боловсролын хорооноос боловсруулсан гамшгаас хамгаалах боловсролын нарийвчилсан төлөвлөгөө, гарын авлага зэргийг танилцуулсан. Мөн сургалтын удирдамж болон загвар хичээлийн төлөвлөгөөний агуулгад дурдсан сургалтын агуулгуудын хамаарлыг үзүүлж, холбогдох сурах бичгийн тодорхой хуудсуудыг зааж өгсөн хүснэгт өгсөн. Түүнчлэн хөтөлбөртэй холбоотой хэд хэдэн холбогдох материалыг Монгол хэлнээ орчуулж, АХЗ-1-ийн үйл ажиллагаанд ашигласан.

Японы Боловсролын Яамны шинжлэх ухааны үйл ажиллагааны судалгаа явуулдаг Шига их сургуулийн Боловсрол судлалын тэнхимийн профессор Фүжиока Монголын боловсролын салбарт зочлох хүрээнд нийслэлийн 131-р бага сургуульд гамшгаас хамгаалах туршилтын хичээл явуулсан. Бага сургуулийн 4-р ангийн сурагчдад хүн төрөлхтөнд байгалийн үзүүлэх үр өгөөж болон гамшгийн талаар ойлголт өгч, гамшгийн бэлэн байдлын талаар хичээл заасан. Хичээлд сурагчдаас гадна АХЗ-1-ийн гишүүд ажиглагчаар оролцсон бөгөөд гамшгийн механизмын талаар ойлголт өгөх туршилта явуулах зэргээр загвар практик хичээл болж чадсан нь анхаарал татсан. Туршилтын хичээлийн дараа АХЗ-1-ийн гишүүд болон 131-р сургуулийн багш нар оролцсон санал солилцох уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар Японы сургуулийн гамшгаас хамгаалах удирдамжийн зорилго, зорилт, гамшгаас хамгаалах боловсролын шинэчлэл өөрчлөлт болон сургууль дахь гамшгаас хамгаалах загвар хичээлийн видео бичлэг зэргийг профессор Фүжиокагийн зүгээс танилцуулсан. Багшид зориулсан материал болох видео хичээл нь ашиглахад хялбар, үр дүнтэй гэсэн саналыг АХЗ-1-ийн гишүүд хэлсэн.

## **(3) Монгол улсын сургуулийн гамшгаас хамгаалах боловсролын өнөөгийн байдлын талаарх шинжилгээ**

Монгол улсын сургуулийн гамшгаас хамгаалах боловсролын өнөөгийн байдлыг тодорхойлохын тулд Монгол улсын СӨБ, бага боловсрол, суурь болон бүрэн дунд боловсролын хөтөлбөр дэх гамшгаас хамгаалах агуулгуудын талаар шинжилгээ хийсэн. Шинжилгээний голлох үр дүнгүүд нь дараах байдалтай байна.

- Аюулт үзэгдэл, гамшгийн талаарх агуулгууд бүрэн дунд, суурь боловсролын

хөтөлбөрт хангалттай туссан байна. СӨБ болон бага боловсролын хөтөлбөрийн тухайд аюулт үзэгдэл, гамшгийн талаарх агуулгууд тодорхой хэмжээгээр тусгагдсан байна.

- Экологийн гаралтай гамшгийн агуулга 48% бөгөөд ихэвчлэн суурь, бүрэн дунд боловсролын газарзүй, химийн хичээлийн агуулгад багтсан байна.
- Байгалийн гамшгийн агуулгууд нь газар зүйн хөтөлбөрт багтсан.
- Техник технологийн гамшгийн агуулгууд нь химийн хичээлийн хөтөлбөрт химийн бодистой хэрхэн харьцах, химийн хорт бодисын нөлөө зэрэг агуулгаар туссан байна.
- Нийгмийн гаралтай болон биологийн гаралтай гамшгийн агуулгууд тэр бүр хичээлийн хөтөлбөрүүдэд багтаагүй байна.
- Ерөнхийдөө одоогийн сургалтын хөтөлбөрийн гамшгаас хамгаалах боловсролын зорилго, зорилтууд нь тодорхой бус. Мөн гамшгаас хамгаалах боловсролтой хамааралтай агуулгууд нь газарзүй, нийгэм судлал зэрэг зарим хичээлд тусгагдсан боловч гамшгаас хамгаалах суралцахуйн системтэй байдал хангагдаагүй.
- Хувь хүний аюулгүй амьдрах ухааны агуулгууд нь СӨБ болон бага боловсролын хөтөлбөрт тусгагдаж, аюулт үзэгдэл, осол, гамшиг болон нийгмийн аюулгүй байдал зэрэг агуулгууд нь суурь болон бүрэн дунд боловсролын хөтөлбөрт туссан.

#### **(4) Сургуулийн гамшгаас хамгаалах сургалтын хөтөлбөрийн төслийг боловсруулах**

Холбогдох материал болон одоогийн сургуулийн гамшгаас хамгаалах агуулгын дүн шинжилгээний үр дүнд үндэслэн, боловсролын түвшин тус бүрийн гамшгаас хамгаалах боловсролын удирдамжийн нэр, бүтэц, зорилгыг дараах байдлаар тодорхойлсон.

- Удирдамжийн нэр: “Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөр”
- Бичиг баримтын хэлбэр: БСШУСЯ-ны сайд болон Шадар сайд батлах сургалтын хөтөлбөр.
- Хөтөлбөрийн агуулга: Сургалтын хөтөлбөрт дан ганц байгалийн гамшиг бус аюулгүй амьдрах ухааны сургалтыг бүхэлд нь хамруулна.

- Хөтөлбөрийн бүтэц: 1) Үндэслэл, 2) Зорилго, 3) Агуулга ба 4) Заах арга зүй

Дээрх бүтцээр хөтөлбөрийн төслийг боловсруулсан. Монгол улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам (цаашид “БСШУСЯ” гэх)-наас олон нийтийн анхны хэлэлцүүлгийг 9-р сард явуулсан бөгөөд хөтөлбөрийн төслийг эцэслэхтэй холбогдуулан холбогдох мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдээс санал, зөвлөгөө авах уулзалтыг 10-р сарын 4-ний өдөр зохион байгуулсан. Одоогоор ажлын хэсгийн гишүүд Япон дахь сургалтаар олж авсан мэдлэг болон холбогдох байгуулагаас ирүүлсэн саналын дагуу хөтөлбөрийн төслийг сайжруулах ажлыг хийж байна.

#### **5) Сургуулийн цогц аюулгүй байдлын хөтөлбөртэй хамтран ажиллах тухайд**

2016 оноос хойш БСШУСЯ болон Дэлхийн зөн Монгол ОУБ-аас ОБЕГ, ЮНИСЕФ болон НҮБХХ-тэй хамтран “Сургуулийн цогц аюулгүй байдал” хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн. Уг хөтөлбөр нь шийдвэрлэх талуудад холбогдох мэдээллийг хүргэх болон зохицуулалт хийх замаар үйл ажиллагааны дараах 3 зорилтот хэсгийг хэрэгжүүлнэ: (1) Сургуулийн барилгын аюулгүй байдал, (2) Сургуулийн гамшгийн менежмент болон (3) Гамшгийн эрсдлийг бууруулах, гамшгийн даван туулах чадварыг нэмэгдүүлэх боловсрол.

2016 оны 11-р сарын 28-29-ний өдрүүдэд “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн цогц аюулгүй байдал үндэсний бодлогын чуулган” аймаг, нийслэл дүүргийн Боловсролын газар, төв орон нутгийн Онцгой байдлын газар, сургуулийн аюулгүй байдлын чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийн оролцоотойгоор явагдаж, сургуулийн аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар зөвлөмж гаргасан. Уг зөвлөмжийн дагуу шийдвэрлэх талуудын хэлэлцээрийн хүрээнд санал болгож буй үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохицуулалт хийх зорилго бүхий сургуулийн цогц аюулгүй байдлыг дэмжих 4 жилийн төлөвлөгөө боловсруулсан. Түүнчлэн тэдгээр үйл ажиллагааны хэрэгжилтийг дэмжих, явцыг хянах платформ байгуулагдаж, холбогдох талууд санамж бичиг байгуулан ажиллаж байна.

Төслийн үр дүн 3-ын үйл ажиллагаа нь Сургууль цэцэрлэгийн цогц аюулгүй байдал хөтөлбөрийн 3 дахь зорилтот хэсгийн агуулгатай хамааралтай байгаа тул БСШУСЯ-наас Төслийн багийг дээрх хөтөлбөртэй хамтран ажиллахыг хүссэн. Үйл ажиллагааны давхцыг бууруулахын тулд Төслийн баг нь Сургууль цэцэрлэгийн цогц аюулгүй байдлын хөтөлбөрт ажиглагч байдлаар оролцож, холбоотой ажиллахаар болсон ба 2017 оны 5 болон 8-р сард болсон воркшоп уулзалт зэрэг холбогдох үйл ажиллагаанд оролцож ирсэн.

Үйл ажиллагаа 3.1.2: Цэцэрлэг, сургуулийн гамшгийн эрсдэлийг бууруулах сургалтанд ашиглах сурах бичгийн нэмэлт материал, сургалтын материал зэргийг боловсруулах

Сургалтын материал боловсруулахын өмнө одоо байгаа гамшгаас хамгаалах сургалтын материалыг цуглуулсан.

Үүнд, НҮБХХ-ийн дэмжлэгтэй боловсруулсан сургуулийн гамшгаас хамгаалах сургалтанд ашиглах сурах бичиг бий ч улсын хэмжээний сургуулиудад ашиглахын тулд агуулгыг сайжруулах шаардлагатай. Учир нь гамшгаас хамгаалах сургалтын агуулгыг бие даасан хичээл хэлбэрээр заах зорилготой боловсруулсан, мөн сурах бичгийн зарим нэг агуулга, зургийг оросын сурах бичгээс хуулбарлан тавьсан нь зохиогчийн эрхийг асуудлыг шийдвэрлэж чадаагүй.

Дээр дурдсан НҮБХХ-ийн сурах бичгээс гадна Дэлхийн зөн Монгол ОУБ-аас гамшгийн төрлүүдээр хүүхдэд зориулан гаргасан, сургуулийн гамшгаас хамгаалах сургалтанд ашиглаж болохоор хэд хэдэн сайн сургалтын материал бий. Гэхдээ хүүхдийн насны онцлог, хичээлүүдийн агуулгад суурилсан системтэй боловсрол олгох боломжтой материал одоогоор байхгүй байна. Багш нар сургалтын төлөвлөгөөний дагуу төвөггүй ашиглах боломжтой сургалтын материал, гарын авлагаар хангах шаардлага тулгарч байна.

Дээрх нөхцөл байдлаас “Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөр”-ийн хавсралт материал болох “Багшийн гарын авлага” боловсруулах нь зүйтэй гэж үзсэн. “Амьдрах чадварыг хөгжүүлэх гамшгаас хамгаалах боловсролыг хэрэгжүүлэх нь” товхимлын сургуулийн гамшгаас хамгаалах загвар хичээлийн агуулгаас санаа авч, “Багшийн гарын авлага”-ыг Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийн агуулгыг сургалтанд хэрхэн хэрэгжүүлэх вэ гэсэн загвар байдлаар боловсруулна.

Нөгөөтэйгүүр, тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан сургуулийн гамшгаас хамгаалах сургалтын материал байдаггүй. “Багшийн гарын авлага”-д тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан загвар хичээлийг оруулах талаар бодож үзнэ.

АХЗ-1-ийн хэд хэдэн уулзалтын үеэр ярилцсаны дүнд “Багшийн гарын авлага”-ын бүтцийг дараах байдлаар тогтсон.

Өмнөх үг Товчилсон үгийн тайлбар 1-р бүлэг “Аюулгүй амьдрах ухаан”-ы тухай ойлголт 1. Үндэслэл, хэрэгцээ 2. “Аюулгүй амьдрах ухаан” гэж юу вэ?
--

2-р бүлэг “Аюулгүй амьдрах ухаан”-ы сургалтын хөтөлбөр ба бусад судлагдахуун, үйл ажиллагааны уялдаа

1. Хичээл /судлагдахуун/-ийг “Аюулгүй амьдрах ухаан”-ы сургалтын хөтөлбөртэй уялдуулах боломж
2. Хичээлээс гадуурх үйл ажиллагааны цагийг “Аюулгүй амьдрах ухаан”-ы сургалтын хөтөлбөртэй уялдуулах боломж
3. Амьдрах чадварт суралцах үйл ажиллагааны цагийг “Аюулгүй амьдрах ухаан”-ы сургалтын хөтөлбөртэй уялдуулах боломж

3-р бүлэг “Аюулгүй амьдрах ухаан”-ы сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн санаа (Олон улсын кейс)

1. “Аюулгүй амьдрах ухаан”-ы сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургуулийн сургалт, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах тухай
2. Хичээлийн үлгэрчилсэн хувилбар (а. Сургуулийн өмнөх боловсрол, б. Бага боловсрол, в. Суурь боловсрол, г. Бүрэн дунд боловсрол)

2017 оны 11-р сарын 28-ны өдөр АХЗ-1 болон З-2-ын гишүүдэд чиглэсэн сургалтын материал боловсруулах талаарх сургалт уулзалт зохион байгуулсан. Уг сургалт уулзалтыг Японы сургалтын материалын жишээнээс илүү их суралцмаар байна гэсэн ажлын хэсгийн гишүүдийн хүсэлтийн дагуу явуулсан. “Гарын авлага”-ын агуулгыг нарийвчлан боловсруулах уулзалтыг 2018 оны 1-р сарын 10-12-ны өдрүүдэд хийнэ.

**Үйл ажиллагаа 3.1.3: БМДИ-ийн арга зүйчид, аймаг нийслэлийн боловсролын газрын мэргэжилтнүүдэд 3.1.1, 3.1.2-д боловсруулсан хөтөлбөр, сургалтын материалыг ашиглан сургалт явуулах.**

БСШУСЯ-ны жилийн сургалтын төлөвлөгөөнд дээрх сургалтыг оруулахын тулд 2017 оны 9-р сард болсон АХЗ-1-ийн уулзалт болон Багшийн мэргэжилт дээшлүүлэх институт (цаашид “БМДИ” гэх)-ийн захиралтай төслийн хүрээнд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөөний талаар ярилцаж зөвшилцсөн.

Багш нар, арга зүйчдийн бусад сургалтын хуваарь зэргийг харгалзан цэцэрлэг, бага, дунд боловсролын арга зүйчдийн сургалтыг 2018 оны 10-р сар орчимд хийхээр болсон.

Сургалтад хэнийг хамруулах, хаана явуулах зэрэг агуулга бүхий хэрэгжүүлэх төлөвлөгөөний тухайд 2018 оны 4-р сар орчимд ярилцахаар болсон.

**Үйл ажиллагаа 3.2.1 Төв, орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах сургалт, сурталчилгааны ажлын нэгдсэн төлөвлөгөө боловсруулах**

## 1) Нэгдсэн график төлөвлөгөөний цар хүрээ

Үйл ажиллагаа 3.2.1-ийн эхэнд АХЗ-2-ын хүрээнд хэрэгжих гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны үйл ажиллагааны одоогийн байдал болон тулгарч буй гол асуудлуудыг дараах байдлаар тодорхойлов.

- ОБЕГ болон Нийслэлийн онцгой байдлын газар (цаашид “НОБГ” гэх) нь сургалт сурталчилгааны ажлын жилийн төлөвлөгөөгөө тус тусдаа боловсруулдаг. Уг төлөвлөгөө тухайн жилдээ шинэчлэгддэггүй.
- Гамшгаас хамгаалах боловсрол, сургалтад ихээхэн дэмжлэг үзүүлдэг хандивлагчдын үйл ажиллагааг ОБЕГ болон НОБГ-ын төлөвлөгөө боловсруулахад харгалзан үздэггүй.
- Хандивлагчдын гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа, сургалтын материал боловсруулахтай холбоотой ажлуудад зохицуулалт хийгддэггүйгээс зарим хандивлагчдын үйл ажиллагаа давхарддаг.
- Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны талаарх мэдээллийг олон нийтэд хангалттай хүргэж чаддаггүй.

Дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах үйл ажиллагааг санал болгосон.

- Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа явуулах голлох байгууллагуудын үйл ажиллагааны мэдээллийг нэгтгэж, сургалтын товыг байнга шинэчлэх.
- Засгийн газрын болон хандивлагч байгууллагууд нэвтрэх эрх бүхий веб хуудастай болж, гамшгаас хамгаалах боловсрол, сургалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг байршуулан удирдах. Тогтвортой ажиллах үүднээс веб хуудас нь энгийн систем, дизайнтай байх ба мэдээллийг шинэчлэхэд хялбар байх талаас нь бодолцох.
- Жилийн төлөвлөгөөнд хандивлагчдын үйл ажиллагааг тусгаж оруулах.
- Төрийн болон хандивлагч байгууллагууд мэдээлэл солилцох мэйлинг лист систем ашиглаж, ажиллуулах

Гол үйл ажиллагаа эхлэхийн өмнө Мьянмар болон Непалын платформ үүсгэсэн жишээг танилцуулж, судалж үзсэн.

## 2) Сургалт сурталчилгааны нэгдсэн график төлөвлөгөө хөгжүүлэх

<Үйлдлийн систем>

Нэгдсэн график төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэхийн тулд АХЗ-2-ын хүрээнд

анхны үйлдлийн системийн төслийг гаргасан бөгөөд АХ-ын хурлаар гамшгаас хамгаалах сургалт сурталчилгаа явуулдаг байгууллагуудыг урьж оролцуулахаар болсон.

АХ-ийн уулзалтын үр дүнд ОБЕГ-ын ГУСГ гол удирдлагаар хангаж, БЗХАГ-ын дэмжлэгтэй ажиллах “Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны баг” бүрдсэн ба Нэгдсэн график төлөвлөгөөний тухайд Дэлхийн зөн Монгол ОУБ-ын дэмжлэгтэйгээр ажиллах юм. Багийн зорилго, бүтэц, гишүүдийн үүрэг хариуцлагын талаар заасан үйл ажиллагааны дүрмийг ОБЕГ-ын дарга баталсан.

Нэгдсэн график төлөвлөгөөгөөр хүргэх мэдээлийн нарийвчилсан агуулгын тухайд Мьянмар болон Непалын жишээн дээр ярилцсан. Үүний үр дүнд гол чухал мэдээлэл болох “Хэзээ (хугацаа)”, “Хэн (зохион байгуулагч)”, “Хаана (байршил)” болон “Ямар үйл ажиллагаа” гэсэн гол агуулгууд харагдах бүтэцтэй байхаар болсон. Түүнчлэн мэдээлэл оруулах системийн тухайд холбогдох байгууллагууд мэдээллээ түвэггүй оруулах талаас нь бодолцож боловсруулсан.

Нэгдсэн график төлөвлөгөөг байршуулахын тулд дараах хоёр веб хуудсыг судалсан.

- Дэлхийн зөн Монгол ОУБ-ын дэмжлэгтэй хөгжүүлсэн, ОБЕГ болон Нийслэл, аймаг, дүүргүүдийн ОБГ-ын гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааны ажил хэрэгжүүлсэн мэдээллийг нийтлэх веб хуудас (<http://ontsgoisur.gov.mn/>)
- Азийн гамшгийн бэлэн байдлын төв (цаашид “ADPC” гэх)-ийн дэмжлэгтэй хөгжүүлсэн, Монгол улсад гамшгаас хамгаалах чиглэлээр хандивчлагчдын хэрэгжүүлж ирсэн төслүүдийн мэдээллийг цэгцлэх зорилготой веб хуудас (<http://www.ontsgoi.gov.mn/>)

Сүүлийн веб хуудас нь төслүүдийг хамрагдах нутаг дэвсгэр болон хэрэгжилтийн хугацаагаар нь хайх функцтэй бөгөөд хайлт хийх нь Нэгдсэн график төлөвлөгөөний системд шаардлагатай үзүүлэлт юм. Тиймээс уг ([www.ontsgoi.gov.mn](http://www.ontsgoi.gov.mn)) веб хуудсыг ADPC-ээс ОБЕГ-т албан ёсоор ашиглах эрхийг хүлээлгэн өгсний дараа Нэгдсэн график төлөвлөгөөний зориулалтаар ашиглаж, хөгжүүлэхээр болсон.

ADPC-ийн хөгжүүлсэн веб хуудас нь бие даасан сервергүй, одоогоор шинэ веб хуудас нэмж ажиллуулахад багтаамжийн хувьд хүрэлцэхгүй ОБЕГ-ын серверт байршуулахаас өөр аргагүй болохыг ажлын хэсгийн гишүүд 2017 оны 9-р сард мэдсэн. Уг шалтгааны улмаас Нэгдсэн график төлөвлөгөөг ADPC-ийн веб хуудсанд байршуулах боломжгүй болсон ба өөр арга зам хайх шаардлагатай болсон.

<Багийн мэйлинг лист >



Гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааны багийн мэйлинг лист (mdptteam@googlegroups.com)-ийг Google групп ашиглан байгуулсан. Туршилтын хугацаанд үйл ажиллагааны дүрмийг эцэслэн баталсан.

<Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны багийн ээлжит уулзалт >

Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны багийн уулзалтыг 2017 оны 5-р сарын 23, 2017 оны 6-р сарын 28-ны өдрүүдэд зохион байгуулсан. ОБЕГ, НОБГ, БСШУСЯ, ШУА-ийн Одон орон геофизикийн хүрээлэн (цаашид “ООГФХ” гэх), Дэлхийн зөн ОУБ, Японы Хүүхдийг ивээх сан, НҮБХХ зэрэг байгууллагууд багийн удирдах зөвлөлийн гишүүний хувиар оролцож, сургалт сурталчилгааны багийн үйл ажиллагааны дүрмийн талаар хэлэлцсэн. Багаас ээлжит уулзалтыг гурван сар тутамд зохион байгуулахаар тогтсон.

Эхний ээлжит уулзалт нь 2017 оны 9-р сарын 29-нд болсон ба “Гамшгаас хамгаалах олон улсын өдөр”-ийг зохион байгуулах асуудлаар ярилцсан. Уулзалтын үеэр мэйлинг лист болон веб хуудас ашиглалтыг сайжруулах талаар ярилцсан.

**Үйл ажиллагаа 3.2.2 Гамшгийн эрсдэлийг бүүрүүлэх сургалт, сурталчилгааны материал боловсруулах, зорилтот бүлгийн сургалтыг сонгогдсон бүс нутагт зохион байгуулах**

**1) Орон нутгийн гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааны материал боловсруулах**

Сургалтын материал шинээр боловсруулахын өмнө орон нутгийн гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааны чиглэлээр одоо байгаа сургалтын материалыг цуглуулж, жагсаалт гаргасан (Үйл ажиллагаа 3.1.2-той хамааралтай).

Тэдгээрийн нэг нь НҮБХХ-өөс боловсруулж, ОБЕГ-ын удирдлагаас баталсан “Иргэд”, “Сайн дурынхан”, “Ажилтан албан хаагчид”-д чиглэсэн гамшгаас хамгаалах сургалт явуулах сургалтын хөтөлбөр, сурах бичиг юм. ОБЕГ болон холбогдох байгууллагуудын гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааны ажил нь дээрх хөтөлбөртэй уялдаатай явагддаг бөгөөд төслийн багаас “иргэд”-д зориулсан сурах бичиг, сургалтын хөтөлбөрийн агуулгатай нарийвчлан танилцсан. Сурах бичигт гамшгаас хамгаалах сургалт, дадлагын агуулгын талаар нарийвчлан тайлбарласан байсан ба нөгөө талаас орон нутгийн иргэдэд чиглэсэн илүү энгийн ойлгомжтой сургалтын материал шаардлагатай гэсэн дүгнэлтэнд хүрсэн.

Дэлхийн зөн Монгол ОУБ болон ОБЕГ-аас хэрэгжүүлж буй “Гамшигт тэсвэртэй Улаанбаатар” төслийн бүрэлдэхүүн хэсэг 3-ын үйл ажиллагаа (“Be Ready!” гэсэн

нэртэй)-ны хүрээнд орон нутгийн гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааны сургалтын багц боловсруулах ажил хийгдэж байна. “Be Ready!” сургалтын багц боловсруулахдаа ОБЕГ-ын даргын баталсан НҮБХХ-ийн сургалтын хөтөлбөрийн дагуу гамшгаас хамгаалах сургалт явуулахад шаардагдах энгийн ойлгомжтой нэмэлт сургалтын материал боловсруулах зорилготой бөгөөд манай төслийн зорилготой ижил болохыг төслийн багийн зүгээс олж мэдсэн. Ижил төстэй үйл ажиллагааны талаар мэдсэний дараа ОБЕГ-ын ГУСГ-аас хоёр төслийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах зорилгоор гамшгаас хамгаалах сургалт сурталчилгаанд хэрэглэгдэхүйц нэг багц материал боловсруулах хүсэлт тавьсан.

Энэхүү нөхцөл байдлын улмаас төслийн баг төслийн үйл ажиллагааны давхцал үүсэхээс зайлсхийх үүднээс “Be Ready!”-ийн хүрээнд ямар бүтэц, агуулга бүхий сургалтын багц хийгдэх талаар судалж үзсэн. 2017 оны 8-р сард болсон ОБЕГ, ЖАЙКА-гийн төслийн баг болон Дэлхийн зөн Монгол ОУБ-ын хамтарсан уулзалтаар ОБЕГ-ын удирдлага дор сургалтын материал боловсруулах ажилд оролцохоор болсон. Түүнчлэн ЖАЙКА-гийн мэргэжилтний баг “Be Ready!” сургалтын багц боловсруулах зарим уулзалтад оролцож тэдний боловсруулсан сургалтын материалын төсөлд санал зөвлөмж өгсөн.

Энэ хугацаанд ЖАЙКА-гийн мэргэжилтний баг Японы орон нутгийн иргэдийн гамшгаас хамгаалах сургалт, дадлагын зарим нэг жишээнээс танилцуулсан. Төслийн хүрээнд сургалтын материал боловсруулах ажлыг сургалтын загвар гаргах болон “Be Ready!”-н үйл ажиллагаатай уялдаатай байх үүднээс 2018 оны 2-р сар хүртэл хийх шаардлагатай болсон.

## **2) Туршилтын нутагт орон нутгийн гамшгаас хамгаалах сургалт, дадлага явуулах**

Төслийн хүрээнд орон нутгийн гамшгаас хамгаалах сургалт дадлага явуулах туршилтын орон нутгийг сонгох талаар АХЗ-2-ын уулзалтаар ярилцсан. Туршилтын орон нутгийг сонгохдоо хотын төвийн барилгажсан газрын хувьд насжилт өндөртэй барилга ихтэй байх, гэр хороололд газар хөдлөлтөөс бусад үер гэх мэт бусад гамшгийн эрсдэлтэй байх, орон нутагт газар хөдлөлтийн эрсдэлтэй байх зэрэг шалгуураар сонгосон. Үүний үр дүн 2017 оны 6-р сарын ХЗХ-ны хуралд туршилтын 3 орон нутгийг санал дэвшүүлсэн. Холбогдох хүмүүстэй ярилцаж, судалсны эцэст 9-р сарын эцсээр болсон Удирдах хорооны хурлаар туршилтын орон нутгийн талаар эцэслэн тогтсон. Улаанбаатар хотоос Баянгол, Баянзүрх дүүрэг, орон нутгаас Завхан аймгийг сонгосон.

Улаанбаатар хотын туршилтын 2 дүүргийн тухайд АХЗ-2-ын гишүүд 8-р сард очиж

үзсэн ба Завхан аймгийн тухайд 10-р сард холбогдох мэдээллийг цуглуулж, гамшиг, гамшгийн эрсдэлийн удирдлага болон орон нутгийн гамшгаас хамгаалах сургалтын үйл ажиллагааны одоогийн байдлын талаар дүн шинжилгээ хийсэн. Туршилтын орон нутгийн талаарх цаашдын зохицуулалтыг 2018 оны 3-р сард явуулах сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхтэй уялдуулан хийнэ.

**Үйл ажиллагаа 3.2.3 Сургалтын төвд хэрэгжүүлэх гамшгаас урьдчилан сэргийлэх гамшгийн нөхцөл байдлыг биеэр мэдрүүлэх сургалт, дадлагын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах**

Юуны түрүүнд Сургалтын төвийн хөтөлбөр, тоног төхөөрөмжийн одоогийн байдалтай танилцаж судалсан. Нийслэлийн иргэдийн гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв нь 2016 оны 10-р сард албан ёсоор байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд Хятад, Солонгос зэрэг улсад үйлдвэрлэгдсэн газар хөдлөлтийг биеэр мэдрүүлэх тавцан, гамшгаас хамгаалах сургалтын биеэр мэдрэх төхөөрөмж зэргийг ашиглан сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна.

АХЗ-2-ын үйл ажиллагааны хүрээнд сургалтын төвийн одоогийн сургалтын агуулга, хөтөлбөртэй танилцаж, одоогийн нөхцөл байдал ба тулгарч буй асуудлуудын талаар ярилцсан. Хэлэлцсэн гол асуудлууд нь дараах байдалтай байна.

- Сургалтын материал гэх зэрэг дутагдалтай байснаас үүдэн 2016 оны 10-р сард төвийн сургалтын хөтөлбөрийг хэсэгчлэн боловсруулж батлуулсан.
- Одоогийн сургалт нь ихэвчлэн сургуулийн сурагчдыг хамруулж байгаа бөгөөд сургуулийн автобусгүй сургуулийн хүүхдүүд төвд ирэх боломжоор дутмаг.
- Сургуулийн хүүхдүүд шууд хүрэлцэн суралцах боломжтой үзүүлэн таниулах материал илүү шаардлагатай.
- Газар хөдлөлтийг биеэр мэдрэх тавцанд суусны дараа үзүүлэх видео бичлэгийн газар хөдлөлтийн өмнөх анхааруулгын талаарх хэсгийг өөрчлөх шаардлагатай. Учир нь өнөөгийн байдлаар газар хөдлөлтийг урьдчилан мэдэх боломжгүй бөгөөд олонх газар хөдлөлт гэнэт болдог.
- Одоогийн сургалтын хөтөлбөрийг илүү баяжуулах үүднээс сургалтын төвд сайн дурын ажилтнуудыг ажиллуулах боломжийн талаар судлах саналыг Япон дахь сургалтаар олж авсан мэдлэгтээ үндэслэн дэвшүүлж байна

Дээрх асуудлуудад үндэслэн сургалтын төвийн хөтөлбөрийг боловсронгуй болгох уулзалтуудыг 2017 оны 5, 6-р сард зохион байгуулсан. Японы гамшгаас хамгаалах

сургалтын төвүүдийн сургалтын хөтөлбөр, агуулгыг танилцуулсны дараа хөтөлбөр нь бүхэлдээ гамшгийн талаар биеэр мэдэрч суралцах боломжтой байхаар сайжруулж ажилласан. Утаат орчноос дүрвэх сургуулилтын үед хүүхэд цээжлэхэд хялбар “О-Ха-Ши-Мо” буюу “Түлхэхгүй, гүйхгүй, ярихгүй, буцаж очихгүй” хэллэг зэрэг Японы холбогдох жишээг танилцуулсан.

Хөтөлбөрийг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх хэд хэдэн воркшоп сургалтыг явуулсан. 8-р сарын 15-нд Японы сургалтын төвд ашигладаг видео хичээл, сургалтын хөтөлбөр, 9-р сарын 21-нд Нагояа их сургуулийн Фукува профессорын зохион бүтээсэн “цаасан Бүрүрү” хэрэглэгдэхүүн зэргийг ашиглаж гамшгаас хамгаалах практик сургалт явуулах бичил воркшоп зэргийг зохион байгуулсан. Япон дахь 2 дахь сургалтад оролцогсдын зүгээс 2017 оны 11-р сарын 17-нд сургалтын төвийн багш ажилтнуудад зориулж сургалтын үеэр олж авсан мэдлэгээ хуваалцах уулзалт зохион байгуулсан ба гамшгаас хамгаалах сургалтын төвд ашиглах боломжтой сургалт, дадлагын хэрэглэгдэхүүн материалын талаар голчлон ярилцсан.

## 1-3 Хүрсэн үр дүн

### (1) Үр дүн 1

Төслийн төлөвлөлтийн матрицын (PDM) дагуу Үр дүн 1-ийн гүйцэтгэлийг дараах гурван үзүүлэлтүүдээр дүгнэнэ:

#### 1.1 Боловсруулагдсан заавар, дүрмийн тоо.

Хүрсэн үр дүн:

А/Х 1-ийн гишүүд Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, Аймаг/сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар болон УБ хот/дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, зэргийн төслүүдийг боловсруулсан байна. Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь одоогоор боловсруулагдаж байгаа.

А/Х 1 хоёр (2) зааврыг боловсруулахаар болсон байна, үүнд: 1) Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний заавар, ба 2) Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний заавар. А/Х 1-ийн гишүүдэд газар хөдлөлтийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний техникийн зааварчилгааг хүлээлгэн өгч танилцуулсан болно.

А/Х 1-ийн гишүүд ОБЕГ-ын орон зайн мэдээллийн сангийн тогтвортой үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалтыг хангахад шаардлагатай арга хэмжээний талаар санал солилцож, Орон зайн мэдээллийн сангийн заавар болон Үйл ажиллагааны гарын авлагын төслүүдийг боловсруулж эхэлсэн байна.

#### 1.2 Боловсруулсан санамж бичгийн төслийн тоо болон санамж бичгийн талаар санал авахаар үүлзсэн талууд

Хүрсэн үр дүн:

Гурван (3) салбарын санамж бичгийн тухайд, "мэдээлэл, харилцаа холбоо" болон "түлш, шатахуун"-ы тухай санамж бичгийн агуулгыг боловсруулж дууссан байна. ЭМЯ-тай байгуулах "эм бэлдмэл"-ийн тухай санамж бичгийн төслийг боловсруулж, одоогоор санал авах үе шатанд байна. Үүнээс гадна, "хүнс", "хоргодох байр/түр сууц", "цэвэр, бохир ус" гэсэн гурван салбаруудад санамж бичиг байгуулахаар төлөвлөсөн болно. Эдгээр санамж бичгийн төслүүдийг боловсруулж дууссан бөгөөд, ХХААХҮЯ, БХБЯ, УБ хотын УСУГ-тай санал солилцож байна.

### 1.3 Гамшгаас хамгаалах цагаан ном

Хүрсэн үр дүн:

Үйл ажиллагаа 1.3.4-т дурдсаны дагуу, Цагаан номд 39 материал оруулахаар төлөвлөсөн байна. 2017 сарын 10-р сарын эцсийн байдлаар 7 төрлийн материал цуглуулсан байна.

#### **(2) Үр дүн 2**

Төслийн төлөвлөгөөний матрицын (PDM) дагуу Үр дүн 2-ийн гүйцэтгэлийг дараах хоёр үзүүлэлтүүдээр дүгнэнэ.

#### 2.1 Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний заавар: газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний сургалтын оролцогчдын тоо

Энэ хугацааны гүйцэтгэл:

А/Х 2 энэхүү зааврыг саяхан боловсруулж эхэлсэн байна. Японы барилга, байгууламжийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний технологи дамжуулалтын хувьд, 2017 оны 6-р сарын 27-ны өдөр Газар хөдлөлт тэсвэрлэлтийн хязгаарын индекс Iso-ын үндсэн ойлголтын талаар семинар зохион байгуулсан байна. Энэхүү семинарт 25 оролцогчид ирсэн байна.

Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний зааврын төслийг боловсруулсны дараа энэхүү зааврыг тайлбарлах сургалт семинаруудыг 10-р сарын 26-ны өдөр ОБЕГ-т 42 хүн, 10-р сарын 27-ны өдөр МХЕГ-т 17 хүн, 11-р сарын 8-нд БХТ-д 40 хүнд зохион байгуулсан байна.

#### 2.2 Хүчитгэлийн заавар: хүчитгэлийн сургалтын хөтөлбөрүүдийн тоо

Энэ хугацааны гүйцэтгэл:

Энэ хугацаанд хүчитгэлийн техник аргачлалын талаар сургалт зохион байгуулаагүй байна.

#### **(3) Үр дүн 3**

Төсөл төлөвлөлтийн матрицын дагуу Үр дүн 3-ын үйл ажиллагааг дараах 2 шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

#### 3.1 Төслийн хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр зохион байгуулагдсан сургалтын тоо

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

АХЗ нь гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааны хөтөлбөр, сургалтын материалыг бэлдэж эхлэх шатандаа явж байгаа бөгөөд тоон үзүүлэлтээр үнэлэх шатанд хүрээгүй байна.

### 3.2 Сургалтын төвөөр үйлчлүүлэгчдийн тоо

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

АХЗ нь сургалтын төвийн гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааны хөтөлбөр, сургалтын материалыг боловсронгуй болгох ажил хийгдэж эхэлсэн боловч тоон үзүүлэлтээр үнэлэх шатанд хүрээгүй байна.

## **1-4 Төслийн зорилтын хүрээнд хүрсэн үр дүн**

Төслийн төлөвлөлтийн матрицын (PDM) дагуу Төслийн зорилтын гүйцэтгэлийг дараах хоёр үзүүлэлтүүдээр дүгнэнэ.

### 1. Батлагдсан заавар, санамж бичгийн тоо

### 2. Шинээр боловсруулсан болон шинэчлэн сайжруулсан гамшгийн эрсдэлийг бууруулах мэдээллийн тоо

Хүрсэн үр дүн:

Заавар, санамж бичиг, барилгын газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээ болон хүчитгэлийн норм норматив, сургалтын материал зэргийг боловсруулах ажлыг А/Х тус бүр үргэлжлүүлэн явуулж байна. Төслийн дараах тогтвортой хэрэгжүүлэлтийг хангах үүднээс, Төслийн хүрээнд боловсруулах заавар болон бусад үр дүнг ОБЕГ, БХБЯ эсвэл БСШУСЯ-ны зохих журмын дагуу батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.

## **1-5 Эрсдэлийн өөрчлөлт болон эрсдэлийг бууруулах арга хэмжээ**

### **(1) Үр дүн 1**

#### **1) Заавруудын агуулгын өөрчлөлтийн тухай**

Төсөл эхлэх үед, Үр дүн 1-ийн хүрээнд таван (5) заавар боловсруулахаар төлөвлөсөн бөгөөд, үүнд: "Эрсдэлийн үнэлгээний заавар", "Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний заавар", "Гамшгаас хамгаалах бэлэн байдлын заавар", "Гамшгаас

хамгаалах хяналтын заавар" болон "Гамшгаас хамгаалах мэдээллийн сангийн заавар" зэрэг болно. Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдахаас өмнө боловсруулж, баталсан Төслийн төлөвлөлтийн матрицын (PDM) дагуу эдгээр заавруудыг боловсруулахаар төлөвлөсөн байна.

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зааврыг гамшгаас хамгаалах бэлэн байдлын болон урьдчилсан арга хэмжээний зэргийг тогтоох чиглэлтэйгээр боловсруулна гэж тооцоолсон ба, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний зааврыг газар хөдлөлтийн үед гамшгийн хохирлыг бууруулахад зориулсан хөрөнгө оруулалтын удирдлага зохион байгуулалтыг хангах чиглэлтэйгээр боловсруулна гэж тооцоолж байв. Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд үндэслэн дээр дурдсан хоёр (2) зааврыг боловсруулах шаардлагатай гэж үзсэн боловч шинээр батлагдсан Гамшгаас хамгаалах тухай хуульд эдгээр 2 зааврыг боловсруулах үндэслэлтэй холбоотой заалтууд өөрчлөгдсөн эсвэл хасагдсан байна. Иймээс, Төслийн хүрээнд энэхүү 2 зааврыг боловсруулах чиглэлийг өөрчлөх шаардлагатай байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.2, 10.8, 11.1-ийн заалтуудыг "Гамшгаас хамгаалах бэлэн байдлын заавар"-тай хамааралтай гэж анх үзэж байв. Гэвч, эдгээр зүйл, заалтууд нь цагдаа, тагнуул, цэргийн албатай холбоотой үйл ажиллагааг тодорхойлсон байна. Эдгээр үйл ажиллагааны зарим хэсэг болон холбогдох мэдээлэл нь улсын нууцад хамаарах учраас Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зааврыг ЖАЙКА-гийн Төслийн хүрээнд боловсруулах боломжгүй юм. Иймээс Төслийн хүрээнд боловсруулж байгаа "Гамшгаас хамгаалах бэлэн байдлын заавар"-ыг бие даасан байдлаар бус, "Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний заавар"-ын нэг хэсэг болгож тусгана.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 12.2-т "гамшгаас хамгаалах хяналт"-ын тухайд "гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч" холбогдох байгууллагад хяналт тавина гэж заасан бөгөөд ОБЕГ-ын гамшгаас хамгаалах улсын хяналтыг улсын хяналтын байцаагч бие даан хэрэгжүүлдэг учраас тус зааврыг боловсруулахад ЖМБ-ын зүгээс дэмжлэг үзүүлэх боломжгүй байна.

Дээрх байдлаас үзэхэд, Төслийн хүрээнд гурван (3) заавар боловсруулагдана, үүнд: "Эрсдэлийн үнэлгээний заавар", "Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний заавар", "Гамшгаас хамгаалах мэдээллийн сангийн заавар" болно. Энэ нөхцөлд, Төслийн төлөвлөлтийн матрицад (PDM) тусгасан Үйл ажиллагаа 1.1.3-ын Тэмдэглэл 1 - 1-ийн агуулгад ОБЕГ-тай зөвлөлдөж өөрчлөлт оруулах шаардлагатай.

**2) Монгол улсад заавар тус бүрийг боловсруулахад Японы материалуудыг**



### **хэрхэн ашиглах тухай**

Монголын тал нь Япон улсын гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас гамшгаалах төлөвлөгөө, төлөвлөгөө боловсруулах заавар, гамшгаас хамгаалах санамж бичиг гэх зэргийн талаар ихэд сонирхож, холбогох мэдлэг мэдээллийг эзэмших хүсэлтэй байна. Иймээс, Монголын тал Япон улсын гамшгаас хамгаалах үндсэн төлөвлөгөө, орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө, яам тус бүрийн гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөө, гамшгаас хамгаалах санамж бичиг зэрэг материалуудыг бүхэлд нь орчуулуулж авах хүсэлтэй байгаа юм.

Гэвч, Монголын тал нь эдгээр материалуудын бүрэн орчуулгыг хүлээн авч, тэдгээрийг тэр чигт нь өөрчлөлгүйгээр авч хэрэглэх тохиолдолд Монгол улсад хэрэгжих боломжгүй төлөвлөгөө, санамж бичгүүдийг боловсруулах эрсдэл байгаа юм. Ийм учраас, ЖМБ нь зөвхөн гамшгаас хамгаалах төлөвлөгөө, санамж бичиг гэх зэргийг боловсруулахад шаардагдах мэдээлэл, материалыг үзүүлсэн болно. А/Х-үүд энэ асуудал дээр санал бодлоо солилцож, Монгол улсад хэрэгжих боломжтой баримт бичиг боловсруулах шаардлагатай байна.

### **3) Мэдээллийн сангийн удирдлага зохион байгуулалтыг хариуцах боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх тухай**

ОБЕГ-ын мэдээллийн сангийн удирдлага зохион байгуулалтын нэгэн гол бүрэлдэхүүн хэсэг нь боловсон хүчний чадавхийг сайжруулах асуудал юм. ОБЕГ сүүлийн үед бүтцийн өөрчлөлт хийж, шинэ газар, хэлтсүүд байгуулагдсан. ОБЕГ-ын шинэ бүтцийн хувьд, мэдээлэл технологийн нэгжийн ажилтнуудын тоо цөөн байна. Мэдээллийн сан болон мэдээлэл технологийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагаанд шаардагдаж буй боловсон хүчний хомсдол нь ОБЕГ-ын одоогийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна. А/Х 1-ийн хариуцаж байгаа орон зайн мэдээллийн сан болон гамшгийн мэдээ мэдээлэл хамтран ашиглах системийг боловсруулж дууссаны дараа ОБЕГ-т энэхүү системийг бие даан хэвийн үйл ажиллагааг нь хариуцан хангах чадвартай мэргэжлийн боловсон хүчин байхгүй тохиолдолд, системийг ОБЕГ-ын үйл ажиллагаанд нэвтрүүлж, орон зайн мэдээллийн сангийн тогтвортой үйл ажиллагааг хангахад бэрхшээлтэй байх болно.

Боловсруулж байгаа системийг ОБЕГ-ын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, Төсөл хэрэгжиж дууссаны дараахь орон зайн мэдээллийн сангийн тогтвортой үйл ажиллагааг хангах үүднээс А/Х 1 ОБЕГ-т Орон зайн мэдээллийн сангийн удирдлагын шинэ нэгж байгуулах санал дэвшүүлсэн болно. ОБЕГ-ын дарга энэхүү саналыг зөвшөөрч, ОБЕГ нь удирдлагын нэгжийг байгуулах ажлыг 2017 оны 7-р сард

эхлүүлсэн байна.

## **(2) Үр дүн 2**

### **1) Монгол улсын норм, нормативуудыг боловсруулах тухай**

Төслийн 1-р үед боловсруулсан дундаж өндөртэй болон өндөр барилгуудын зааврыг ашиглахгүй учир, зааврыг илүү үр дүнтэй болгох үүднээс А/Х 2 БХБЯ-ны боловсруулсан Монгол улсын норм, нормативуудыг мөрдөхөөр шийдсэн байна. Нөгөө талаас, албан ёсны норм, нормативыг мөрдөхөд цаг их шаарддаг байна. Жишээлбэл, ажлын удирдамжийг бэлтгэж холбогдох мэргэжлийн зөвлөлөөс зөвшөөрөл авахад шаардагдах цаг, ажлын удирдамжийг баталж БХБЯ-аас зөвшөөрөл авахад шаардагдах цаг, ЗҮБ-ын үйл ажиллагаанд шаардагдах цаг болон бусад холбогдох үйл ажиллагаанд шаардагдах цаг, ажил хөдөлмөр нь Төслийн ахицыг саатуулсан байна.

Төслийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх үүднээс, А/Х 2 нь ЖМБ-тай хамтран ажлын удирдамжийг бэлтгэж, ЗҮБ болон холбогдох мэргэжлийн зөвлөлд урьдчилан тайлбар өгсөн байна.

А/Х 2 нь ЗҮБ-т зааврын төсөл боловсруулахад нь дэмжлэг үзүүлэх үүднээс, заавар бүрийн анхны загварыг боловсруулж, анхны зааврыг Монгол улсын нөхцөл байдалд хэрхэн тохируулах тал дээр тогтмол санал солилцсон байна.

### **2) Багаж, хэрэгсэл ашиглан үнэлгээний зааврыг тайлбарлах тухай**

Монголын олон норм, норматив, журмууд уншигчид ойлгоход тус болох зураг график, хүснэгт, жишээ тооцоонуудыг агуулаагүй байдаг.

Ийм учраас, зааврын агуулгыг уншагчдад хялбархан ойлгуулахын тулд, зааварт газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээний жишээ тооцоонууд болон хүчитгэлийн ажлын жишээнүүдийг тусгахаар А/Х 2 болон ЗҮБ шийдсэн байна. Мөн түүнчлэн, А/Х 2 зураг график, зургийн бэлтгэлийг ЗҮБ-ын зүгээс хариуцах хүсэлтийг ЗҮБ-т гаргасан байна.

Хүнд тооцоолол шаардагдсан зааврууд нь газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээ хийхтэй холбоотой зарим ажилтнуудад хэрэгжүүлэхэд түвэгтэй байж болзошгүй бөгөөд зарим тохиолдолд ийнхүү хүнд тооцооллыг хийх шаардлагагүй байж болно.

Энэ нь Монголын инженерүүд Монгол улсад Японы газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээний технологийг нэвтрүүлэх анхны туршилт болж байгаа учир, А/Х 2 нь ЗҮБ-ын гишүүдэд Японы үнэлгээний арга зүйг ойлгуулах үүднээс Excel-д хөрвүүлсэн

үнэлгээний хүснэгтүүдийг ашиглан хэд хэдэн жижиг сургалтуудыг зохион байгуулсан байна.

Энэхүү сургалтууд нь үнэлгээ хийх арга зүй болон төрөл бүрийн аргачлалын давуу ба сул талуудыг ойлгуулах чухал ач холбогдолтой байсан бөгөөд үүний үр дүнд, ЗҮБ-ын бүх инженерүүд Японы арга зүйг Монголын заавруудад тусгахыг хүлээн зөвшөөрсөн байна. Энэхүү багаж, хэрэгслийг зөвхөн Төслийн хүрээнд биш, Төслийн дараа ч сургалт зохион байгуулахад ашиглаж болохыг онцолсон байна.

### **(3) Үр дүн 3**

#### **1) Техник хамтын ажиллагааны төслийн үйл ажиллагааг илүү сайн ойлгох**

Энэхүү төсөл нь ОБЕГ-ын техник хамтын ажиллагааны анхны төсөл юм. Төслийн баг болон Монголын тал юу хийх ёстой талаар зарим нэг эндүүрэл гарч байсан. ОБЕГ-ын хэрэгжүүлж ирсэн гадаадын тусламжийн төслийн ихэнх нь төслийн гол үйл ажиллагааг тухайн төслийн баг хийж гүйцэтгэж ирсэн бөгөөд үйл ажиллагаанд ОБЕГ-ын оролцоо хязгаарлагдмал байсан. Ийм нөхцөл байдлын улмаас төслийн холбогдох байгууллагын газар, хэлтсийн дарга нар төслийн үр дүнд хүрэхэд хэр хугацаа зарцуулах талаар тэр бүр сайн ойлголтогүй байсан ба хамтран ажиллагчид нь үндсэн ажил үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан цаг завгүй байх тохиолдол гарч байсан. Тэд төслийн үйл ажиллагаа болон өөрийн үндсэн ажил үүргийн аль нэгийг гүйцэтгэхээс өөр аргагүй байдалтай тулгарах тохиолдол гарч байсан.

Монголын талын хамтран ажиллагсдыг төслийн үйл ажиллагаанд илүү таатай байдлаар оролцуулан ажиллуулахын тулд Төслийн багаас тэдний удирдлагуудад тогтмол тайлбар өгөх, үйл ажиллагааг тайлагнах, зөвлөлдөх гэх мэт үйл ажиллагааг зохион байгуулсан. Түүнчлэн төслийн үйл ажиллагааны процедурын талаар хамтран ажиллагчдад нэг бус удаа тайлбарлаж ирсэн.

#### **2) Бусад төслүүдтэй зохицуулалт хийх хэрэгцээ шаардлага**

Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг сайжруулахад гол ач холбогдол өгсөн Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан ГЭБ-ын боловсрол, сургалттай холбоотой зарим төсөл бусад хандивлагч байгууллага, ТББ-уудын шугамаар боловсруулагдан хэрэгжиж байна. Энэхүү төслийн үйл ажиллагаатай ижил төстэй, хамааралтай агуулгууд бусад төслийн хүрээнд төлөвлөгдсөн байсан ба төслүүдийн үр дүнг нэмэгдүүлэх, давхцлыг бууруулах үүднээс үйл ажиллагааг уялдуулах нь чухал.

Үйл ажиллагаа 3.2.1 нь ГЭБ сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг илүү үр дүнтэй

хэрэгжүүлэхэд хамтрагч талуудын хоорондын уялдаа холбоог сайжруулахад чиглэгдсэн. Уг үйл ажиллагаа одоогоор эхний шатандаа явж буй боловч үйл ажиллагаа 3.2.1-ийн хүрээнд нэвтрүүлэх системийн тусламжтайгаар цаашид холбогдох байгууллагууд ГЭБ сургалт, сурталчилгааны мэдээллийг илүү их солилцож ажиллана гэж төсөөлж байна. Цаашид ОБЕГ холбогдох талуудын үйл ажиллагааны давхцлыг багасгах зохицуулалтыг хийнэ гэж үзэж байна.

Түүнчлэн БСШУСЯ, Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын хамтарсан Сургууль цэцэрлэгийн Цогц Аюулгүй байдал (CSS) хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд хөтөлбөр нь ГЭБ сургуулийн үйл ажиллагаанд оролцогч талуудын үйл ажиллагааг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх зохицуулалтыг бий болгож байна. Төслийн баг нь дээрх санаачлагын хүрээнд ГЭБ сургуульд зориулсан бусад сонирхогч талуудын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг авч ажиллана.

Төслийн баг зохицуулалтын арга хэмжээний тогтвортой байдлыг хангах үүднээс дээрх хоёр төслийн холбогдох талуудтай хамтран ажиллах болно.

### **3) ADPC-ийн веб хуудас хүлээлгэн өгөх болон вебийн үйл ажиллагаа**

Төслийн багаас нэгдсэн график төлөвлөгөө байрлуулан ажиллуулахаар төлөвлөж байсан ADPC-ын веб хуудсыг ОБЕГ 9-р сард хүлээн авсан. Одоогийн гол бэрхшээл нь боловсруулсан вэб хуудсын өгөгдлийн эх сурвалжийг шилжүүлэхэд ОБЕГ-ын серверийн хүчин чадал хүрэхгүй байгаа явдал юм. Тэрхүү төслийн хэрэгжилтийн явцад энэ талаар ОБЕГ болон ADPC хангалттай ярьж тохироогүй байсан. 2017 оны 9-р сарын байдлаар ОБЕГ нь Азийн хөгжлийн банк (цаашид "АХБ" гэх)-ны санхүүжилтээр серверийн хүчин чадлаа нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгаа боловч серверийн хүчин чадлыг нэн даруй нэмэгдүүлнэ гэсэн баталгаа одоогоор байхгүй байна.

Тиймээс нэгдсэн график төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга замын тухайд ОБЕГ-ын одоогийн серверийн хүчин чадал болон мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийн чадвар бололцооны хүрээнд дахин зохицуулалт хийх шаардлагатай байна. Тохирох хүчин чадал бүхий серверт мэдээлэл байршуулж, чухал мэдээллүүдийг цуглуулах, иргэд олон нийтэд мэдээллийг нээлттэй болгох нь нэн чухал гэсэн ОБЕГ-ын чиг хандлагыг нэмэгдүүлэх талаар ярилцах шаардлагатай. Төсөв батлуулах замаар серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх эсвэл боломжит эх үүсвэрийг ашиглах замаар өгөгдөл хадгалалтын найдвартай байдлыг хангах тал дээр ЖАЙКА-гийн мэргэжилтний багаас үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэн ажиллана.

### **1-6 ЖАЙКА-гийн зүгээс хариуцсан үйл ажиллагааны явц**

Газар хөдлөлтийн чичирхийллийг биеэр мэдрүүлэх тоног төхөөрөмжийг Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт аргагүйн төвд нийлүүлэхтэй холбоотой ажлыг ЖАЙКА-гийн Төв дээр эхлүүлсэн байна. Гэвч тоног төхөөрөмжийг нийлүүлэх хугацаа нь Японы талын холбогдох шалтгааны улмаас 2018 оны 2-р хагас болж хойшлогдоод байна. Тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн хугацааны талаар ОБЕГ-т тайлбар өгсөн бөгөөд ийнхүү нийлүүлэлтийн хугацаа хойшилсон асуудал дээр анхаарч, нийлүүлэлтийн явцын талаар цаг тухайд нь Монголын талд мэдэгдэх шаардлагатай байна.

Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ хийх багажын нийлүүлэлтийн тухайд, ЖАЙКА-гийн Монгол дахь төлөөлөгчийн газар нийлүүлэх ажлыг эхлүүлсэн бөгөөд 2018 оны 5-р сарын сүүлээр нийлүүлэх ажлыг дуусгана. Үнэлгээний багажын ашиглалттай холбоотой сургалтын үйл ажиллагааг нийлүүлэлтийн үйл ажиллагаа дууссаны дараа эхлүүлэхээр төлөвлөсөн байна.

### **1-7 Монгол улсын Засгийн газрын зүгээс хариуцсан үйл ажиллагааны явц**

Үр дүн 2: БХТ нь ОБЕГ, БХБЯ нартай зөвлөлдөн Ажлын удирдамжийг хянаж, Монголын барилгын инженерүүдийн холбоог (цаашид "МБИХ" гэх) барилга, байгууламж, Сарт Шарайд ХХК-г дэд бүтэц, инженерийн шугам сүлжээг тус тус хариуцуулахаар ЗҮБ-ын бүрэлдэхүүнд оруулсан байна.

Үр дүн 3: БСШУСЯ “Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөр”-ийг 2017 оны 12-р сард батлуулахаар ажиллаж байна.

### **1-8 Байгаль орчны болон нийгмийн үйл ажиллагааны явц (хэрэгжүүлэх тохиолдолд)**

N/A

### **1-9 Жендерийн эрх тэгш байдал/Энхийг дэмжих/Ядүүрал бууруулах үйл ажиллагааны явц (хэрэгжүүлэх тохиолдолд)**

N/A

**1-10 Төсөлтэй холбоотой анхаарвал зохих асуудал (жишээлбэл: ЖАЙКА-гийн бусад төслүүд; төсөл хамтран хэрэгжүүлэгч байгууллага, бусад донор орнуудын төсөл, хувийн хэвшил, төрийн бус байгууллага гэх мэтийн үйл ажиллагаа)**

Үр дүн 3: БСШУСЯ нь Дэлхийн зөн Монгол ОУБ-тай хамтран сургуулийн гамшгаас хамгаалах холбогдох талуудад мэдээлэл хүргэх боловсролын платформ байгуулахаар ажиллаж байна. Мэдээлэл хуваалцах зорилгоор ЖАЙКА-гийн мэргэжилтний багийн үр дүн 3-ын мэргэжилтнүүд уг үйл ажиллагаанд ажиглагчаар оролцоно.

Үр дүн 3: Дэлхийн зөн Монгол ОУБ гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааны сургалтын материал боловсруулах тал дээр ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй нь тодорхой болсон. ЖАЙКА-гийн мэргэжилтний багийн үр дүн 3-ын мэргэжилтнүүд энэ тухайд, гамшгийн төрлөөр сургалтын материал боловсруулах хуваарилалт хийх чиглэлээр ОБЕГ-тай ярилцаж байна.

## **2. Ажлын төлөвлөгөөнд гарсан саатал ба/эсвэл асуудал (гарсан тохиолдолд)**

### **2-1 Асуудлын талаарх мэдээлэл**

N/A

### **2-2 Учир шалтгаан**

N/A

### **2-3 Авах арга хэмжээ**

N/A

### **2-4 Хариуцах ажилтан/байгууллагын үүрэг (ЖАЙКА, Монгол улсын Засгийн газар, гэх мэт.)**

N/A

## **3. Төслийн хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөнд оруулсан өөрчлөлт**

### **3-1 РО**

N/A

### **3-2 Нарийвчилсан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөнд орсон бусад өөрчлөлт**

(Жич: Х/Т болон ТТМ-д орох өөрчлөлтүүдийг (төслийн нэр, үргэлжлэх хугацаа, төсөл хэрэгжүүлэх газар(ууд), зорилтот бүлэг(үүд), хэрэгжүүлэлтийн бүтэц зохион байгуулалт, ерөнхий зорилт, төслийн зорилго, үр дүн, үйл ажиллагаа болон зохион байгуулалт) ЖАЙКА-гийн Төв байгууллага батална. Хэрэв төслийн баг Х/Т болон ТТМ-д ямарваа нэгэн өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл, төслийн баг нь оруулах өөрчлөлтийн төслийг боловсруулж санал болгож болно.)

N/A

#### **4. Төсөл дууссаны дараа Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэх үйл ажиллагааны бэлтгэл ажил**

Энэ хугацаанд тодорхой бодлого, арга хэмжээний талаар хэлэлцэж санал солилцоогүй байна.

## **II. Төслийн хяналтын хуудас      *доор хавсаргав***

**Project Monitoring Sheet I Ver. 3.0 (Term: June, 2017 - November, 2017)**

**Project Title:** Project for Strengthening the National Capacity of Earthquake Disaster Protection and Prevention in Mongolia  
**Implementing Agency:** National Emergency Management Agency (NEMA)  
**Target Group:** NEMA, Ministry of Construction and Urban Development, Ministry of Education, Culture and Science, General State Inspection Agency, Emergency Management Department of the Capital City (EMDC), Construction Quality and Safety Department, Master Planning Agency of Capital City  
**Period of Project:** December 2016 to November 2019  
**Project Site:** Mongolia

**Version 3**  
**Dated January 17, 2018**

Narrative Summary		Objectively Verifiable Indicators	Means of Verification	Important Assumption	Achievement	Remarks
<b>Overall Goal</b> Seismic risk will be reduced.	<ol style="list-style-type: none"> <li>Number of the approved guideline, rules, provisions</li> <li>Number of white paper open to public</li> <li>Number of the executed seismic assessment</li> <li>Number of the seismic strengthened building</li> <li>Number of implemented activities on disaster risk reduction education</li> </ol>	Study by NEMA	The policy on disaster risk reduction will not be changed in Mongolia.			
<b>Project Purpose</b> The Capacity of National Emergency Management Agency will be enhanced through the activities for strengthening the countermeasures for seismic risk.	<ol style="list-style-type: none"> <li>The number of the approved guidelines and agreement</li> <li>The number of the data on disaster risk reduction which newly established and improved</li> </ol>	Project report	NEMA expands the pilot activities in other aimags and sums.	Activities for developing guidelines, agreements, standards of seismic diagnosis and strengthening, teaching materials have been continued at each WG.	In order to ensure sustainability after the Project, each WG makes it a goal to get an approval of guidelines and other related outputs which will be developed in the Project from NEMA, MCUD or MECSS through their standard procedures.	
<b>Outputs</b> 1. Capacity for data collection on disaster risk reduction and coordination among related organizations will be enhanced.  2. Capacity of public administration officer related with the seismic assessment and seismic strengthening for buildings will be enhanced.  3. Implementing plan on disaster risk reduction education and awareness raising activities will be developed and realized.	<ol style="list-style-type: none"> <li>The number of guidelines, operational rules, provisions which are developed. <ol style="list-style-type: none"> <li>The number of the draft of agreement developed and participants who participated in the training programs on agreements</li> <li>White paper on disaster risk reduction</li> </ol> </li> <li>Guideline for seismic assessment The number of the participants in the training program on seismic assessment</li> <li>Guideline for seismic strengthening The number of the training program on seismic strengthening</li> <li>The number of the cases of delivering classes on disaster risk reduction based on the activities of the Project</li> <li>The number of visitors in Training Center</li> </ol>	Project report  Project report  Ordinance of Ministry of Education, Culture and Science  Ordinance of NEMA	<ol style="list-style-type: none"> <li>The counterparts from NEMA, the Ministry of Construction and Urban Development and the Ministry of Education continue to work in the same position.</li> <li>Participants in training programs continue to work in the same position.</li> <li>The relation among related organizations is maintained.</li> <li>Exchange information is maintained among the related organizations.</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>The WG1 has drafted three (3) guidelines for national earthquake disaster operation planning, aimag / soum level earthquake disaster protection planning and draft UB City / District level earthquake disaster protection planning. And also, The WG1 members decided to develop two (2) guidelines for earthquake risk assessment, namely general risk assessment guideline and detailed risk assessment guideline.</li> <li>Three (3) fields, namely, "information / communication", "fuel" and "medicine" were selected as fields for establishing the agreement during the Project period. Agreements on "information / communication" and "fuel" are completed. Draft agreement on "medicine" between Ministry of Health is prepared and under discussion.</li> <li>Thirty-ninth (39) items scheduled to be included in the white paper. 7 items were collected at the end of October 2017.</li> <li>The WG2 is developing the guidelines. For technical transfer of seismic diagnosis for buildings in Japan, the seminar on the basic concept of Seismic Demand Index Iso was held on June 27th, 2017. There were 25 attendees at this seminar.</li> <li>After establishing draft guideline of seismic diagnosis for infra and lifeline structures, model training seminars to explain the guideline were held on October 26th at NEMA, on October 27th at GASJ, and on November 8th at CDC. There were 42, 17 and 40 attendees, respectively.</li> <li>No activity on the dissemination of techniques of seismic strengthening was held in this period.</li> <li>The WG3 is developing the guidelines and teaching materials for DRR education and raising awareness, and it has not reached the stage of evaluation with quantitative indicators.</li> <li>The WG3 is preparing the improved training program and teaching materials for DRR education and raising awareness for the Training Center, and it has not reached the stage of evaluation with quantitative indicators.</li> </ol>		



Activities	The Mongolian Side	Inputs	The Japanese Side	Important Assumption
< Гамшгийн үеийн тээвэрлэлт, замын хөдөлгөөнийг аюулгүй байдлыг хангах>

Зам, тээврийн хөгжлийн яам болон ОБЕГ хооронд байгуулах санамж бичгийн төслийг боловсруулсан байна.

<Гамшгийн үед түлш, шатахуунаар хангах>

Ашигт малтмал, газрын тосны газар болон ОБЕГ хооронд байгуулах гамшгийн үед түлш, шатахуунаар хангах тухай санамж бичгийн төслийг боловсруулсан. Санамж бичгийг илүү үр дүнтэй болгох үүднээс ОБЕГ-аас гадна бусад холбогдох талуудыг тус санамж бичигт оролцуулахыг яам санал болгосон байна.

<Гамшгийн үед нэн тэргүүнд холбогдох телефон үйлчилгээ>

ОБЕГ болон үүрэн телефоны оператор Юнител компанитай байгуулах гамшгийн үеийн нэн тэргүүнд холбогдох телефон үйлчилгээний талаарх санамж бичгийн төслийг боловсруулсан байна.


<Гамшгийн үеийн цэвэр усны хангамж, бохир усны шугам сүлжээ>

ОБЕГ, УСУГ-ын хооронд байгуулах гамшгийн үеийн цэвэр, бохир усны үйлчилгээний санамж бичгийн төслийг боловсруулсан байна.

**Үйл ажиллагаа 1.2.2 Үйл ажиллагаа 1.2.1-т заасан санамж бичгүүдийг олон нийтэд мэдээлэх болон гамшгаас хамгаалах байгууллагуудын үйл ажиллагааны үялдаа холбоог бэхжүүлэх сургалт зохион байгуулах**

Газар хөдлөлтийн гамшгийн үед авах арга хэмжээн дэх санамж бичгийн эзлэх байр суурь, ач холбогдлын талаар ойлгуулах, эрүүл мэндийн болон бусад салбарт санамж бичиг байгуулах сайн туршлагыг дэмжих зорилгоор 2018 оны 4-р сарын 9-ний өдөр холбогдох сургалтыг УБ хотод зохион байгуулав. Төрөл бүрийн салбарын нийт 38 мэргэжилтэн, албан хаагч энэхүү сургалтанд оролцсон байна.

Япон Улсад хэрэгжүүлж буй санамж бичигтэй холбоотой шилдэг туршлага, Монгол Улсад санамж бичиг байгуулах ажлын үйл явц, ЭМЯ-тай байгуулах санамж бичгийн төсөл зэргийг ОБЕГ болон ЖАЙКА-ын мэргэжилтний багийн (цаашид "ЖМБ" гэх) гишүүд хамтран танилцуулсан байна. Үүний дараа, УБ хотод 8 баллын хүчтэй газар хөдлөлт болох цагийн байдал үүсгэж, санамж бичгийн төслийн дагуу эмнэлгийн байгууллагын ажилтнууд болон эм бэлдмэлийг гамшгийн дараах 6-72 цагийн хугацаанд хэрхэн тараан байршуулах тухай ширээний дадлага сургуулийг 1/50,000 масштабтай газрын зураг ашиглан хийсэн байна.



Илтгэл



Ширээний дасгал

Зураг 1.1 Газар хөдлөлтийн гамшгийн хариуд авах арга хэмжээний санамж бичгийн үр дүнтэй байдлыг шалгах сургалт

**Үйл ажиллагаа 1.3.1 Улс болон орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хяналт, тайлан, үнэлгээ хийх болон нийтлэхтэй холбоотой асуудлыг тодорхойлох**

Энэхүү үйл ажиллагааг гүйцэтгэж дууссан бөгөөд үр дүнг хяналтын хуудсын хураангуйн 3-р хувилбарт тусгасан байна.

**Үйл ажиллагаа 1.3.2 1.3.1-д дурдсан төлөвлөгөөг шинэчлэн сайжруулах гарын авлага боловсруулах**

Улсын болон УБ хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавруудыг ашиглан А/Х 1-ийн гишүүд 2018 оны 10-р сар гэхэд одоогийн Улсын болон УБ хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэх төлөвлөгөөтэй байна. Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зааврыг боловсруулж дууссаны дараа холбогдох яам, байгууллагуудад хянуулахаар/санал авахаар хүргүүлнэ.

Одоогийн байдлаар аймаг, сум, дүүргийн түвшинд газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулагдаагүй байгаа учир тэдгээрийг шинээр гаргасан заавруудын дагуу боловсруулна. 2018 оны 5-р сард А/Х 1-ийн гишүүд Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний заавар болон Аймаг/сумын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зааврыг ашиглан туршилтын аймгууд болох Дархан-Уул, Өмнөговь аймгуудад газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах, эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх туршилтын үйл ажиллагаа, сургалтыг зохион байгуулав. Эдгээр хоёр аймагт зохион байгуулсан 2 өдрийн сургалтад холбогдох байгууллага, албадын мэргэжилтнүүд оролцсон байна. Тус сургалтын үеэр оролцсон мэргэжилтнүүд эрсдэлийн үнэлгээ болон төлөвлөгөө боловсруулах заавруудын агуулгыг судалж, заавар болон тооцооллын програм хангамж ашиглан аймгийн төвийн газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэв. Эдгээр аймгуудын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 2018 оны 10-р сар гэхэд боловсруулж дуусгана.

УБ хотын Чингэлтэй, Баянгол дүүргүүдийн туршилтын үйл ажиллагааг 2018 оны 9-р сард явуулах төлөвлөгөөтэй байна.

**Үйл ажиллагаа 1.3.3 Гамшгаас хамгаалах мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх одоогийн системийг шинэчлэн сайжруулах**

Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын 14 дүгээр зүйл “Гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх”-д ОБЕГ нь гамшгийн мэдээллийн санг

сайжруулах ажлыг хэрэгжүүлнэ гэж заасан. ОБЕГ-ын дээр дурьдсан хуулийн дагуу гүйцэтгэх чиг үүрэг болон "Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ"-ний тэргүүлэх чиглэлүүдийг Монгол улсад хэрэгжүүлэхэд оруулах хувь нэмэр зэрэг үйл ажиллагааны хүрээнд А/Х 1 дээр өнөөгийн тогтолцоог шинэчлэн сайжруулах бодлогын талаар авч үзэж санал солилцсоны үр дүнд одоогийн байдлаар дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:

**1) Гамшгаас хамгаалах орон зайн мэдээллийн сангийн мэдээлэл удирдлагын шинэ тогтолцоог бий болгох**

Гамшгаас хамгаалах мэдээллийн санг сайжруулах ерөнхий үйл ажиллагааны талаар хэлэлцсэний дараа, мэдээллийн санг хариуцсан дэд А/Х нь Японы ГХШУТХ-ийн боловсруулсан вэб-д суурилсан газар зүйн мэдээллийн систем (GIS) болох "И-коми мап"-ыг ОБЕГ, орон нутгийн онцгой байдлын газар болон холбогдох байгууллагуудын гамшгаас хамгаалах мэдээллийн удирдлагын шинэ систем болгож суурилуулахаар шийдсэн байна.

2018 оны 3-р сарын байдлаар системийг суурилуулах ажлын ихэнхийг нь гүйцэтгэсэн бөгөөд Монголын Үндэсний дата төвд сервер суурилуулах ажлыг хийж дуусгав. Одоогоор төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагаас серверт холбогдох байдал болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар гэх мэт холбогдох байгууллагуудын орон зайн мэдээллийн сантай холбогдох байдлыг шалгах зорилгоор системийг туршилтын горимд ажиллуулж байна. Одоогийн серверийн багтаамж нь олон тооны мэдээллийн солилцоог нэгэн зэрэг хийхэд хангалтгүй учир ОБЕГ илүү өндөр үзүүлэлттэй сервер худалдан авах төлөвлөгөөтэй байна.

ОБЕГ-ын Гамшгийн шуурхай удирдлага, Зарлан мэдээллийн төвийн өдөр тутмын гамшгийн мэдээ мэдээллийн системийн цахим бичвэрт суурилсан мэдээллийн сан болон шинээр байгуулагдсан удирдлагын багийн орон зайн мэдээллийн сангийн өгөгдлүүдийг хөрвүүлэх шинэ програм хангамж боловсруулах ажлыг дэд А/Х ЖМБ-ийн техникийн тусламжтайгаар гүйцэтгэж байна.

**2) Гамшгийн орон зайн мэдээллийн санг ашиглах зааврыг боловсруулах**

ОБЕГ гамшгийн орон зайн мэдээллийн санг ашиглахад хамгийн тохиромжтой дүрэм, журмын талаар дэд А/Х-ийн гишүүд заавар боловсруулах ажлын хүрээнд орон нутгийн онцгой байдлын байгууллагын мэргэжилтнүүдийн саналыг авч хэлэлцэв. Дэд А/Х-ийн гишүүд нь 2017 оны 11-р сараас эхлэн зааврын төслийг боловсруулж эхэлсэн бөгөөд Интернетэд суурилсан гамшгийн орон зайн мэдээллийн шинэ

системийг нэвтрүүлсэн Гамшгийн орон зайн мэдээллийн санг удирдаж ажиллуулах шинээр байгуулах удирдлагын багийн ажлын агуулгыг харгалзан боловсруулж буй зааварт тусгаж ирсэн байна. 2018 оны 5-р сарын эцсийн байдлаар ОБЕГ-ын Гамшгийн шуурхай удирдлага, Зарлан мэдээллийн төвд шинэ нэгж хэлтэс байгуулагдаж, 2018 оны 6-р сарын эцэст энэхүү шинэ хэлтсийн нарийвчилсан ажлын агуулга болон чиг үүргийг тодорхойлсны үндсэн дээр зааврын төслийг шинэчилнэ.

### **3) Холбогдох байгууллагуудтай орон зайн мэдээлэл хамтран ашиглах гэрээ байгуулах**

Дэд А/Х-ийн гишүүд Монгол Улсад хэрэгжүүлж байгаа гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хамтран ашиглах орчинг боловсронгуй болгох үүднээс байр зүйн зураг, газар хөдлөлтийн мужлалын бичил зураглал, барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ гэх мэт нарийвчилсан мэдээлэл бүхий байгууллагууд болон ОБЕГ хооронд орон зайн мэдээлэл хамтран ашиглах гэрээ байгуулах үйл ажиллагаанд анхаарал хандуулж ажилласан. Энэхүү үйл ажиллагааны эхний шатанд дэд А/Х-ийн гишүүд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (ГЗБГЗЗГ) болон Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газартай (НХТЕТГ) санал солилцсон байна.

ГЗБГЗЗГ, ОБЕГ-ын хооронд техникийн болон удирдлага, зохион байгуулалтын асуудлуудаар санал солилцож хэлэлцсэний дараа 2018 оны 4-р сарын дундуур орон зайн мэдээлэл хамтран ашиглах гэрээг байгуулсан.

ОБЕГ, НХТЕТГ хоорондын гэрээ одоогоор хэлэлцэх шатанд явж байна. НХТЕТГ нь Улаанбаатар хотын гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд энэхүү мэдээлэл солилцох ажлын ач холбогдол болон үр дүнг ойлгож байгаа бөгөөд хоёр тал энэхүү гэрээг байгуулахад үндсэндээ санал нийлж байна. Энэхүү гэрээг байгуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх үүднээс ОБЕГ-аас НХТЕТГ-т албан бичиг хүргүүлсэн байна.

### **4) ОБЕГ-т гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд орон зайн мэдээллийн санг ашиглах сургалт зохион байгуулах**

Орон зайн мэдээллийн санг удирдаж ажиллуулах шинэ бүтэц зохион байгуулалтыг бий болгох үүднээс ОБЕГ, НОБГ болон 21 аймгийн онцгой байдлын газар, хэлтсийн хүний нөөцийн чадавхыг үнэлэх болон бэхжүүлэх нь чухал арга хэмжээний нэг бөгөөд уг арга хэмжээни хүрээнд эхний ээлжинд, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд орон зайн мэдээллийн санг ашиглах сургалтыг ОБЕГ-т зохион байгуулав.

2018 оны 3-р сарын 12, 13-нд зохион байгуулсан сургалтанд ОБЕГ болон орон нутгийн газар, хэлтсээс 50 мэргэжилтэн оролцсон байна. Энэхүү сургалтын гол зорилго нь гамшгийн орон зайн мэдээллийн системийг ашиглан орон зайн мэдээллийн сангийн талаар анхан шатны ойлголт олгох бөгөөд ОБЕГ-ын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд орон зайн мэдээллийн санг хэрхэн илүү үр дүнтэй ашиглах талаар санал солилцов.

Ихэнх оролцогчид энэхүү сургалтын 2 дахь өдрийн агуулга нь хамгийн их ач холбогдолтой байсан гэж дүгнэжээ. Оролцогчид багаар хамтран ажилласнаар практикт суурилсан мэдлэг авахад илүү дөхөм гэж үзсэн байна. Гэвч, сургалтын хугацаа богино байсан тухай олон санал ирсэн байна. Ихэнх оролцогчид газар зүйн болон орон зайн мэдээллийн системийг ажиллуулах анхан шатны мэдлэгийг төвөггүй эзэмшиж, орон зайн мэдээллийн системийн үйл ажиллагаа, удирдлагын практик дадлага хийхийг сонирхож байв. Түүнчлэн, оролцогчид бусад сэдвүүд дээр дасгал хийх хүсэлтэй гэх зэрэг эерэг саналууд олон гарсан байна.



Зураг 1.2 Орон зайн мэдээллийн сангийн 2 өдрийн сургалтын дасгал ажил

**Үйл ажиллагаа 1.3.4 Үйл ажиллагаа 1.3.1 болон 1.3.2-т заасан улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжүүлэлт, хяналт, үнэлгээ зэрэг үйл ажиллагааны талаар Монгол улсын иргэдэд мэдээлэх зорилго бүхий гамшгаас хамгаалах цагаан номыг боловсруулах**

Цагаан номын Монгол хувилбарыг боловсруулж дууссан бөгөөд одоогоор Цагаан номын хэв загварын талаар санал солилцож байна.

Цагаан номыг англи хэл рүү орчуулах ажил явагдаж байгаа бөгөөд энэхүү ажил нь 2018 оны 6-р сарын эхээр дуусах төлөвтэй байна. Мөн, 2018 оны Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хуралд (цаашид "бага хурал" гэх)



зориулж Цагаан номын англи хувилбарын хураангуй товхимолыг бага хурал эхлэхээс өмнө буюу 7-р сарын 2-ны өдөр гэхэд бэлэн болгох төлөвлөгөөтэй байна.

**Хүснэгт 1.2 Цагаан номын агуулга**

<p>Оршил</p> <p>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ШИНЭЧЛЭЛ</p> <p>1.1. Монгол Улсын гамшгаас хамгаалах тухай хууль, тогтоомж</p> <p>1.2. Гамшгаас хамгаалах бодлогын баримт бичиг</p> <p>1.3. Гамшгаас хамгаалах тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт</p> <p>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</p> <p>2.1. Монгол Улсад 2017 онд тохиолдсон аюулт үзэгдэл, гамшиг осол, хэрэгжүүлсэн арга хэмжээ</p> <p>2.2. Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа</p> <p>2.3. Гамшгийн бэлэн байдлыг хангах арга хэмжээ</p> <p>2.4. Гамшгийн үеийн зарлан мэдээлэл, шуурхай удирдлага, зохицуулалт</p> <p>2.5. Гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээ</p> <p>2.6. Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл</p> <p>2.7. Гамшгаас хамгаалах дадлага сургууль</p> <p>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХ ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА</p> <p>3.1. Гамшгаас хамгаалах олон улсын хамтын ажиллагаа</p> <p>3.2. Гамшгаас хамгаалах албадын харилцан ажиллагаа</p> <p>3.3. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэний нийгэм, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо</p> <p>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ</p> <p>4.1. Галын аюулгүй байдлын талаарх баримт бичиг</p> <p>4.2. Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаа</p>	<p>ТАВДУГААР БҮЛЭГ. УЛСЫН НӨӨЦ, ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ</p> <p>5.1. Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн талаарх баримт бичиг</p> <p>5.2. Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаа</p> <p>ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</p> <p>6.1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл</p> <p>6.2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай баримт бичиг</p> <p>6.3. Монгол Улсын газар хөдлөлтийн нөхцөл байдлын судалгаа</p> <p>6.4. Улаанбаатар хотын ойр орчим дахь хагарлын судалгаа</p> <p>6.5. Улаанбаатар хотын газар хөдлөлтийн шуурхай арга хэмжээний төлөвлөгөө</p> <p>6.6. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай боловсрол, сургалтын үйл ажиллагаа</p> <p>ДОЛООДУГААР БҮЛЭГ. ГАМШИГ СУДЛАЛ, ГАМШГААС ХАМГААЛАХ СУДАЛГААНЫ АЖИЛ</p> <p>7.1. Гамшиг судлалын хүрээлэнгийн судалгаа шинжилгээний ажлууд</p> <p>7.2. Гамшгийн мэдээллийн сан</p> <p>НАЙМДУГААР БҮЛЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</p> <p>8.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт</p> <p>8.2. Гадаадын хөрөнгө оруулалт</p> <p>8.3. Онцгой байдлын ерөнхий газарт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр</p> <p>8.4. Гамшигт нэрвэгдэгсдэд олгох нөхөн олговор</p> <p>8.5. Гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээ</p> <p>2017 ОНЫ ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН</p>
--	--

**Үйл ажиллагаа 1.3.5 Барилга, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн мэдээллийн сангийн системийг сайжруулах**

Үйл ажиллагаа 1.3.3-т тайлбарласны дагуу, гамшгаас хамгаалах мэдээллийн санг хариуцсан дэд А/Х нь гамшгаас хамгаалах орон зайн мэдээллийн санг боловсруулж

байгаа. Орон зайн мэдээллийн сан нь холбогдох байгууллагуудын гүйцэтгэх барилга, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний үр дүнг хуримтлуулж, удирдах боломжтой байхаар зохион байгуулж байна. Мөн түүнчлэн, дэд А/Х-ийн гишүүд НХТЕТГ-тай мэдээлэл солилцох гэрээ байгуулах ажлыг гүйцэтгэж байна. НХТЕТГ нь өөрийн боловсруулсан аргачлалаар барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээг хийж байгаа бөгөөд үнэлгээний үр дүнг барилга тус бүрийн "паспорт"-д тусгадаг байна. Энэхүү гэрээ байгуулагдах тохиолдолд, ОБЕГ, НХТЕТГ хоорондоо барилгаас гадна дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үр дүнгийн талаар мэдээлэл солилцож, түүнийг гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах боломжтой болох юм.

**(3) Үр дүн 2**

**Үйл ажиллагаа 2.1.1 Гамшгаас хамгаалах тухай хуулийн хүрээнд, Барилга, Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнд газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ хийх журам, зааварт дүн шинжилгээ хийж шинэчилсэн заавар боловсруулах**

Өмнөх хяналтын хуудсанд тусгасны дагуу, А/Х 2-ын гишүүд барилга, байгууламжийн газар хөдлөлт тэсвэрлэлттэй холбоотой үнэлгээний одоогийн норм, нормативын бичиг баримтуудыг холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүдтэй хамт судлан үзэж, тулгарч буй асуудлуудыг төслийн хүрээнд боловсруулах заавруудад тусгахаар шийдсэн.

**Үйл ажиллагаа 2.1.2 Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлал, Үнэлгээнд хэрэглэгдэх хэмжилтийн багаж төхөөрөмжийг ашиглах заавар боловсруулах**

А/Х 2 нь Бүдүүвч 2.1-т заасан байдлаар норм, норматив батлах Монгол дүрмийг мөрдөхөөр шийдсэн байна. Энэхүү бүдүүвчинд мөн үйл ажиллагааны явцыг урьдчилсан байдлаар дүрсэлжээ.



БХТ: Барилга хөгжлийн төв, ЗҮБ: Зөвлөх үйлчилгээний баг, БД: Барилгын дүрэм

**Бүдүүвч 2.1 Барилгын дүрэм боловсруулах ажлын дараалал**

### **1) Барилга, байгууламжийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлал боловсруулах**


А/Х 2 нь цутгамал төмөр бетон, угсармал том хавтгаалжин болон тоосгон өрөгт бүтээцтэй барилга тус бүрийн дүрмийн агуулгыг тодорхойлж, дүрмийн төслийг боловсруулсан. Барилгын дүрмийн төслийг боловсруулахад тулгарсан зарим асуудлын талаар Зөвлөх үйлчилгээний багтай (цаашид "ЗҮБ" гэх) хамтран ажиллаж, ЗҮБ-аар дамжуулан барилгын дүрмийн төслийг Барилгын Хөгжлийн Төвд (цаашид "БХТ" гэх) хүргүүлсэн байна.

БХТ нь ЗҮБ-ийн хүргүүлсэн дүрмийн төслийг шалгаж, ЗҮБ-аар оруулах зарим өөрчлөлтүүдийг тодорхойлсон байна. Үүнд:

- Судалгааны үр дүнг газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний жишээнд оруулах
- Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний тайлбар зургийг нэмж оруулах
- Дүрэм бүрд заасан загвар барилгуудын Is үнэлгээний тооцооны жишээ болон тус үнэлгээний аргачлал нь тохиромжтой эсэхийг шалгасан

Дээр дурдсан асуудлуудын талаар А/Х 2-той хэлэлцэж, шийдвэрлэсний дараа ЗҮБ эдгээр шинэчилсэн дүрмүүдийг БХТ-д дахин хүргүүлж, Мэргэжлийн зөвлөлөөр батлуулсан байна. Гэвч, БХТ эдгээр дүрмүүдийг сайтар ойлгохын тулд ЗҮБ-ээр барилгад биет судалгаа явуулахыг хүссэн. А/Х 2 нь ЗҮБ-тэй зөвлөлдөж судалгааны ажилд өмнө нь хамрагдаагүй цутгамал төмөр бетон барилгад дахин нэмж биет судалгаа хийхээр шийдсэн. Угсармал том хавтгаалжин болон тоосгон өрөгт бүтээцтэй барилгуудын хувьд өмнө нь хийсэн биет судалгааны үр дүнг ашиглана.

А/Х 2 нь 5-р сарын 4, 5-ны өдрүүдэд барилгын дүрмийн төслүүдийн талаар хоёр өдрийн сургалт зохион байгуулж, А/Х 2-ын гишүүд ирээдүйд Монгол Улсад шинэ технологи нэвтрүүлэхийн тулд эдгээр дүрмүүдийн талаар хүрэлцэхүйц мэдлэгтэй болохыг анхаарсан байна. Энэхүү сургалтын үеэр авсан зургийг Зураг 2.1-т үзүүлэв.



**Зураг 2.1 А/Х 2-ын зохион байгуулсан барилгын дүрмийн төслийн тухай сургалт**

## **2) Инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлал боловсруулах**

Инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлал нь БХБЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцэгдэж дэмжигдсэн бөгөөд одоогоор Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар батлагдахаар хүлээгдэж байна. Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр дэмжигдсэнээс хойш 6 сар өнгөрсөн учир ЖМБ БХБЯ-ны хэлтсийн дарга болох А/Х 2-ын ахлагчаас тус аргачлалыг батлуулах ажлыг хурдасгахыг хүснэ.

**Үйл ажиллагаа 2.1.3: Барилга, байгууламж болон шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээг хийх мэргэжилтнүүдийн мэдлэг, үр чадварыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах**

А/Х 2 нь барилга, байгууламж болон инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлийн үнэлгээний тухай 4-н өдрийн сургалтын агуулга болон төлөвлөгөөг хэлэлцсэн бөгөөд Бүдүүвч 2.2-т заасан байдлаар тус сургалтыг зохион байгуулахаар шийдсэн байна.


	1-р өдөр	2-р өдөр	3-р өдөр	4-р өдөр
Өглөө1	Нээлтийн ёслол • Нээлтийн үг хэлэх • Танилцуулга • Дүрмийн тухай • Дурсгалын зураг	Төмөр бетон (1) • Дүрмийн тайлбар	Өрөгт бүтээц • Дүрмийн тайлбар • Тэсвэрлэлтийн үнэлгээний дасгал ажил	ДБИШС (1) • Японд учирсан хохирол • Төслийн 1-р үе шатны тайлбар
Өглөө2	Ерөнхий (1) • Монгол дах одоо мөрдөгдөж буй барилгын дүрэм • УБ хотын ГХ	Төмөр бетон (2) • Тэсвэрлэлтийн үнэлгээний дасгал ажил	Ерөнхий (4) • Японы тэсвэрлэлтийн үнэлгээний тогтолцоо	ДБИШС (2) • Монголын ИШС-ний өнөөгийн нөхцөл байдал • Дүрмийн тухай
Өдөр1	Ерөнхий (2) • Японд болсон гамшиг, авсан арга хэмжээ • Хүчитгэлийн жишээ	Угсармал (1) • Дүрмийн тайлбар	Тоног төхөөрөмж • Биет судалгаанд ашиглагдах багаж • Товч тайлбар	ДБИШС (3) • Тэсвэрлэлтийн үнэлгээний дасгал • Ирээдүйн Ү/А-ны талаар ярилцах
Өдөр2	Ерөнхий (3) • Тэсвэрлэлтийн үнэлгээний заавар • Японы аргачлалыг Монголд нэвтрүүлэх	Угсармал (2) • Тэсвэрлэлтийн үнэлгээний дасгал ажил	Хаалтын ёслол • Сертификат гардуулах • Хаалтын үг хэлэх	Хаалтын ёслол • Сертификат гардуулах • Хаалтын үг хэлэх

**Бүдүүвч 2.2 Газар хөдлөлт тэсвэрлэлийн үнэлгээний тухай сургалтын төлөвлөгөө**

А/Х 2 дараах зүйлсийг хэлэлцэж, шийдвэрлэсэн байна;

- Сургалтыг 6-р сарын 4-ний өдрөөс 6-ны өдөр хүртэл явуулах,
- Сургалтыг БХТ-ны хурлын зааланд зохион байгуулах, ба
- Холбогдох байгууллагуудаас 90 оролцогчдыг тус сургалтад оролцуулах.

Сургалт эхлэхээс өмнө 5-р сарын 10, 11-ний өдрүүдэд Монголын Барилгын Инженерүүдийн Холбооны байранд 20 оролцогчдод 2 өдрийн туршилтын сургалтыг Бүдүүвч 2.2-т заасан "Ерөнхий (2) & (3)", "Цутгамал төмөр бетон барилга (1) & (2)", "Угсармал том хавтгаалжин барилга (1) & (2)" болон "Тоосгон өрөгт бүтээцтэй барилга (1) & (2)" гэсэн сэдвүүдээр явуулсан байна. Оролцогчдын дунд явуулсан санал асуулгын үр дүнг Бүдүүвч 2.3-т харуулав. Энэхүү туршилтын сургалт нь лекц болон дасгалуудаас бүрдсэн бөгөөд Зураг 2.2-т харуулсан байдлаар зохион байгуулагдсан байна.



**Бүдүүвч 2.3 Оролцогчдын дунд явуулсан санал асуулгын үр дүн**

1. Энэхүү сургалт таны ажилд ач холбогдолтой эсэх:

Тийм - 18; Үгүй - 0; Аль нь ч биш - 0.

2. Сургалтын агуулга: Маш сэтгэл хангалуун - 12; Сэтгэл хангалуун - 6; Аль нь ч биш: - 0; Сэтгэл ханамжгүй - 0; Маш сэтгэл ханамжгүй - 0.


3. Багш нарын лекц: Сайн - 12; Аль нь ч биш - 0; Муу: 6.

4. Оролцогчдын тоо: Хэт их - 15; Их - 2; Тохирсон - 1; Бага - 0; Хэт бага - 0.

5. Лекц болон сургалтын материал хоорондын уялдаа холбоо:

Уялдаа холбоотой: 12; Аль нь ч биш - 0; Уялдаа холбоогүй: 6.

6. Сургалтын хугацаа: Хэт урт - 0; Урт - 0; Тохирсон - 18; Богино - 0; Хэт богино - 0.



Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний тухай лекц

Excel дээр суурилсан дасгал ажил

## **Зураг 2.2 Монголын Барилгын Инженерүүдийн Холбооны байранд зохион байгуулсан туршилтын сургалт**

### **Үйл ажиллагаа 2.2.1 Барилга байгууламжийг хүчитгэх, шинэчлэн барих тухай заавар аргачлал боловсруулах**

А/Х 2 газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ, барилга, байгууламжийн хүчитгэл зэргийг нэгтгэж, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнээс гадна барилгын төрөл бүрд нэг заавар боловсруулахаар шийдсэн. Учир нь газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ нь барилгын хүчитгэлтэй шууд холбоотой.

Өмнө дурдсаны дагуу, БХТ хүргүүлсэн дүрмийн төслүүдийг шалгаж, ЗҮБ-ээр дараах өөрчлөлтийг оруулахыг шаардсан байна. Үүнд;

- Хүчитгэлийн загвар зураг төслийг нэмж оруулах

Дээр дурдсан асуудлуудын талаар А/Х 2-той хэлэлцэж, шийдвэрлэсний дараа ЗҮБ эдгээр шинэчилсэн дүрмүүдийг БХТ-д дахин хүргүүлж, Мэргэжлийн зөвлөлөөр батлуулсан байна.

### **Үйл ажиллагаа 2.2.2: Орон сууц, цэцэрлэг, сургууль, эмнэлэг, төрийн захиргааны барилга, байгууламж зэргийг хүчитгэх, загвар зураг төсөл боловсруулах**

А/Х 2-ын ахлагчаар БХБЯ-ны хэлтсийн дарга томилогдсоны дараа хүчитгэлийн зураг төсөл боловсруулах барилгууд эцсийн байдлаар сонгогдсон байна. Сонгогдсон



барилгуудыг Хүснэгт 2.1-т тусгав.

Зураг төсөл, тооцооллын хүснэгт, газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний тайлан гэх мэт барилгын хүчитгэлд шаардлагатай мэдээллийг А/Х 2 цуглуулсан байна.

**Хүснэгт 2.1 Хүчитгэлийн зураг төсөл боловсруулахаар сонгогдсон барилга**

Бүтээц	Зориулалт	Нэр	Байршил	Тайлбар
Тоосгон өрөгт бүтээц	Цэцэрлэг	105-р цэцэрлэг	Сонгино хайрхан дүүрэг	Нэг маягийн зургаар Улаанбаатар хотод хамгийн олон баригдсан цэцэрлэгийн барилга
	Сургууль	23-р сургууль	Чингэлтэй дүүрэг	Нэг маягийн зургаар баригдсан тоосгон бүтээцтэй том хэмжээний сургуулийн барилга
	Төрийн байгууллага	ОБЕГ-ын төв байр	Сүхбаатар дүүрэг	Гамшгийн үед шуурхай арга хэмжээ авах үүрэг бүхий төрийн байгууллагын барилга
Цутгамал төмөр бетон бүтээц	Эмнэлэг	1-р төрөх эмнэлгийн өргөтгөл	Сүхбаатар дүүрэг	Цутгамал төмөр бетон бүтээцтэй барилга бүхий цөөн тооны Улсын эмнэлгийн нэг
Угсармал хавтгаалжин бүтээц	Орон сууц	9 давхар барилга	Баянгол дүүрэг	Нэг маягийн зургаар Улаанбаатар хотод хамгийн олон баригдсан угсармал хавтгаалжин орон сууцны барилга

#### (4) Үр дүн 3

##### Үйл ажиллагаа 3.1.1 Гамшгаас хамгаалах тухай хуультай уялдсан цэцэрлэг, сургуулийн гамшгаас хамгаалах боловсролын агуулга, арга зүй, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон удирдамж боловсруулах

Япон дахь сургалтаар олж авсан мэдлэг болон 2018 оны 1, 2 сард хийгдсэн Ажлын хэсэг 3-1-ийн воркшоп зэргийн үр дүнд “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн төслийг эцэслэн сайжруулах ажил хийгдсэн.

Хөтөлбөрийн төслийг 2018 оны 3 сард Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам (цаашид БСШУСЯ гэх)-нд хүлээлгэн өгсөн ба үүний дараа БСШУСЯ-ны хөтөлбөр батлуулах журмын дагуу мэргэжлийн экспертээр уншуулж, түүнээс гарсан саналын дагуу дахин сайжруулах ажил хийгдсэн.

“Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөр нь 2018 оны 4 сарын 6-ны өдрийн БСШУС-ын сайдын тушаалаар батлагдсан.

Хөтөлбөр нь 1)Үндэслэл, 2)Зорилго, 3)Агуулга, 4)Арга зүй, 5) Үнэлгээ гэсэн 5 үндсэн хэсэг ба “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн агуулга, хичээл, сургалтын үйл ажиллагааны уялдааг харуулсан матриксаас бүрдэнэ.

##### Үйл ажиллагаа 3.1.2: Цэцэрлэг, сургуулийн гамшгийн эрсдэлийг бууруулах сургалтад ашиглах сурах бичгийн нэмэлт материал, сургалтын материал зэргийг боловсруулах

“Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн дагалдах баримт бичиг болох багш нарт зориулсан суралцахуйн удирдамжийг бичих, сайжруулах ажил 2018 оны 2 болон 4 сард болсон Ажлын хэсгийн воркшоп дээр хийгдэж, ажлын хэсгийн гишүүд тус тусын хариуцсан бүлгүүд дээр ажиллав.

Суралцахуйн удирдамжийн төслийн агуулга дараах байдалтай байна.

###### **Нэг. “Аюулгүй амьдрах ухаан”-ы тухай ойлголт**

1.1. Үндэслэл, хэрэгцээ

1.2. “Аюулгүй амьдрах ухаан” гэж юу вэ?

###### **Хоёр. “Аюулгүй амьдрах ухаан”-ы сургалтын хөтөлбөр ба бусад судлагдахуун, үйл ажиллагааны уялдаа**

2.1. ААУ-ны сургалтын хөтөлбөрийн товч танилцуулга

<p>2.2. Хичээл /судлагдахуун/-ийг “Аюулгүй амьдрах ухаан”-ы сургалтын хөтөлбөртэй уялдуулах боломж</p> <p><b>3-р бүлэг: “Аюулгүй амьдрах ухаан”-ы сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн санаа</b></p> <p>3.1. Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх цэцэрлэг, сургуулийн сургалт, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах санаа</p> <p>3.2. “Аюулгүй амьдрах ухаан”-ы сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломж, загвар, жишээ (СӨБ, Бага боловсрол, Суурь боловсрол, Бүрэн дунд боловсрол тус бүрээр)</p> <p>Хавсралт 1.Багшид зориулсан унших материал</p> <p>Хавсралт 2. Холбогдох зарим нэр томъёоны тайлбар</p> <p>Хавсралт 3. Сургалтад хэрэглэж болох эх сурвалжийн жагсаалт</p>
---

Түүнээс гадна, 2018 оны 5-р сарын 1-2-ний өдрүүдэд, Японы зөвлөх мэргэжилтэн Ерөнхий боловсролын сургуулийн 5, 8-р ангийн сурагчдад зориулан гамшгаас хамгаалах туршилтын хичээлийг явуулсан бөгөөд үүнд сургалт хийгдсэн сургуулиудын багш нар болон төслийн хамтран ажиллагч талын мэргэжилтнүүд, ажлын хэсгийн гишүүд оролцсон.

Суралцахуйн удирдамжийн эхний төслийг 2018 оны 7 сард гаргахаар ажлын хэсгийн гишүүд тус тусын хариуцсан хэсгүүд дээр ажиллаж байна.

**Үйл ажиллагаа 3.1.3: БМДИ-ийн арга зүйчид, аймаг нийслэлийн боловсролын газрын мэргэжилтнүүдэд 3.1.1, 3.1.2-д боловсруулсан хөтөлбөр, сургалтын материалыг ашиглан сургалт явуулах.**

Ажлын хэсгийн үйл ажиллагаагаар дамжуулан, сургалтын төлөвлөгөө болон сургалт явуулах газрын талаар хамтран ажиллагч талтай ярилцаж хэлэлцсэн. Багш болон сургагч багш нарын жилийн сургалтын төлөвлөгөөг харгалзан, доорх хүснэгтэд үзүүлсэн байдлаар боловсролын гурван түвшингийн арга зүйч нарын оролцоог хангасан сургалтыг хийхээр төлөвлөж байна.

Сургалт болох газар	Ховд	УБ хот (1 дэх сургалт)	УБ хот (2 дахь сургалт)
Хугацаа (3 өдөр)	2018.9.11~13	2018.9.18~20	2018.10.8~10
Хамрагдах бүс нутаг	Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай (5 аймаг)	Архангай, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Баянхонгор, Дорноговь, Булган, Хөвсгөл, Орхон,	УБ хотын 9 дүүрэг, Дархан-Уул, Говьсүмбэр, Төв(9 дүүрэг, 3 аймаг)

		Хэнтий, Дорнод, Сүхбаатар (13 аймаг)	
Оролцогчийн тоо	Аймаг, дүүрэг тус бүрээс 3 хүн (Нийт 90 хүн)		

Сургалтын агуулгын тухай 2018 оны 5-р сарын 7-ны өдөр болсон Ажлын хэсэг 3-1-ийн уулзалт дээр хэлэлцэж ярилцсан. 2018 оны 8-р сарын дундуур дэлгэрэнгүй агуулга, ложистикийн асуудлуудыг хэлэлцэх бөгөөд 2018 оны 9-р сарын эхээр эцэслэн боловсруулна.

**Үйл ажиллагаа 3.2.1 Төв, орон нутгийн гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны нэгдсэн график төлөвлөгөө боловсруулах**

<"Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны баг"-ийн ээлжит уулзалт>

Гамшгийн эрсдэлийг бууруулах сургалт сурталчилгааны багийн ээлжит хурлыг 2017 оны 12 сарын 21, 2018 оны 3 сарын 16-ны өдрүүдэд зохион байгуулж, тус тусын байгууллагын үйл ажиллагааны тайлан болон хойшид хийх ажил, хамтын ажиллагааны талаар ярилцсан.

<Сургалтын төлөвлөгөөний мэдээлэл нийтлэх веб хуудас>

2017 оны 12-р сарын байдлаар ОБЕГ-ын сургалтын төлөвлөгөөг түгээх, зохицуулалт хийх веб хуудасны серверийн зай хангалтгүй байсан тул Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны баг нь Google Drive дахь эксел файл ашиглан цаашид веб хуудсаар мэдээлэх агуулгын талаар туршихаар шийдсэн ба одоогоор багийн гишүүд туршилтаар мэдээлэл оруулах, уг агуулгыг өөрчлөх шаардлагатай эсэхийг хянаж үзэж байна.

2018 оны 4-р сард ОБЕГ-ын сургалтын веб хуудас (<http://ontsgoisur.gov.mn/>)-нд сургалтын мэдээлэлд зориулж тодорхой хэмжээний зай гаргасан. Нэгдсэн график төлөвлөгөөний форматыг хянаж, эцэслэсний дараа уг форматын дагуу системийг веб хуудсанд байрлуулна.

<Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны багийн мэйл групп>


Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны багийн мэйл групп (mdptteam@googlegroups.com) сургалтын мэдээлэл түгээх, зохицуулалт хийх зэрэг зорилгоор үр дүн ашиглагдаж байна.

**Үйл ажиллагаа 3.2.2 Гамшгаас хамгаалах боловсрол олгох сургалт,**

**сурталчилгааны материал боловсруулж, зорилтот бүлгийн сургалтыг сонгогдсон бүс нутагт зохион байгуулах**

**1) Орон нутгийн гамшгаас хамгаалах сургалтын материал боловсруулах**

Үр дүн 3-2-ын үйл ажиллагааны хүрээнд Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын “Гамшигт тэсвэртэй Улаанбаатар” төсөлтэй (“Бэлэн бай!” сургалтын багц) хамтран ажилласан ба 2018 оны 2-р сард зохион явуулсан 2 өдрийн воркшоп сургалт, 2018 оны 2 ба 3-р сард явуулсан уулзалтууд, бусад үйл ажиллагааны үр дүнд төслийн гамшгаас хамгаалах сургалтын хэрэглэгдэхүүн материалыг 2018 оны 3-р сард боловсруулсан.



Зураг. 3-2-1 Сургалтын багцын агуулга

Сургалт нь “Хэн ч, хэзээ ч, хаана ч бэлэн. Гамшгаас хамгаалах буухиа тэмцээн” нэртэй.

**2) Орон нутгийн гамшгаас хамгаалах сургалт явуулах туршилтын нутаг дэвсгэрийн сонголт**

Туршилтын нутаг дэвсгэр Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх дүүрэг, Завхан аймгийг сонгох талаар 2018 оны 3-р сард болсон төслийн Удирдах хорооны хурал болон 2018 оны 4-р сард болсон ХЗХ-ны хурлаар баталгаажуулсан.

**3) Сургагч багшийн сургалт хэрэгжүүлэх**

Сургагч багшийн сургалтыг 2018 оны 3-р сарын 21-нд Улаанбаатар хотод, 2018 оны 3-р сарын 26-нд Завхан аймагт Дэлхийн Зөн Монгол ОУБ болон МУЗН-аас зохион байгуулсан “Бэлэн бай” сургалттай хамтарсан байдлаар хэрэгжүүлсэн. Сургалтуудад аймаг, дүүргийн гамшгаас хамгаалах сайн дурын гишүүд, хороо, сумын засаг даргын тамгын газрын ажилтнууд, орон нутгийн насан туршийн боловсролын төвийн мэргэжилтэн зэрэг тус бүр 50 оролцогч оролцсон.

Сургагч багшийн сургалтын дараа “Гамшгаас хамгаалах буухиа тэмцээн”-ий сургалтын хэрэглэгдэхүүнийг хэрхэн хийх, сургалтыг хэрхэн явуулах агуулгыг багтаасан буухиа тэмцээний гарын авлагын төслийг боловсруулсан.

**1) Орон нутгийн гамшгаас хамгаалах сургалт хэрэгжүүлэх**

Завхан аймгийн гамшгаас хамгаалах сургалтыг 2018 оны 5-р сарын 12-нд Отгон сум,

2018 оны 5-р сарын 14-нд Улиастай суманд тус тус амжилттай хэрэгжүүлсэн. Мөн Улаанбаатар хотын туршилтын нутаг дэвсгэр болох Баянгол дүүргийн сургалтыг 2018 оны 5-р сарын 17-нд, Баянзүрх дүүргийн сургалтыг 2018 оны 5-р сарын 20-нд амжилттай хэрэгжүүлсэн. Сургалтуудыг 2018 оны 3-р сарын сургагч багшийн сургалтанд хамрагдсан сургагч багш нар голчлон зохион байгуулсан ба буухиа тэмцээний гарын авлагын төслийн дагуу явуулсан.

Түүнчлэн ОБЕГ-ын хүсэлтээр сургагч багшийн сургалтын явуулахын өмнө буюу 2018 оны 3-р сарын 20-нд Монгол улсын Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийн хүрээнд Баянзүрх дүүргийн 87-р сургуульд Гамшгаас хамгаалах буухиа тэмцээн явуулахад сургалтын хэрэглэгдэхүүн материалыг бэлдэн дэмжлэг үзүүлж оролцсон.

Сургагч багшийн сургалт, орон нутгийн иргэдийн гамшгаас хамгаалах сургалт болон сургуульд зохион явуулсан буухиа тэмцээн өдөрлөгийн үйл ажиллагаанд тулгуурлан АХЗ-2-ын гишүүд цаашид уг үйл ажиллагааг Монгол улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлэхэд зориулж гамшгаас хамгаалах буухиа тэмцээний гарын авлагын төслийг сайжруулан эцэслэх ажлыг гүйцэтгэнэ.

### Үйл ажиллагаа 3.2.3 Сургалтын төвд гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн нөхцөл байдлыг биеэр мэдрүүлэх сургалт, сурталчилгааны хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах

2017 онд Япон улсад явуулсан сургалтын дараа АХЗ-2-ын гишүүд Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн үзүүлэн материалыг Японд сурч мэдсэн мэдлэгтээ тулгуурлан сайжруулах талаар хэд хэдэн уулзалт болон 2018 оны 2-р сарын 2 өдрийн воркшопын үеэр ярилцсан. Мөн АХ-ын гишүүд Сургалтын төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллах хүсэлтэй Дэлхийн Зөн Монгол ОУБ-тай үйл ажиллагааны давхардлаас сэргийлэх үүднээс хамтарсан уулзалт хийж, зохицуулалт хийж ажилласан. Үүний үр дүнд ЖАЙКА-гийн төслийн зүгээс Сургалтын төвийн үзүүлэн материалын агуулгыг сайжруулахтай холбоотой дараах ажлуудыг хийхээр шийдсэн.

- Газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхимын үзүүлэн материал
- Газар хөдлөлтийн тэсвэржилт, хүчитгэлийн талаар суралцах барилгын макет
- Сургалтын материал: Хүүхдийн өрөөний гамшгаас хамгаалах сургалтын асуулт хариулт

2018 оны 5-р сарын 3-ны өдөр барилгын макетыг хэрхэн хийх талаар хялбаршуулсан воркшопыг явуулсан. Мөн 2018 оны 5-р сарын 24-ны уулзалтаар 2018 оны 11-р сард газар хөдлөлтийг биеэр мэдрэх тавцанг суурилуулсны дараах

газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхимын хөтөлбөрийг боловсронгуй болгох асуудлаар ярилцсан.

## 1-3 Хүрсэн үр дүн

### (1) Үр дүн 1

Төслийн төлөвлөлтийн матрицын (PDM) дагуу Үр дүн 1-ийн гүйцэтгэлийг дараах гурван шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

#### 1.1 Боловсруулсан заавар, дүрмийн тоо.

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

А/Х 1-ийн гишүүд Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний зааврыг боловсруулсан бөгөөд Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний зааврын бүтцийг гаргасан. Газар хөдлөлтийн эрсдэлийн хялбарчилсан үнэлгээний програм хангамжийг боловсруулсан бөгөөд Монгол Улсын нөхцөл байдалд тохирсон аргачлалыг ашигласнаар газар хөдлөлтийн эрсдэлийн талаар мэргэжлийн мэдлэг, туршлагагүй төрийн албан хаагчид ч үнэлгээ хийх боломжтой юм.

А/Х 1-ийн гишүүд Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, Аймаг/сумын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар болон УБ хот/дүүргийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, зэргийг боловсруулав. Одоогоор газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах улсын албадын төлөвлөгөө боловсруулах зааврыг боловсруулж байна.

А/Х 1-ийн гишүүд Гамшгийн орон зайн мэдээллийн санг ашиглах зааврын төслийг Интернетэд суурилсан гамшгийн орон зайн мэдээллийн системийг удирдаж ажиллуулах хүний нөөцөөр хангах зорилгоор шинээр байгуулагдаж буй удирдлагын багийн гишүүдийн ажлын агуулгыг тусган боловсруулж эхэлсэн байна. 2018 оны 5-р сарын эцсийн байдлаар шинэ хэлтэс байгуулагдсан бөгөөд энэхүү шинэ хэлтсийн нарийвчилсан ажлын агуулга болон чиг үүрэг, хариуцлагыг тодорхойлсны үндсэн дээр зааврын төслийг шинэчилнэ.

#### 1.2 Боловсруулсан санамж бичгийн төслийн тоо болон санамж бичгийн талаар санал солилцсон, холбогдох сургалтанд оролцсон байгууллагууд

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

Одоогийн байдлаар доор дурдсан салбаруудын санамж бичгийн төсийг хэлэлцэж байна.



<Гамшгийн үед эм, эмийн хэрэгсэл болон эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх>  
Эрүүл мэндийн яам (цаашид "ЭМЯ" гэх), Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын нэгдсэн холбоо болон ЭМЯ, Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн "Эм" холбооны хооронд байгуулах хоёр санамж бичгийн төслийг тус тус боловсруулаад байна.

<Түр хорогдох байр, түр сууцанд шилжин ирсэн гамшигт нэрвэгдэгсдэд шаардагдах ундны цэвэр ус, хоол, хүнсээр хангах>  
ОБЕГ болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хооронд байгуулах санамж бичгийн төслийг боловсруулсан байна.

<Барилгын материалын хангамжийн тогтвортой байдлыг хангах>  
Барилга, хот байгуулалтын яам (цаашид "БХБЯ" гэх), Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо болон БХБЯ, Барилгачдын нэгдсэн холбоо хооронд байгуулах хоёр санамж бичгийн төслийг тус тус боловсруулсан байна.

< Гамшгийн үеийн тээвэрлэлт, замын хөдөлгөөнийг аюулгүй байдлыг хангах>  
Зам, тээврийн хөгжлийн яам болон ОБЕГ хооронд байгуулах санамж бичгийн төслийг боловсруулсан байна.

<Гамшгийн үед нэн тэргүүнд холбогдох телефон үйлчилгээ>  
ОБЕГ болон үүрэн телефоны оператор Юнител компанитай байгуулах санамж бичгийн төслийг боловсруулсан байна.

<Гамшгийн үеийн цэвэр усны хангамж, бохир усны шугам сүлжээ>  
ОБЕГ, УСУГ-ын хооронд байгуулах санамж бичгийн төслийг боловсруулсан байна.

### 1.3 Гамшгаас хамгаалах Цагаан ном

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

Цагаан номын Монгол хувилбарыг боловсруулж дууссан бөгөөд одоогоор Цагаан номын хэв загварын талаар ярилцаж, санал солилцож байна.

Цагаан номыг англи хэл рүү орчуулах ажил явагдаж байгаа бөгөөд энэхүү ажил нь 2018 оны 6-р сарын эхээр дуусах төлөвтэй байна. Мөн түүнчлэн, 2018 оны Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хуралд зориулж Цагаан номын англи хувилбарын хураангуй товхимолыг бэлтгэх төлөвлөгөөтэй байна.

#### **(2) Үр дүн 2**

Төслийн төлөвлөлтийн матрицын (PDM) дагуу Үр дүн 2-ын гүйцэтгэлийг дараах хоёр

шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

### 2.1 Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний заавар: газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний сургалтанд оролцсон хүний тоо

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

А/Х 2 заавруудыг боловсруулж дууссан бөгөөд одоогоор БХБЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцэгдэж, сайдын тушаалаар батлагдахыг хүлээж байна.

3-р сарын 29-ний өдөр А/Х 2-ын гишүүд цутгамал төмөр бетон барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний сургалтыг Монголын Барилгын Инженерүүдийн Холбоо (цаашид "МБИХ" гэх)-ны байранд Монголын залуу инженерүүдэд зориулан зохион байгуулсан бөгөөд, тус сургалтанд 25 инженер оролцсон байна.

Цутгамал төмөр бетон, угсармал том хавтгаалжин болон тоосгон өрөгт бүтээцтэй барилга тус бүрийн зааврын төслийг боловсруулсны дараа эдгээр заавруудыг танилцуулах туршилт сургалтыг 5-р сарын 10, 11-ний өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд энэхүү сургалтанд МБИХ болон Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбооноос нийт 18 оролцогчид оролцсон байна. Энэхүү туршилт сургалт нь МБИХ-ны албан ёсны сургалт гэж зохион байгуулагдсан бөгөөд энэхүү сургалт оролцогч бүрт лиценз авахад нь тус болсон байна.

### 2.2 Барилгын хүчитгэлийн аргачлал: Зохион байгуулсан сургалтын тоо

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

Энэ хугацаанд хүчитгэлийн аргачлалын нийтлэх аливаа үйл ажиллагаа явуулаагүй байна.

### **(3) Үр дүн 3**

Төсөл төлөвлөлтийн матрицын дагуу Үр дүн 3-ын үйл ажиллагааг дараах 2 шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

#### 3.1 Төслийн хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр зохион байгуулагдсан сургалтын тоо

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

Ажлын хэсэг 3-1 нь 2018 оны 4 сард сургалтын хөтөлбөрөө батлуулж, суралцахуйн удирдамж бэлтгэх, мэдлэг дээшлүүлэх сургалтын агуулгыг боловсруулах ажлыг хийж байгаа бөгөөд одоогийн байдлаар тоон үзүүлэлтээр үнэлэх шатанд хүрч

чадаагүй байна.

### 3.2 Сургалтын төвөөр үйлчлүүлэгчдийн тоо

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

Ажлын хэсэг 3 нь Нийслэлийн Иргэдийн Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвийн боловсролын сургалтын хөтөлбөр болон сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсронгуй болгох, сургалтын төвийн чадавхыг дээшлүүлэх зэрэг ажлыг хийж байгаа бөгөөд, одоогийн байдлаар тоон үзүүлэлтээр үнэлэх шатанд хүрч чадаагүй байна.

### 1-4 Төслийн зорилтын хүрээнд хүрсэн үр дүн

Төслийн төлөвлөлтийн матрицын (PDM) дагуу Төслийн зорилтын гүйцэтгэлийг дараах хоёр шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

#### 1. Батлагдсан заавар, санамж бичгийн тоо

#### 2. Шинээр боловсруулсан болон шинэчлэн сайжруулсан гамшгийн эрсдэлийг бууруулах мэдээллийн тоо

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

А/Х тус бүр заавар, санамж бичиг, газар хөдлөлт тэсвэрлэлт ба хүчитгэлийн норм, дүрэм болон сургалтын материал боловсруулах ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэсэн байна. Төсөл дууссаны дараах тогтвортой залгамж байдлыг хангахын тулд Төслийн хүрээнд боловсруулсан заавар болон бусад үр дүнг ОБЕГ, БХБЯ болон БСШУСЯ-аар батлуулах зорилготойгоор Төслийн үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж байна. Холбогдох баримт бичгийн боловсруулалтын одоогийн байдлыг доорх хүснэгтэнд тусгасан байна;

Үйл ажиллагаа бүрт боловсруулах баримт бичиг		Гүйцэтгэх байгууллага	Одоогийн байдал
Үр дүн 1	Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар	ОБЕГ	Зааврын төслийг боловсруулсан. Япон хэл рүү орчуулсаны дараа ЖМБ-аас санал авна.
	Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах улсын албадын төлөвлөгөө боловсруулах заавар	ОБЕГ	Боловсруулж байгаа. 2018 оны 6-р сарын дундуур зааврын төслийг боловсруулах төлөвтэй байна.
	Аймаг/сумын газар хөдлөлтийн	ОБЕГ	Зааврын төслийг боловсруулсан.

	гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар		Туршилтын аймгуудаас ирүүлэх саналын үндсэн дээр шинэчилнэ.
	Нийслэл/дүүргийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар	НОБГ	Зааврын төслийг боловсруулсан. Япон хэл рүү орчуулсаны дараа ЖМБ-аас санал авна.
	Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний заавар	ОБЕГ	Ерөнхий үнэлгээний зааврын төслийг ЖМБ-ын саналын үндсэн дээр шинэчилсэн. Нарийвчилсан үнэлгээний зааврын төслийн бүтцийг гаргасан.
	Гамшгийн мэдээллийн сангийн заавар	ОБЕГ	Боловсруулж байгаа. 2018 оны 6-р сарын эцсээр зааврын төслийг боловсруулж дуусгах төлөвтэй байна.
	Санамж бичиг	ОБЕГ эсвэл холбогдох байгууллага	Үйл ажиллагаа 1.2.1-т заасны дагуу найман (8) санамж бичгийн төслийг боловсруулсан байна.
	Цагаан ном	ОБЕГ	Монгол хувилбарыг боловсруулж дууссан. Англи болон Япон хэл рүү орчуулах ажил явагдаж байна.
Үр дүн 2	Одоогийн цутгамал төмөр бетон бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ болон хүчитгэлийн аргачлал	БХБЯ	БХБЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр шалгагдаж байна.
	Одоогийн угсармал том хавтгаалжин бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ болон хүчитгэлийн аргачлал	БХБЯ	БХБЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр шалгагдаж байна.
	Одоогийн тоосгон өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ болон хүчитгэлийн аргачлал	БХБЯ	БХБЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр шалгагдаж байна.
	Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ	БХБЯ	БХБЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр дэмжигдэж, одоогоор сайдын тушаалаар батлагдахыг хүлээж байна.
Үр дүн 3	“Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөр	БСШУСЯ	2018 оны 4-р сарын 6-ны өдөр батлагдсан
	“Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн сурах бичиг	БСШУСЯ	Ажил явагдаж байна

## **1-5 Эрсдэлийн өөрчлөлт болон эрсдэлийг бууруулах арга хэмжээ**

### **(1) Үр дүн 1**

#### **1) Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хурлын бэлтгэл ажлын Төсөлд үзүүлсэн нөлөө**

А/Х 1-ийн олон гишүүд бага хурлын бэлтгэлийг хангах ажлын хэсгийн гишүүдээр томилогдсон байна. Бага хурал 7-р сарын эхэнд зохион байгуулагдах бөгөөд хурлын бэлтгэл ажилд их цаг зарцуулсан учир энэ нь Төслийн үйл ажиллагааны явцад нөлөөлсөн байна. Жишээлбэл, Төслийн хүрээнд гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хариуцсан Баянмөнх нь бага хурлын бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар томилогдсон учир туршилтын нэг аймагт явуулсан үйл ажиллагаанд оролцох боломжгүй байсан. Мөн түүнчлэн, бага хурлын дараа А/Х 1-ийн гишүүд ээлжийн амралтаа авах магадлалтай байгаа учраас 8-р сарын дунд үе буюу ээлжийн амралтын хугацаа дуусах үе хүртэл Төслийн үйл явц саатах магадлал байна.

### **(2) Үр дүн 2**

#### **1) Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний нарийвчилсан аргачлалын материал**

Цутгамал төмөр бетон болон угсармал том хавтгаалжин бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлалын хувьд энгийн болон нарийвчилсан гэсэн хоёр түвшний үнэлгээний аргачлалыг боловсруулсан байна. Энгийн аргачлалыг нь А/Х 2-ын гишүүдээс гадна бусад байгууллагуудын инженерүүдэд танилцуулсан боловч нарийвчилсан аргачлал нь илүү түвэгтэй бөгөөд тооцооллын хэрэгсэл шаардсан учир түүнийг танилцуулаагүй байна. Гэвч, нарийвчилсан аргачлал нь энгийн аргачлалтай харьцуулбал илүү оновчтой үнэлгээ болон илүү өндөр Is оноо өгдөг учир, барилга байгууламжийг хүчитгэх үүрэгтэй ажилтнуудын хувьд нарийвчилсан арга нь илүү тохиромжтой юм.

Ийм учир, ЖМБ А/Х 2-тай хамтарч илүү нарийвчилсан материалыг тооцооллын хэрэгсэлтэй хамт боловсруулж хувийн хэвшлийн холбогдох инженер, ажилтнуудад мэдлэг, технологи шилжүүлэх ажлыг явуулах төлөвлөгөөтэй байна.

Мөн, нарийвчилсан аргачлалыг үр дүнтэй танилцуулахын тулд дээр дурдсан материалыг ашигласан сургалт зохион байгуулах шаардлагатай. Иймээс, А/Х 2 МБИХ эсвэл өөр холбогдох байгууллагатай хамтарч сургалтын хөтөлбөрийг хянаж, инженерүүдийг идэвхтэй оролцуулахын тулд тус сургалтын хөтөлбөрийг албан ёсны

болгож батална.

## **2) Хүчитгэлийн туршилтын барилгуудын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ**

6-р сард зохион байгуулагдах сургалтын дараа А/Х 2 5 туршилтын барилгыг хүчитгэх үйл ажиллагаа явуулна. Барилга байгууламжийг хүчитгэх технологи нь Монголд шинээр нэвтэрч орсон бөгөөд газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээг оновчтой гаргахад газар дээрх хяналт, шалгалт хийх шаардлагатай тул энэхүү төслийг цаг тухайд нь хэрэгжүүлэхэд А/Х 2 болон ЖМБ хоорондын мэдээллийн солилцоо хангалттай байх шаардлагатай байна.

Ажлын төлөвлөгөөний дагуу дээр дурдсан ажил 6-р сарын эцсээр дуусч, хүчитгэлийн зураг төслийг 7-р сард боловсруулж эхлэх шаардлагатай байна. А/Х 2 болон ЖМБ нь хоорондоо үүрэг, хариуцлагаа хуваарилж, ажлыг аль болох түргэн эхлүүлэх шаардлагатай байна.

### **(3) Үр дүн 3**

#### **1) Үндсэн хичээлийн агуулгад суурилсан гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг олгох Аюулгүй амьдрах ухаан сургалтын хөтөлбөр**

Ажлын хэсэг 3-1-ийн гишүүдийн хүчин чармайлтын хүчинд “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөр 2018 оны 4 сарын 6-ны өдөр батлагдсан. Монголын сургуулиудад энэхүү сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд сургалтын хөтөлбөрийн агуулгын талаар багш нарт заах арга зүйн талаар сургалт өгөх, гамшгаас хамгаалах боловсролын талаар мэдээлэл, ойлголт өгөх шаардлагатай. Гамшгаас хамгаалах сургалтын агуулга нь одоогийн сургалтын агуулга, төсөлт хичээл, хичээлээс гадуур үйл ажиллагааны агуулгад өмнө байгаагүй шинэ агуулга, эсвэл нэмэлт агуулга болох бөгөөд багш нар хичээл явуулахад мэдээлэл дутмаг, гамшгаас хамгаалах боловсролын аргачлал ба багшлах төлөвлөгөөний ойлголт хангалтгүй байгаагаас зарим нэг хүндрэл гарах магадлалтай. Мөн түүнчлэн орон нутгийн боловсролын байгууллагын гамшгаас хамгаалах боловсролын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх шаардлагатай. Энэ үүднээс БСШУСЯ-ны зүгээс Монгол улсын хэмжээнд заах арга зүйч багш нарт чиглэсэн сургалт явуулах хүсэлт ирүүлсэн.

Төслийн багаас зөвхөн нийслэл Улаанбаатар хотод сургалт явуулах байсан эхний төлөвлөгөөг өөрчлөх шаардлагатай арга хэмжээ авах талаар Монголын талын хамтрагч байгууллагуудтай ярилцана.

## **2) Бусад төслүүдтэй зохицуулалт хийх**

Үйл ажиллагааны хугацаанд АХЗ-ын гишүүд Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа явуулдаг бусад хандивчлагч байгууллагуудтай зохицуулалт хийж, хамтран ажиллаж ирсэн. Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг явуулахад дэмжлэг үзүүлэх ойрын жилүүдийн цөөнгүй төлөвлөгөө байгаа ба үүний дагуу АХЗ-ын зүгээс хязгаарлагдмал эх үүсвэрийг үр дүнтэй ашиглах талаар бусад байгууллагатай нөхөрсөг байдлаар үргэлжлүүлэн хамтран ажиллахыг хичээх болно.

### **1-6 ЖАЙКА-ын хариуцсан үйл ажиллагааны явц**

Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвд суурилуулах газар хөдлөлтийн чичирхийллийг биеэр мэдрэх тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн үйл явцыг ЖАЙКА-гийн төв эхлүүлсэн байна. Тус тоног төхөөрөмжийн Монголд ирэх хугацаа нь 2018 оны 11-р сараас өмнө байхаар төлөвлөгдөж байна.

ЖАЙКА-гийн Монгол дахь төлөөлөгчийн газрын эхлүүлсэн газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний тоног төхөөрөмжийн нийлүүлэлт нь төлөвлөсөн хугацаанаасаа хоцрох төлөвтэй байна. Японы тал нь энэхүү тоног төхөөрөмжийг ашиглах тухай сургалтыг тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн дараа удахгүй зохион байгуулахыг хүлээн зөвшөөрсөн.

### **1-7 Монгол Улсын Засгийн газрын хариуцсан үйл ажиллагааны явц**

Үр дүн 2: Барилгын дүрмийн баталгааны тайланг БХТ бэлтгэсний дараа түүнийг БХБЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөл дэмжиж сайдын тушаалаар батлуулна. Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний заавар одоогоор сайдын тушаалаар батлагдах шатанд байна.

### **1-8 Байгаль орчны болон нийгмийн чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц (хэрэгжүүлсэн тохиолдолд)**

N/A

### **1-9 Жендерийн эрх тэгш байдал/Энхийг дэмжих/Ядуурлыг бууруулах**

**чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц (хэрэгжүүлсэн тохиолдолд)**

N/A

**1-10 Төсөлтэй холбоотой анхаарвал зохих бусад асуудал (жишээлбэл: ЖАЙКА-ын бусад төслүүд, төсөл хамтран хэрэгжүүлэгч байгууллага, бусад донор орнуудын хэрэгжүүлж буй төсөл, хувийн хэвшил, төрийн бус байгууллага гэх зэргийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа)**

Үр дүн 2: А/Х 2-ын гишүүний бүрэлдэхүүнийг дараах шалтгаануудын улмаас өөрчлөх шаардлагатай байна; А/Х 2-ын дэд дарга болох Баттулга ОБЕГ-т өөр ажил руу шилжсэн бөгөөд ГЗБГЗЗГ-ын Гантулга байгууллагаасаа гарсан байна. ОБЕГ нь төслийн оролцогч тал мөн бөгөөд ГЗБГЗЗГ нь МХЕГ-г төлөөлж үнэлгээ хийх учир эдгээр байгууллагуудаас шинэ гишүүд томилох шаардлагатай байна.

**2. Ажлын төлөвлөгөөнд гарсан саатал ба/эсвэл асуудал (гарсан тохиолдолд)**

**2-1 Асуудлын талаарх мэдээлэл**

N/A

**2-2 Асуудал гарах болсон шалтгаан**

N/A

**2-3 Хариу арга хэмжээ**

N/A

**2-4 Хариуцаж буй ажилтан/байгууллагын үүрэг (ЖАЙКА, Монгол Улсын Засгийн газар, гэх мэт)**

N/A

**3. Төслийн хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөнд оруулсан өөрчлөлт**

**3-1 РО**

N/A

**3-2 Хэрэгжүүлэлтийн нарийвчилсан төлөвлөгөөнд орсон бусад өөрчлөлт**



(Жич: Х/Т болон ТТМ-д орох өөрчлөлтүүдийг (төслийн нэр, үргэлжлэх хугацаа, төсөл хэрэгжүүлэх газар(ууд), зорилтот бүлэг(үүд), хэрэгжүүлэлтийн бүтэц зохион байгуулалт, ерөнхий зорилт, төслийн зорилго, үр дүн, үйл ажиллагаа болон зохион байгуулалт) ЖАЙКА-ын Төв байгууллага батална. Хэрэв төслийн баг Х/Т болон ТТМ-д ямарваа нэгэн өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл, төслийн баг оруулах өөрчлөлтийн төслийг боловсруулж санал болгож болно.)

N/A

#### **4. Төсөл дууссаны дараа Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэх үйл ажиллагааны бэлтгэл ажил**

Энэ хугацаанд тодорхой бодлого, арга хэмжээний талаар хэлэлцэж санал солилцоогүй байна.

#### **II. Төслийн хяналтын хуудас**      *доор хавсаргав*

Газар хөдлөлтийн гамшгийн үед авах арга хэмжээн дэх санамж бичгийн ач холбогдлын талаар ойлгуулах сургалтыг өмнөх хяналтын хугацаанд хэрэгжүүлсэн байна. Сургалтыг хэрэгжүүлсэн туршлагын үндсэн дээр, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зааврын төслийг А/Х-1 боловсруулна.

**Үйл ажиллагаа 1.3.1** Улс болон орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хяналт, тайлан, үнэлгээ хийх болон нийтлэхтэй холбоотой асуудлыг тодорхойлох

Энэхүү үйл ажиллагааг өмнөх хяналтын хугацааны эцэст гүйцэтгэсэн байна.

Монгол улсад хэрэгжиж буй гамшгаас хамгаалах төлөвлөгөөнүүдийг судалсны үндсэн дээр Үйл ажиллагаа 1.1.2-т заасан дөрвөн (4) төрлийн Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зааврыг боловсруулахаар шийдсэн байна.

**Үйл ажиллагаа 1.3.2** 1.3.1-д дурдсан төлөвлөгөөг шинэчлэн сайжруулах гарын авлага боловсруулах

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэх / шинээр боловсруулах туршилтын үйл ажиллагаануудыг туршилтын нутаг дэвсгэрүүд болох

Дархан-Уул, Өмнөговь аймгууд болон УБ хотын Баянгол, Чингэлтэй дүүргүүдэд хэрэгжүүлжээ. А/Х 1 энэхүү үйл ажиллагааны хүрээнд хэд хэдэн сургалт зохион байгуулсан байна. Сургалтын үеэр зааврын төслүүдийг танилцуулах, дэд бүтцийн салбарын гишүүдийг оролцуулан ажлын хэсгийг бүрдүүлэх, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах хуваарийг тогтоох, газар хөдлөлтийн эрсдэлийг үнэлэх, гамшгийн үзүүлэх сургууль зохион байгуулах, эрсдэлийг бууруулах зорилтуудыг тогтоох зэрэг үйл ажиллагаа явагджээ. Сургалтын үйл ажиллагааны тоймыг Хүснэгт 1.1-д тусгасан байна.

Сургалтын үр дүнг зааврын төслүүдэд тусгана.

Хүснэгт 1.1 Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэх туршилтын үйл ажиллагаанууд

Туршилтын нутаг дэвсгэр	Сургалтын нэр	Огноо	Оролцогчдын тоо	Үйл ажиллагаа
Дархан-Уул аймаг	Сургалт 1	2018 оны 5-р сарын 16, 17	19	<ul style="list-style-type: none"> <li>• Зааврын танилцуулга</li> <li>• Өнөөгийн мэдээллийг шалгах</li> <li>• Газар хөдлөлтийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ</li> </ul>
	Сургалт 2	2018 оны 9-р сарын 18, 19	12	<ul style="list-style-type: none"> <li>• Зааврын танилцуулга</li> <li>• Өнөөгийн мэдээллийг шалгах</li> <li>• Газар хөдлөлтийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ</li> </ul>
Өмнөговь аймаг	Сургалт 1	2018 оны 5-р сарын 24, 25	17	<ul style="list-style-type: none"> <li>• Ажлын хэсгийг бүрдүүлэх</li> <li>• Төлөвлөлтийн хуваарийг тогтоох</li> <li>• Гамшгийн үзүүлэх сургууль зохион байгуулах</li> <li>• Эрсдэлийг бууруулах зорилтуудыг тогтоох</li> </ul>
	Сургалт 2	2018 оны 9-р сарын 28	13	<ul style="list-style-type: none"> <li>• Ажлын хэсгийг бүрдүүлэх</li> <li>• Төлөвлөлтийн хуваарийг тогтоох</li> <li>• Гамшгийн үзүүлэх сургууль зохион байгуулах</li> <li>• Эрсдэлийг бууруулах зорилтуудыг тогтоох</li> </ul>
Баянгол дүүрэг	Хамтарсан сургалт	2018 оны 8-р сарын 28, 29	8	<ul style="list-style-type: none"> <li>• Зааврын танилцуулга</li> <li>• Өнөөгийн мэдээллийг шалгах</li> <li>• Гамшгийн үзүүлэх сургууль зохион байгуулах</li> <li>• Чухал ухагдахуунуудыг онцлох</li> </ul>
Чингэлтэй дүүрэг			8	

### Үйл ажиллагаа 1.3.3 Гамшгаас хамгаалах мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх одоогийн системийг шинэчлэн сайжруулах

Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын 14 дүгээр зүйл “Гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх”-д ОБЕГ нь гамшгийн мэдээллийн санг

сайжруулах ажлыг хэрэгжүүлнэ гэж заасан. ОБЕГ-ын дээр дурьдсан хуулийн дагуу гүйцэтгэх чиг үүрэг болон "Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ"-ний тэргүүлэх чиглэлүүдийг Монгол улсад хэрэгжүүлэхэд оруулах хувь нэмэр зэрэг үйл ажиллагааны хүрээнд А/Х 1 дээр өнөөгийн тогтолцоог шинэчлэн сайжруулах бодлогын талаар авч үзэж санал солилцсоны үр дүнд одоогийн байдлаар дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:

### **1) Гамшгийн орон зайн мэдээллийн санг ашиглах зааврыг боловсруулах**

Үйл ажиллагаа 1.1.2-т заасны дагуу I-DSIS-д суурилсан Орон зайн мэдээллийн сангийн ашиглалт болон удирдлагын зааврын төслийг шинээр байгуулагдсан тасгийн ажлын журам, үүрэг, хариуцлагыг авч үзэж боловсруулж байгаа. 2018 оны 9-р сарын эхээс 10-р сарын дунд хүртэл дэд А/Х-ийн гишүүд шинээр байгуулагдсан тасгийн албан тушаалтнуудтай зааврын төсөл болон түүнд хавсаргах техникийн бичиг баримтуудын агуулгын талаар ЖМБ-ийн дэмжлэгтэйгээр долоо хоног бүр зохион байгуулсан сургалтын үеэр нэлээд тодорхой ярилцаж, 2018 оны 10-р сарын сүүлээр зааврын төслийг түүнд хавсаргах зарим бичиг баримттай нь боловсруулж дууссан бөгөөд одоогоор ОБЕГ-ын даргаар батлуулах үе шатанд явж байна.

### **2) ОБЕГ-т хэрэгжиж буй гамшгийн тохиолдлын бүртгэлийн мэдээллийг удирдах системийг шинэчлэх**

ОБЕГ-ын Гамшиг судлалын хүрээлэн нь 2005 оноос хойших гамшгийн тохиолдлуудын бүртгэл, мэдээллийг хөтөлж ирсэн бөгөөд эдгээр мэдээллийг MS Excel програмаар бүртгэдэг байна. Орон нутгийн онцгой байдлын хэлтсүүд өөр өөр хэлбэрээр гамшгийн мэдээллийг тайлагнадаг. Улмаар, ОБЕГ-т хүний нөөц дутагдаж байгаа учир гамшгийн мэдээллийг цөөн тооны албан тушаалтнууд бүртгэдэг байна.

Шинэ тасгийг байгуулснаас хойш орон нутгийн гамшгийн тохиолдлын мэдээллийг бүртгэх ажлыг уг тасаг руу шилжүүлжээ. Сендайн үйл ажиллагааны хүрээний нийтлэг зорилтуудын биелэлтийг хянаж, тайлагнахтай холбогдуулан, дэд-А/Х-ийн гишүүд I-DSIS-д суурилсан Орон зайн мэдээллийн санг ашиглаж орон нутгийн онцгой байдлын хэлтсүүдээс ирүүлсэн гамшгийн тохиолдлуудын мэдээллийг сайжруулах сэдвээр ярилцсан байна. Улмаар, А/Х 1-ийн гишүүд ОБЕГ-ын Гамшгийн шуурхай удирдлага, Зарлан мэдээллийн төвийн одоогийн удирдаж буй өдөр тутмын гамшгийн мэдээ мэдээллийн системийг сайжруулах ажыг эхлүүлжээ. 2018 оны 10-р сарын эцсийн байдлаар энэхүү сайжруулалтын үйл ажиллагаа явагдсаар байна.



### **3) Холбогдох байгууллагуудтай орон зайн мэдээлэл хамтран ашиглах гэрээ байгуулах**

Дэд А/Х-ийн гишүүд Монгол Улсад хэрэгжүүлж байгаа гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хамтран ашиглах орчинг боловсронгуй болгох үүднээс байр зүйн зураг, газар хөдлөлтийн мужлалын бичил зураглал, барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ гэх мэт нарийвчилсан мэдээлэл бүхий байгууллагууд болон ОБЕГ хооронд орон зайн мэдээлэл хамтран ашиглах гэрээ байгуулах үйл ажиллагаанд анхаарал хандуулж ажилласан.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (ГЗБГЗЗГ), ОБЕГ-ын хооронд техникийн болон удирдлага, зохион байгуулалтын асуудлуудаар санал солилцож хэлэлцсэний дараа 2018 оны 4-р сарын дундуур орон зайн мэдээлэл хамтран ашиглах гэрээг байгуулсан

ОБЕГ, Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газартай (НХТЕТГ) хоорондын гэрээ одоогоор хэлэлцэх шатанд явж байна. НХТЕТГ нь Улаанбаатар хотын гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд энэхүү мэдээлэл солилцох ажлын ач холбогдол болон үр дүнг ойлгож байгаа бөгөөд хоёр тал энэхүү гэрээг байгуулахад үндсэндээ санал нийлж байна. Энэхүү гэрээг байгуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх үүднээс ОБЕГ-аас НХТЕТГ-т албан бичиг хүргүүлсний үр дүнд хоёр тал орон зайн мэдээллийн солилцооны талаар илүү тодорхой хэлэлцэхийг зөвшөөрсөн байна.

### **4) ОБЕГ-т гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд орон зайн мэдээллийн санг ашиглах сургалт зохион байгуулах**

I-DSIS-д суурилсан Орон зайн мэдээллийн санг удирдаж ажиллуулах шинэ бүтэц зохион байгуулалтыг бий болгох үүднээс ОБЕГ, НОБГ болон 21 аймгийн онцгой байдлын газар, хэлтсийн хүний нөөцийн чадавхыг үнэлэх болон бэхжүүлэх нь чухал арга хэмжээний нэг бөгөөд уг арга хэмжээни хүрээнд эхний ээлжинд, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд орон зайн мэдээллийн санг ашиглах хоёр өдрийн сургалтыг 2018 оны 3-р сарын 12, 13-ны өдрүүдэд ОБЕГ-т зохион байгуулав.

2018 оны 10-р сарын 24, 25-ны өдрүүдэд дэд А/Х-ийн гишүүд I-DSIS-д суурилсан Орон зайн мэдээллийн сангийн ашиглалт, удирдлагын 2-р сургалтыг зохион байгуулж, орон хутгийн онцгой байдлын хэлтсүүдийн 30 албан тушаалтнуудыг оролцуулжээ. Эдгээр албан тушаалтнууд системийг өөрсдөө бие даан ашиглах хэмжээнд хүрэхэд шаардлагатай мэдлэгийг олгох нь энэхүү сургалтын гол зорилго байжээ. Сургалтанд оролцсон ихэнх албан тушаалтнууд ГМС-ийн анхан шатны мэдлэгтэй байсан тул I-DSIS-ийг эзэмшхэд бэрхшээл тулгараагүй юм.



Зураг 1.1 2018 оны 10-р сарын 24, 25-ны өдрүүдэд зохион байгуулсан I-DSIS-ийн сургалтын үйл явц

**Үйл ажиллагаа 1.3.4 Үйл ажиллагаа 1.3.1 болон 1.3.2-т заасан улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжүүлэлт, хяналт, үнэлгээ зэрэг үйл ажиллагааны талаар Монгол улсын иргэдэд мэдээлэх зорилго бүхий гамшгаас хамгаалах цагаан номыг боловсруулах**

Цагаан номын төслийг 2018 оны 7-р сард боловсруулж, ОБЕГ-ын даргаар батлуулсан бөгөөд одоогоор Цагаан номын хэв загварын талаар санал солилцож байна. Цагаан номыг 2018 оны 12-р сард хэвлэн гаргана. Цагаан номын агуулгыг Хүснэгт 1.2-т тусгав.

Хүснэгт 1.2 Цагаан номын агуулга

<p><b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ШИНЭЧЛЭЛ</b></p> <p>1.1. Монгол Улсын гамшгаас хамгаалах тухай хууль, тогтоомж</p> <p>1.2. Гамшгаас хамгаалах бодлогын баримт бичиг</p> <p>1.3. Гамшгаас хамгаалах тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт</p> <p><b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b></p> <p>2.1. Монгол Улсад 2017 онд тохиолдсон аюулт үзэгдэл, гамшиг осол, хэрэгжүүлсэн арга хэмжээ</p> <p>2.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа</p> <p>2.3. Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа</p> <p>2.4. Гамшгийн бэлэн байдлыг хангах арга</p>	<p><b>ТАВДУГААР БҮЛЭГ. УЛСЫН НӨӨЦ, ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ</b></p> <p>5.1. Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн талаарх баримт бичиг</p> <p>5.2. Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаа</p> <p><b>ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b></p> <p>6.1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл</p> <p>6.2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай баримт бичиг</p> <p>6.3. Улаанбаатар хотын ойр орчим дахь хагарлын судалгаа</p> <p>6.4. Улаанбаатар хотын газар хөдлөлтийн шуурхай арга хэмжээний төлөвлөгөө</p>
---	---

<p>хэмжээ</p> <p>2.5. Гамшгийн үеийн зарлан мэдээлэл, шуурхай удирдлага зохицуулалт</p> <p>2.6. Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл</p> <p>2.7. Гамшгаас хамгаалах дадлага, сургууль</p> <p>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХ ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА</p> <p>3.1. Гамшгаас хамгаалах олон улсын хамтын ажиллагаа</p> <p>3.2. Гамшгаас хамгаалах албадын харилцан ажиллагаа</p> <p>3.3. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэний нийгэм, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо</p> <p>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ</p> <p>4.1. Галын аюулгүй байдлын талаарх баримт бичиг</p> <p>4.2. Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаа</p>	<p>ДОЛООДУГААР БҮЛЭГ. ГАМШИГ СУДЛАЛ, ГАМШГААС ХАМГААЛАХ СУДАЛГААНЫ АЖИЛ</p> <p>7.1. Гамшиг судлалын хүрээлэнгийн судалгаа шинжилгээний ажлууд</p> <p>7.2. Гамшгийн мэдээллийн сан</p> <p>НАЙМДУГААР БҮЛЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</p> <p>8.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт</p> <p>8.2. Гадаадын хөрөнгө оруулалт</p> <p>8.3. Онцгой байдлын ерөнхий газарт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр</p> <p>8.4. Гамшигт нэрвэгдэгсдэд олгох нөхөн олговор</p> <p>ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. 2017 ОНЫ ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН</p> <p>ХАВСРАЛТ</p>
--	--

2018 оны 7-р сард УБ хотод зохион байгуулагдсан бага хуралд зориулж Цагаан номын англи хувилбарын хураангуй товхимолыг А/Х 1-ийн гишүүд бэлтгэжээ. Уг товхимолыг 1,000 ширхэгээр хэвлэж бага хурлын оролцогчдод тараасан байна.

А/Х 1-ийн гишүүд одоогоор Цагаан номын боловсруулалтын гарын авлагыг бэлтгэж байна. Энэхүү гарын авлагад 2017 онд Цагаан номыг боловсруулах явцын талаар дараах зүйлсийг тусгажээ. Үүнд:

- Цагаан ном боловсруулах ажлын хэсэг байгуулах
- Цагаан номын найруулга болон агуулгыг хэлэлцэх
- Мэдээллийн эх үүсвэрийг тодорхойлох
- Материалыг цуглуулах
- Цуглуулсан материалыг цэгцлэх
- Цагаан номын төслийг бэлтгэх
- Цагаан номын төслийг хянан засах
- Англи хэл рүү орчуулах заавар, чиглэл
- Хэвлэлийн компаниар хянан засуулах, гэх мэт зүйлс орно.

Гарын авлагыг 2018 оны эцэст бэлэн болгосон байна.

**Үйл ажиллагаа 1.3.5 Барилга, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар**

хөдлөлт тэсвэрлэлтийн мэдээллийн сангийн системийг сайжруулах

Үйл ажиллагаа 1.3.3-т тайлбарласны дагуу, Орон зайн мэдээллийн сан нь холбогдох байгууллагуудын гүйцэтгэх барилга, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний үр дүнг хуримтлуулж, удирдах боломжтой байхаар зохион байгуулж байна. А/Х 1, А/Х 2-ын гишүүд эдгээр үнэлгээний үр дүнг холбогдох байгууллагуудаас авах тохиромжтой аргын талаар хэлэлцэнэ.

Дэд А/Х-ийн гишүүд НХТЕТГ-тай мэдээлэл солилцох (үүнд барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ хамрагдана) гэрээ байгуулах ажлыг гүйцэтгэж байна. Мөн түүнчлэн, А/Х 1-ийн гишүүд ЖАЙКА-гийн өмнө гүйцэтгэсэн "Монгол Улсын Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдлээс хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд гүйцэтгэсэн барилга, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээг Орон зайн мэдээллийн санд оруулах төлөвлөгөөтэй байна. Эдгээр ажлыг гүйцэтгэсний үр дүнд Орон зайн мэдээллийн сан сайжирч, ОБЕГ эдгээр үнэлгээнүүдий үр дүнг гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагаанд ашиглах боломжтой болно.

**(3) Үр дүн 2**


**Үйл ажиллагаа 2.1.1** Гамшгаас хамгаалах тухай хуулийн хүрээнд, Барилга, Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнд газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ хийх журам, зааварт дүн шинжилгээ хийж шинэчилсэн заавар боловсруулах

Энэхүү үйл ажиллагааг өмнөх хяналтын хугацааны эцэст гүйцэтгэсэн болно.

А/Х 2-ын гишүүд холбогдох байгууллагуудын албан тушаалтнуудтай хамтарч одоо хэрэгжиж буй барилга, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний үнэлгээний норм, нормативыг судалсан бөгөөд энэхүү судалгаагаар илрүүлсэн асуудлуудыг Төслийн хүрээнд шинээр боловсруулах заавруудад тусгана.

**Үйл ажиллагаа 2.1.2** Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлал, Үнэлгээнд хэрэглэгдэх хэмжилтийн багаж төхөөрөмжийг ашиглах заавар боловсруулах

А/Х 2 нь Бүдүүвч 2.1-т заасан байдлаар норм, нормативийн баримт бичгийг боловсруулах дарааллын дагуу боловсруулахаар шийдсэн. Энэхүү бүдүүвчинд мөн үйл ажиллагааны явцыг үзүүлэв.



БХТ: Барилга хөгжлийн төв, ЗҮБ: Зөвлөх үйлчилгээний баг



Бүдүүвч 2.1 Барилгын дүрэм боловсруулах ажлын дараалал

### 1) Барилга, байгууламжийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлал боловсруулах

2017 оны 12-р сард Зөвлөх үйлчилгээний баг (цаашид "ЗҮБ" гэх) цутгамал төмөр бетон, угсармал том хавтгаалжин болон тоосгон өрөгт бүтээцтэй барилга тус бүрийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлалын төслийг БХТ-д хүргүүлж, БХТ-ийн холбогдох мэргэжлийн зөвлөлөөс (цаашид "ХМЗ" гэх) техникийн санал авсан байна. Аргачлалын төсөлд газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ болон хүчитгэлийн талаарх агуулга орсон тул техникийн санал нь тус хоёр сэдвийн дагуу ирүүлсэн.

А/Х 2 болон ЗҮБ нь хүргэгдэж ирсэн саналуудыг тусгаж дүрмийн төслийг шинэчилж 2018 оны 4-р сард БХТ-д дахин хүргүүлсэн. ирүүлж, БХТ-ын ХМЗ нь дүрмийн төслийг БХБЯ-аар батлуулахаар хүргүүлэхийг дэмжсэн. 2018 оны 8-р сард дүрмийн төслийг БХБЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөл (цаашид "ШУТЗ" гэх) хэлэлцэж, сайдын тушаалаар батлуулахыг зөвшөөрсөн болно.

Зураг 2.1-т үзүүлсний дагуу, 2018 оны 11-р сард дүрмийг сайдын тушаалаар баталсан байна.



Тушаал 3 төрлийн барилгатай холбоотой хавсралт  
Зураг 2.1 Аргачлалыг баталсан БХБЯ-ны сайдын тушаал

А/Х 2-ын тал гаруй гишүүд нь 2018 оны 9-р сарын ХЗХ-ны хурлаар шинээр томилогдсон учир, А/Х 2-ын гишүүд 2018 оны 9-р сарын 22, 23-ны өдрүүдэд дүрэм дэх аргачлалын дагуу А/Х 2-ын шинэ гишүүдэд танилцуулах 2 өдрийн сургалтыг зохион байгуулсан.

### 2) Инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлал боловсруулах

Инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлал нь

2017 оны 12-р сард БХБЯ-ны ШУТЗ-р хэлэлцэгдэж дэмжигдсэн. Гэвч, тус аргачлалд инженерийн шугам сүлжээнээс гадна зам, гүүрийн үнэлгээ орсон тул БХБЯ тус аргачлалыг ЗТХЯ-д хүргүүлж, үүний үр дүнд ЗТХЯ тус аргачлалыг сайдын хамтарсан тушаалаар батлахыг БХБЯ-аас хүсчээ.

Аргачлалыг БХБЯ-ны сайд 2018 оны 9-р сард баталсан бөгөөд ЗТХЯ-аар батлуулахаар дахин хүргүүлсэн байна.

**Үйл ажиллагаа 2.1.3: Барилга, байгууламж болон шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээг хийх мэргэжилтнүүдийн мэдлэг, үр чадварыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах**

А/Х 2, БХБЯ, ОБЕГ, МХЕГ, БХТ, МБИХ нар хамтран 2018 оны 6-р сарын 4-нөөс 6-ны өдөр хүртэл цутгамал төмөр бетон, угсармал том хавтгаалжин болон тоосгон өрөгт бүтээцтэй барилга тус бүрийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний сургалтыг БХТ-ийн хурлын танхимд зохион байгуулсан. Сургалтын оролцогчдын тоо МХЕГ болон орон нутгийн холбогдох мэргэжилтнүүдийн хамт 110 орчим байсан нь төлөвлөснөөс олон байсан бөгөөд, газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний энэхүү аргачлалд холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүд ач холбогдол өгсөний илрэл юм.

Сургалтын үйл ажиллагааны хувьд танхимын сургалтаас гадна үнэлгээний аргачлалыг ашиглаж дадлага ажил хийх, Шинжлэх ухаан техникийн их сургуулийн (цаашид "ШУТИС" гэх) професор Дүйнхэржав барилга байгууламжийн үл эвдэх аргачлалын тухай танилцуулсан.



Лекц



Тоног төхөөрөмжийн тайлбар

Зураг 2.2 Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний сургалт

Дээр дурдсан сургалтын дараа 2018 оны 6-р сарын 7-ны өдөр БХБЯ, ОБЕГ, МХЕГ, БХТ нар хамтран Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний сургалтыг БХТ-ийн хурлын танхимд зохион байгуулсан.

Сургалтад оролцогчдын тоо МХЕГ болон орон нутгийн холбогдох мэргэжилтнүүдийн хамт 70 хүн байсан нь мөн л ач холбогдол өндөртэй болсны илрэл юм.



Лекц



Гэрчилгээ гардуулах ёслол

Зураг 2.3 Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний сургалт

Мөн Эрдэнэт хотын инженерүүдийн хүсэлтийн дагуу МБИХ-ны сургалтын хөтөлбөрийн хүрээнд 2018 оны 9-р сард Эрдэнэт хотод газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний нэг өдрийн сургалтыг зохион байгуулсан. Энэхүү сургалтыг өмнө нь зохион байгуулагдсан сургалтын лекц, дадлага ажлын материалыг ашигласан. Сургалтад нийт 23 хүн хамрагдагсан бөгөөд оролцогчдын дунд дулаан хангамж болон бусад салбарын инженерүүд байсан.

Энэхүү сургалтанд хамрагдсанаар мэргэшсэн инженер болоход шаардлагатай “кредит оноо” авах боломжтой байсан учир оролцогчид сургалтанд маш идэвхитэй оролцсон. Иймээс цаашид, МБИХ-тэй хамтарч сургалт зохион байгуулах нь газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлалыг Монгол улсад нэвтрүүлэх нэгэн арга зам байж болох юм.



Лекц



Үнэлгээний дасгал ажил

Зураг 2.3 Эрдэнэт хотод зохион байгуулагдсан сургалт



Барилга байгууламжийг үл эвдэх аргаар шалгах, газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээнд ашиглах 5 тоног төхөөрөмжийг ЖАЙКА-аас ОБЕГ-т 2018 оны 11-р сарын 12-ны өдөр хүлээлгэж өгсөн. Үүний дараа А/Х 2 нь эдгээр тоног төхөөрөмжийн тухай 2 өдрийн сургалтыг 2018 оны 11-р сарын 12, 13-ны өдрүүдэд БХТ-ийн хурлын танхимд зохион байгуулсан.

Сургалтад төрийн байгууллагууд төдийгүй хувийн компаниудаас хүрэлцэн ирж, нийт 64 хүн хамрагдсан. А/Х-ийн гишүүд, Японы мэргэжилтнүүд болон Монголын хувийн хэвшлийн мэргэжилтнүүдэд сургалтын үеэр лекц уншиж, тоног төхөөрөмжийн хэрэглээнээс гадна түүнийг хэрхэн ашиглаж газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ гаргах тухай танилцуулсан байна.

Сургалтын үеэр бетоны бат бөхийг хэмжих болон арматурын байршил, диаметрийг тогтоох зэрэг практик ажлыг явуулжээ. Сургалтын талаарх санал асуулга явуулахад оролцогчдын дийлэнх нь сургалтын практик ажилд сэтгэл хангалуун гэж хариулжээ. Энэхүү сургалтын хүрээнд бэлтгэсэн материалыг цаашид зохион байгуулах сургалтад ашиглана.



Дурсгалын зураг



Гар камер ашигласан лекц



Бетоны бат бөхийг хэмжих практик



Арматурын хэмжих практик

Зураг 2.4 Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний тоног төхөөрөмжийн сургалт

**Үйл ажиллагаа 2.2.1 Барилга байгууламжийг хүчитгэх, шинэчлэн барих тухай**

заавар аргачлал боловсруулах

А/Х 2 нь барилга, байгууламжийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ, хүчитгэлийгнэгтгэж, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнээс гадна барилгын бүтээцийн төрөл тус бүрд аргачлалыг боловсруулахаар шийдсэн. Учир нь газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ нь барилгын хүчитгэлтэй шууд холбоотой.


Өмнө дурдсаны дагуу, аргачлалыг БХБЯ-ны сайд 2018 оны 11-р сарын 6-нд баталсан байна.

Үйл ажиллагаа 2.2.2: Орон сууц, цэцэрлэг, сургууль, эмнэлэг, төрийн захиргааны барилга, хүчитгэх, загвар зураг төсөл боловсруулах

А/Х 2 нь хүчитгэлийн зураг төсөл боловсруулах барилгуудыг сонгосох талаар хэлэлцэж, Хүснэгт 2.1-ын дагуу өөр өөр бүтэц, зориулалттай таван барилгыг сонгожээ. Эдгээр барилгуудын байршил болон зургыг Зураг 2.5-д тусгасан байна.

Хүснэгт 2.1 Хүчитгэлийн зураг төсөл боловсруулахаар сонгогдсон барилга


Бүтээц	Зориулалт	Нэр	Байршил	Тайлбар
Тоосгон өрөгт бүтээц	Цэцэрлэг	105-р цэцэрлэг	Сонгино хайрхан дүүрэг	Нэг маягийн зургаар Улаанбаатар хотод хамгийн олон баригдсан цэцэрлэгийн барилга
	Сургууль	23-р сургууль	Чингэлтэй дүүрэг	Нэг маягийн зургаар баригдсан тоосгон бүтээцтэй том хэмжээний сургуулийн барилга
	Төрийн байгууллага	ОБЕГ-ын төв байр	Сүхбаатар дүүрэг	Гамшгийн үед шуурхай арга хэмжээ авах үүрэг бүхий төрийн байгууллагын барилга
Цутгамал төмөр бетон бүтээц	Эмнэлэг	1-р төрөх эмнэлгийн өргөтгөл	Сүхбаатар дүүрэг	Цутгамал төмөр бетон бүтээцтэй барилга бүхий цөөн тооны Улсын эмнэлгийн нэг
Угсармал хавтгаалжин бүтээц	Орон сууц	9 давхар барилга	Баянгол дүүрэг	Нэг маягийн зургаар Улаанбаатар хотод хамгийн олон баригдсан угсармал хавтгаалжин орон сууцны барилга




Зураг 2.4 Хүчитгэлийн зураг төсөл боловсруулахаар сонгогдсон барилгуудын байршил болон зураг

A/X 2 нь Зураг төсөл, тооцоо, газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний тайлан гэх мэт барилгын хүчитгэлд шаардлагатай мэдээллийг цуглуулсан. Үүний дараа, хүчитгэлийн зураг төсөл боловсруулахад шаардлагатай газар хөдлөлт тэсвэрлэлтийн нарийвчилсан үнэлгээг хийж гүйцэтгэнэ.

Зураг 2.5-д цутгамал төмөр бетон бүтээцтэй эмнэлэгийн барилгын хүчитгэлийн зураг төслийг жишээ болгон харуулав. Хүчитгэл хийхийн өмнөх болон хийсний дараах Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний дүнг Зураг 2.6-д харуулав.



Зураг 2.5 Нэмэлт хана барьж цутгамал төмөр бетон бүтээцтэй барилгыг хүчитгэх байдал жишээ



Хүчитгэлийн өмнө

Хүчитгэлийн дараа

Зураг 2.6 Нэмэлт хана цутгаж барилгыг хүчитгэсэн үр дүн

#### (4) Үр дүн 3

Үйл ажиллагаа 3.1.1 Гамшгаас хамгаалах тухай хуультай уялдсан цэцэрлэг, сургуулийн гамшгаас хамгаалах боловсролын агуулга, арга зүй, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон удирдамж боловсруулах

Энэхүү үйл ажиллагаа “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөр боловсруулагдан, 2018 оны 4 сарын 6-ны өдөр (өмнөх тайлангийн хугацаанд) батлагдсанаар бүрэн дуусгавар болсон.

**Үйл ажиллагаа 3.1.2: Цэцэрлэг, сургуулийн гамшгийн эрсдэлийг бууруулах сургалтад ашиглах сурах бичгийн нэмэлт материал, сургалтын материал зэргийг**

“Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг дагалдан гарах багшид зориулсан гарын авлагыг боловсруулах ажил 2018 оны 9 сард болсон воркшоп болон ажлын

Түүнчлэн, гарын авлагын эхний хувилбарыг сургагч багшийн сургалтын явцад танилцуулсан (Үйл ажиллагаа 3.1.3). Сургалтын явцад олж авсан мэдлэг болон дадлага ажлын жишээн дээр тулгуурлан гарын авлагын эхний хувилбарыг 2018 оны 10 ба 11 сард дахин хянасан. Гарын авлагын сүүлийн хувилбар дээр ажлын хэсгийн гишүүд ажиллаж, ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн 2019 оны 1 сарын сүүл гэхэд эцэслэх төлөвлөгөөтэй байна.

**Үйл ажиллагаа 3.1.2: Цэцэрлэг, сургуулийн гамшгийн эрсдэлийг бууруулах сургалтад ашиглах сурах бичгийн нэмэлт материал, сургалтын материал зэргийг боловсруулах**

2018 оны 6, 7 саруудад сургалтын хугацаа болон ложистик асуудлын талаар хэлэлцээд сургалтын төлөвлөгөөнд бага зэрэг өөрчлөлт оруулсан. Ажлын хэсгийн гишүүд эхлээд Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд болон Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институтын арга зүйчдэд зориулан үндэсний сургагч багшийн сургалт явуулж, орон нутгийн арга зүйчдэд зориулсан сургалтын хөтөлбөр болон агуулгыг тогтоох нь зүйтэй гэж үзсэн. Түүний үр дүнд, үндэсний болон орон нутгийн сургагч багшийн сургалтыг амжилттай явуулсан. Дэлгэрэнгүйгээр доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3.2 Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт

	Үндэсний сургагч багшийн сургалт	Орон нутгийн сургагч багшийн сургалт (1дэх сургалт)	Орон нутгийн сургагч багшийн сургалт (2дахь сургалт)
Сургалт явагдсан газар	УБ хот	УБ хот	УБ хот
Хугацаа	2018.9.11-13	2018.9.17-20	2018.10.8-11
Сургалтад оролцогч	Боловсролын хүрээлэн, БМДИ, НИГХСАЗТ-ийн багш	Орон нутгийн бага, дунд боловсролын арга зүйч нар	Орон нутгийн СӨБ хариуцсан арга зүйч нар
Оролцогсдын тоо	Нийт 50 хүн	Аймаг, нийслэл, дүүргийн БСГ-аас тус бүр 2 хүн (Нийт 60 хүн)	Аймаг, нийслэл, дүүргийн БСГ-аас 1 хүн (Нийт 30 хүн)

Сургалтын агуулгыг доорх хүснэгтэд үзүүлэв. Оролцогчоос хамааран агуулга нь хоорондоо бага зэрэг ялгаатай буй.

## Хүснэгт 3.3 Сургалтын хөтөлбөрийн гол агуулга


Эхний өдөр	2 дахь өдөр	3 дахь өдөр	4 дэх өдөр
<p><b>Keynote Talk:</b> 1) Олон улсын гамшгийн эрсдэлийг бууруулах хүрээ ба гамшгаас хамгаалах боловсрол 2) Аюулгүй амьдрах ухаан - Монгол улсын боловсролын бодлогод 3) Гамшгаас хамгаалах хууль, эрх зүйн баримт бичиг</p> <p><b>Биеэр мэдрэх сургалт:</b> НИГХСАЗТ-ийн танхимтай танилцах, сургалт авах</p> <p><b>Мэдээлэл 1:</b> Гамшиг ба гамшгаас хамгаалах тухай ерөнхий ойлголт</p> <p><b>Мэдээлэл 2:</b> Гамшгаас хамгаалах боловсролын гол агуулга, гамшгаас хамгаалах боловсролын олон улсын жишээ</p> <p><b>Мэдээлэл 3:</b> “Хэн ч, хэзээ ч, хаана ч бэлэн” гамшгаас хамгаалах буухиа тэмцээний танилцуулга</p> <p><b>Дадлага ажил 1:</b> “Хэн ч, хэзээ ч, хаана ч бэлэн” гамшгаас хамгаалах буухиа тэмцээн</p>	<p><b>Дадлага ажил 2:</b> Гамшгаас хамгаалах боловсрол олгох тоглоом: Кроссроуд тоглоом</p> <p><b>Мэдээлэл 4:</b> Сургуулийн аюулгүй байдал ба гамшгаас хамгаалах сургуулийн хөтөлбөрийн жишээ</p> <p><b>Дадлага ажил 3:</b> Заах арга зүйн зөвлөмж</p> <p><b>Мэдээлэл 5:</b> “Бэлэн бай!” сургалтын хэрэглэгдэхүүний танилцуулга</p> <p><b>Дадлага ажил 4-6:</b> Бэлэн бай сургалтын багц хэрэглэн дадлага ажил явуулах:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймэртэй тэмцэх</li> <li>➢ Газар хөдлөлтийн бэлэн байдал</li> <li>➢ Ахуйн хэрэглээний химийн бодис, материалын зохистой хэрэглээ</li> </ul>	<p><b>Мэдээлэл 6:</b> “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн танилцуулга</p> <p><b>Дадлага ажил 7:</b> “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөр ба сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн уялдаа</p> <p><b>Дадлага ажил 8:</b> Туршилтын хичээл</p>	<p><b>Мэдээлэл 7.</b> XXI зууны суралцагчийн чадвар, үнэлгээ</p> <p><b>Мэдээлэл 8:</b> Сургууль, цэцэрлэгийн гамшгаас хамгаалах менежмент ба сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт</p> <p><b>Дадлага ажил 8:</b> Манай гэр аюултай юу?</p> <p><b>Дадлага ажил 9:</b> Сургууль/цэцэрлэгийн жилийн сургалт, үйл ажиллагааны төлөвлөлт</p> <p><b>Дадлага ажил 10:</b> “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйг багш нарт түгээх сургалт зохион байгуулах үйл ажиллагааны зураглал гаргах</p>



Зураг 3.1 Үндэсний сургагч багшийн сургалт (зүүн тал), бага, дунд боловсролын арга зүйч нарын сургалт (дунд тал) ба СӨБ-ын арга зүйч нарын сургалт (баруун тал)

Сургалтын дараа 3-1 ажлын хэсгийн гишүүд уулзаж, сургалтын үр дүнг нэгтгэн ярилцаж, цаашдын үйл ажиллагааны талаар санал дэвшүүлсэн. Түүн дотор,

БМДИ-ийн үндсэн сургалтын хөтөлбөрт “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн агуулгыг багтаах, мөн туршилтын сургууль цэцэрлэгийг сонгон аюулгүй амьдрах ухааны сургалтыг явуулах зэрэг ажлууд багтаж байна. Сургалтад оролцогчдоос сургалтын талаар асуулга авсан бөгөөд түүний үр дүнг дор харуулав. Цаашдын сургалтын талаар 2019 оны 3 сард хэлэлцэх төлөвлөгөөтэй байна.



Зураг 3.2 Сургалтад оролцогсдын сана асуулгын үр дүн


### **3.1.4 3.1.3-ын сургалтад хамрагдсан арга зүйч, мэргэжилтнүүд багш нараар удирдуулан сургуулийн багш нарт сургалт явуулах**

Ажлын хэсэг 3-1-ийн гишүүд 2019 оны 3-р сард сонгогдсон сургууль, цэцэрлэгт загвар хичээл явуулах талаар шийдвэрлэсэн.

### **Үйл ажиллагаа 3.2.1 Төв, орон нутгийн гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны нэгдсэн график төлөвлөгөө боловсруулах**

<Сургалтын төлөвлөгөөний мэдээлэл нийтлэх веб хуудас>


2018оны 6 сарын 25-ны өдөр болсон ажлын хэсэг 3-2-ын хурлаар, гишүүд сургалтын төлөвлөгөөнд оруулах агуулга, бүтэц, системд оруулах өгөгдлийн талаар ярилцсан. 2018 оны 10, 11 сард төслийн баг болон ОБЕГ хамтран вэб сайтын бүтэц, мэдээлэл шивж оруулах эрх, хэрхэн удирдан хариуцаж ажиллах талаар хэлэлцсэн. Вэб хуудас хөгжүүлэх ажлыг 2019 оны 1 сарын эцсээр дуусгах төлөвлөгөөтэй байна.



Зураг 3.3 Сургалтын төлөвлөгөөний вэб хуудасны бүдүүвч зураг

**Үйл ажиллагаа 3.2.2 Гамшгаас хамгаалах боловсрол олгох сургалт, сурталчилгааны материал боловсруулж, зорилтот бүлгийн сургалтыг сонгогдсон бүс нутагт зохион байгуулах**

Ажлын хэсэг 3-2-ын гишүүд сургууль дээр зохиогдсон сургагч багшийн болон иргэдэд зориулсан гамшгаас хамгаалах сургалтын үр дүнд тулгуурлан, орон даяар түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Хэн ч, хэзээ ч, хаана ч бэлэн” гамшгаас хамгаалах буухиа тэмцээний гарын авлагыг боловсруулан гаргасан. Энэхүү гарын авлагад буухиа тэмцээний өртөө тус бүрийн танилцуулга ба буухиа тэмцээнд хэрэглэх хэрэглэгдэхүүний талаар танилцуулгыг багтаасан байна.



ОБЕГ

Төслийн баг “Хэн ч, хэзээ ч, хаана ч бэлэн” гамшгаас хамгаалах буухиа тэмцээний гарын авлагыг хэвлүүлж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор, 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргийн онцгой байдлын холбогдох байгууллагад тараав. Үүнээс гадна ОБЕГ нь МУЗН-ийн сайн дурын ажилтнуудад зориулж, МУЗН-ийн санхүүжилтээр дахин 500 ширхэгийг нэмж хэвлүүлэхээр бэлтгэж байна. Гарын авлагын хуулбарыг ОБЕГ-ын вэбсайт дээр байршуулсан бөгөөд хүссэн хүн түүнийг татаж авах боломжтой.

Сургагч багшид болон иргэдэд чиглэсэн сургалтад ашиглагдах сургалтын тоног төхөөрөмжийг НОБГ дээр хадгалж байгаа бөгөөд, сургалт явуулах сонирхолтой ОБЕГ



байгууллага иргэдэд түрээсээр хэрэглүүлэх юм.

**Үйл ажиллагаа 3.2.3 Сургалтын төвд гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн нөхцөл байдлыг биеэр мэдрүүлэх сургалт, сурталчилгааны хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах**

<Газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхимын самбар>

Ажлын хэсэг 3-2-ын гишүүдээс Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн нэг багшийг самбар гаргах ажилд томилсон. 2018 оны 9-р сард хэд хэдэн удаагийн уулзалтын дараа доорх хүснэгтэд үзүүлсний дагуу хийж гаргах самбарыг шийдвэрлэв.

**Хүснэгт 3.4 Самбарын агуулга (төсөл)**

1) Анхаарах агуулга бүхий самбар	7) Монгол улсад өмнө болж байсан хүчтэй газар хөдлөлтүүдийг газрын зургаар үзүүлэх
2) Газар хөдлөлт гэж юу вэ? газар хөдлөлтийн механизм	8) Монгол улсад өмнө болж байсан хүчтэй газар хөдлөлтийн тоо баримт, гэрэл зураг
3) Дэлхийн газар хөдлөлтийн тоо баримт, дэлхийн газрын зураг дээр	9) Монгол улс, Улаанбаатар хот орчимд болох магадлалтай 3 газар хөдлөлтийн төсөөллийн тоо баримт, газрын зураг дээрх тэмдэглэгээ
4) Хёого мужийн өмнөд хэсгийн /Кобэгийн/ газар хөдлөлт	10) Гэр доторх тавилгын хүчитгэлийн талаар тайлбарласан жижиг самбар /барилгын макетны ойролцоо тавигдах/ *4)-6) for as information of shakes of the Shaking Table
5) Кумамотогийн газар хөдлөлт	
6) Нийгата мужийн Чюүэцү газар хөдлөлт	

Төслийн багийн зүгээс 2018 оны 9, 10, 11 саруудад болсон уулзалтаар самбартай холбогдуулан техникийн зөвлөгөө өгч, мэдээлэл, материал, тоо баримт гаргаж өгсөн. Түүнчлэн, самбарт ашиглагдах мэдээ баримтны талаар ООГФХ болон бусад холбогдох байгууллага хооронд зохицуулалт хийж ажиллалаа.

<Газар хөдлөлтийн тэсвэржилт, хүчитгэлийн талаар суралцах барилгын макет>

Ажлын хэсэг 3-2-ын гишүүд нь НИГХСАЗТ-ийн нэг багшийг барилгын макет хийх хүнээр томилсон. Томилогдсон багшид дэмжлэг үзүүлэхийн тулд, 2018 оны 6 сараас 11 сар хүртэл техникийн зөвлөгөө өгөх уулзалт хурлыг зохион байгуулсан.



Зураг 3.5 Барилгын макетны туршилтын загвар

<Сургалтын материал: Хүүхдийн өрөөний гамшгаас хамгаалах сургалтын асуулт хариулт>

Түүнчлэн, НИГХСАЗТ-ийн нэг багш хүүхдийн өрөө хариуцсан багшаар томилогдсон. Тэрбээр СӨБ-ийн арга зүйч нарт зориулсан сургалтад хамрагдаж, хүүхдэд зориулсан сургалтын материал хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүйн талаар ойлголт мэдлэгээ гүнзгийрүүлсэн. Ажлын хэсэг 3-2-ын хурлаар мөн энэ асуудлын талаар ярилцаж, боловсруулах сургалтын материалын талаар авч хэлэлцэх болно.

## 1-3 Хүрсэн үр дүн

### (1) Үр дүн 1

Төслийн төлөвлөлтийн матрицын (ТТМ) дагуу Үр дүн 1-ийн гүйцэтгэлийг дараах гурван шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

#### 1.1 Боловсруулсан заавар, дүрмийн тоо.

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

А/Х 1 хоёр (2) төрлийн Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний заавар, дөрвөн (4) төрлийн Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар болон нэг (1) Гамшгийн мэдээллийн санг ашиглах зааврыг тус тус боловсруулах төлөвлөгөөтэй байна.

Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний зааврын хүрээнд, ерөнхий үнэлгээний зааврыг түүнтэй дагалдах хялбарчилсан тооцооллын програм хангамжийн хамт боловсруулж газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний туршилтын үйл ажиллагаанд туршиж үзсэн байна. Нарийвчилсан үнэлгээний зааврын хувьд, А/Х 1-ийн гишүүд одоогийн байдлаар уг зааврыг боловсруулж байна.

А/Х 1-ийн гишүүд Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, Аймаг/сумын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар болон УБ хот/дүүргийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, зэргийг боловсруулав. Одоогоор газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах улсын албадын төлөвлөгөө боловсруулах зааврыг боловсруулж байна.

Гамшгаас хамгаалах мэдээллийн санг ашиглах зааврын хувьд, уг зааврыг түүнд хавсаргах бичиг баримттай нь хамт 2018 оны 10-р сард боловсруулж дууссан байна. Одоогоор ОБЕГ-ын даргаар батлуулах үе шатанд явж байна.

#### 1.2 Боловсруулсан санамж бичгийн төслийн тоо болон санамж бичгийн талаар санал солилцсон, холбогдох сургалтанд оролцсон байгууллагууд

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

2018 оны 6-р сараас 11-р сар хүртэлх хугацаанд дор дурдсан хоёр (2) санамж бичгийг байгуулжээ.

- Түр хорогдох байр, түр сууцанд шилжин ирсэн гамшигт нэрвэгдэгсдэд

шаардагдах ундны цэвэр ус, хоол, хүнсээр хангах: Санамж бичгийг ОБЕГ, ХХААХҮЯ нар 2018 оны 10-р сарын 16-ны өдөр байгуулав.

- Гамшгийн үед эм, эмийн хэрэгслээр хангах: Санамж бичгийг ОБЕГ болон эм ханган нийлүүлдэг 3 том компани нар 2018 оны 11-р сарын 7-ны өдөр байгуулав.

Дор дурдсан салбаруудын санамж бичгийн төслүүд одоогоор хэлэлцэх шатанд явж байна.

- Барилгын материал болон түр хорогдох байраар хангах
- Гамшгийн үеийн тээвэрлэлт, замын хөдөлгөөнийг аюулгүй байдлыг хангах
- Гамшгийн үед түлш, шатахуунаар хангах
- Гамшгийн үед нэн тэргүүнд холбогдох телефон үйлчилгээ
- Түр хорогдох байрны цэвэр, бохир усны хангамж

Газар хөдлөлтийн гамшгийн үед авах хариу арга хэмжээний үр дүнтэй эсэхийг туршиж, эрүүл мэндийн болон бусад салбаруудын санамж бичгийг дэмжих үүднээс санамж бичгийн ач холбогдлыг танилцуулах зорилготойгоор 2018 оны 4-р сард УБ хотод хамтарсан сургалт зохион байгуулжээ. Олон салбаруудаас нийт 38 оролцогчид уг сургалтанд оролцсон байна.

### 1.3 Гамшгаас хамгаалах Цагаан ном

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

Цагаан номын төслийг 2018 оны 7-р сард боловсруулж, ОБЕГ-ын даргаар батлуулсан бөгөөд одоогоор Цагаан номын хэв загварын талаар санал солилцож байна.

### **(2) Үр дүн 2**

Төслийн төлөвлөлтийн матрицын (ТТМ) дагуу Үр дүн 2-ын гүйцэтгэлийг дараах хоёр шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

#### 2.1 Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний заавар: газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний сургалтанд оролцсон хүний тоо

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

А/Х 2 барилга (цутгамал төмөр бетон, угсармал том хавтгаалжин болон тоосгон өрөгт бүтээцтэй), дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт

тэсвэрлэлтийн дөрвөн (4) төрлийн аргачлалыг боловсруулсан байна. Барилгын үнэлгээний аргачлалыг БХБЯ-ны сайд 2018 оны 6-р сарын 6-нд баталсан бөгөөд одоо түүнийг нийтлэх ажил явагдана. Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний аргачлалыг БХБЯ-ны сайдаар батлуулсан бөгөөд одоогоор ЗТХЯ-ны сайдаар батлуулж, сайдын хамтарсан тушаал гаргахыг хүлээж байна.

БХБЯ-ны ШУТЗ-өөр аргачлалыг батлуулсны дараа А/Х 2 барилгын газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээний сургалтыг 2018 оны 6-р сарын 4-нөөс 6-ны өдөр хүртэл зохион байгуулж, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний үнэлгээний сургалтыг 2018 оны 6-р сарын 7-нд зохион байгуулжээ. Барилгын үнэлгээний сургалтанд 110 оролцогчид оролцсоны дотор МХЕГ-ын байцаагч нар байсан бөгөөд оролцогчдын тоо тамагласнаас илүү байсан. Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний үнэлгээний сургалтанд 70 оролцогчид оролцсон нь мөн тамагласнаас илүү тоо байжээ.

Дээр дурдсан сургалтаас гадна 2018 оны 9-р сарын 8-ны өдөр МБИХ-ны хүсэлтийн дагуу Эрдэнэт хотод газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний сургалт явуулсан бөгөөд энэхүү сургалтанд Эрдэнэтийн 23 инженер оролцжээ. МБИХ-ын сургалтанд амжилттай оролцсоноор итгэмжлэгдсэн инженер болоход шаардлагатай "оноо" авах боломжтой учир эдгээр сургалтуудад оролцогчид маш идэвхитэй оролцдог байна. Иймээс, МБИХ-ны сургалтаар дамжуулан газар хөдлөлт тэсвэрлэлт болон хүчитгэлийн технологийг дэлгэрүүлэх нь илүү үр дүнтэй аргын нэг байж болох юм.

Барилга байгууламжийг эвдэлгүйгээр хяналт, шалгалт хийж газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх тоног төхөөрөмжийн тухай 2 өдрийн сургалтыг 2018 оны 11-р сарын 12, 13-ны өдрүүдэд зохион байгуулжээ. Энэхүү сургалтанд 64 оролцогчид оролцсон байна.

## 2.2 Хүчитгэлийн аргачлал болон зохион байгуулсагдсан хүчитгэлийн сургалтын тоо

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

А/Х 2-ын гишүүд дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнээс тусад нь барилгын бүтээц тус бүрийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ болон хүчитгэлийн аргачлалыг нэгтгэхээр шийджээ. Үүний дагуу, А/Х 2 цутгамал төмөр бетон, угсармал том хавтгаалжин болон тоосгон өрөгт бүтээцтэй барилга тус бүрийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ, хүчитгэлийн гурван (3) аргачлалыг боловсруулж БХБЯ-ны сайдаар 2018 оны 11-р сарын 6-ны өдөр батлуулжээ.

### **(3) Үр дүн 3**

Төсөл төлөвлөлтийн матрицын дагуу Үр дүн 3-ын үйл ажиллагааг дараах 2 шалгуур

үзүүлэлтээр үнэлнэ.

### 3.1 Төслийн хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр зохион байгуулагдсан сургалтын тоо

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

Ажлын хэсэг 3-1 нь 2018 оны 4 сард сургалтын хөтөлбөрөө батлуулж, суралцахуйн удирдамж бэлтгэх, мэдлэг дээшлүүлэх сургалтын агуулгыг боловсруулах ажлыг хийж байгаа бөгөөд одоогийн байдлаар тоон үзүүлэлтээр үнэлэх шатанд хүрч чадаагүй байна.

### 3.2 Сургалтын төвөөр үйлчлүүлэгчдийн тоо

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

Ажлын хэсэг 3 нь Нийслэлийн Иргэдийн Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвийн боловсролын сургалтын хөтөлбөр болон сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсронгуй болгох, сургалтын төвийн чадавхыг дээшлүүлэх зэрэг ажлыг хийж байгаа бөгөөд, одоогийн байдлаар тоон үзүүлэлтээр үнэлэх шатанд хүрч чадаагүй байна.

## 1-4 Төслийн зорилтын хүрээнд хүрсэн үр дүн

Төслийн төлөвлөлтийн матрицын (ТТМ) дагуу Төслийн зорилтын гүйцэтгэлийг дараах хоёр шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

### 1. Батлагдсан заавар, санамж бичгийн тоо

### 2. Шинээр боловсруулсан болон шинэчлэн сайжруулсан гамшгийн эрсдэлийг бууруулах мэдээллийн тоо

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

А/Х тус бүр заавар, санамж бичиг, газар хөдлөлт тэсвэрлэлт ба хүчитгэлийн норм, дүрэм болон сургалтын материал боловсруулах ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэсэн байна. Төсөл дууссаны дараах тогтвортой залгамж байдлыг хангахын тулд Төслийн хүрээнд боловсруулсан заавар болон бусад үр дүнг ОБЕГ, БХБЯ болон БСШУСЯ-аар батлуулах зорилготойгоор Төслийн үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж байна. Холбогдох баримт бичгийн боловсруулалтын одоогийн байдлыг доорх хүснэгтэнд тусгасан байна;

	Үйл ажиллагаа бүрт боловсруулах баримт бичиг	Гүйцэтгэх байгууллага	Одоогийн байдал
Үр дүн 1	Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар	ОБЕГ	Ажил явагдаж байна.
	Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах улсын албадын төлөвлөгөө боловсруулах заавар	ОБЕГ	Ажил явагдаж байна.
	Аймаг/сумын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар	ОБЕГ	Зааврын төслийг боловсруулсан. Туршилтын аймгуудаас ирүүлэх саналын үндсэн дээр шинэчилнэ.
	Нийслэл/дүүргийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар	НОБГ	Зааврын төслийг боловсруулсан. Туршилтын дүүргүүдээс ирүүлэх саналын үндсэн дээр шинэчилнэ.
	Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний заавар	ОБЕГ	Ерөнхий үнэлгээний зааврын төслийг ЖМБ-ын саналын үндсэн дээр шинэчилсэн. Нарийвчилсан үнэлгээний зааврын төслийн бүтцийг гаргасан.
	Гамшгийн мэдээллийн сангийн заавар	ОБЕГ	Зааврын төслийг хавсаргах бичиг баримттай нь боловсруулсан бөгөөд одоогоор ОБЕГ-ын даргаар батлуулах үе шатанд явж байна.
	Санамж бичиг	ОБЕГ эсвэл холбогдох байгууллага	Хяналтын хугацаанд хоёр (2) салбарт санамж бичиг байгуулж, таван (5) санамж бичгийн төслийг боловсруулсан байна.
	Цагаан ном	ОБЕГ	Цагаан номыг боловсруулж дууссан.
Үр дүн 2	Одоогийн цутгамал төмөр бетон бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ болон хүчитгэлийн аргачлал	БХБЯ	Аргачлалыг БХБЯ-ны сайд 2018 оны 11-р сарын 6-ны өдөр батласан.
	Одоогийн угсармал том хавтгаалжин бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ болон хүчитгэлийн аргачлал	БХБЯ	Аргачлалыг БХБЯ-ны сайд 2018 оны 11-р сарын 6-ны өдөр батласан.
	Одоогийн тоосгон өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ болон хүчитгэлийн аргачлал	БХБЯ	Аргачлалыг БХБЯ-ны сайд 2018 оны 11-р сарын 6-ны өдөр батласан.
	Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ	БХБЯ	Аргачлалыг БХБЯ-ны сайд баталсан бөгөөд одоогоор ЗТХЯ-ны сайдаар батлуулж, сайдын хамтарсан тушаал гаргахыг хүлээж байна.
Үр дүн 3	“Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөр	БСШУЯ	2018 оны 4-р сард баталсан.

Үйл ажиллагаа бүрт боловсруулах баримт бичиг	Гүйцэтгэх байгууллага	Одоогийн байдал
“Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн сурах бичиг	БСШУЯ	Ажил явагдаж байна.
Олон нийтийн гамшгаас хамгаалах сургалтын гарын авлага (DVD-тэй)	ОБЕГ	Боловсруулж дууссан бөгөөд 2018 оны 8-р сард 150 ширхэгийг хэвлэсэн байна.

## 1-5 Эрсдэлийн өөрчлөлт болон эрсдэлийг бууруулах арга хэмжээ

### (1) Үр дүн 1

#### 1) Албан тушаалтнууд байнга солигдож ажил эзгүйдэх

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зааврын хувьд, Аймаг/сумын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар болон Нийслэл/дүүргийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар зэрэг хоёр зааврыг боловсруулахаар төлөвлөсөн байсан боловч, Монголын талын хүсэлтийн дагуу Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар болон Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах улсын албадын төлөвлөгөө боловсруулах заавар тус бүрийг нэмж боловсруулахаар болсон байна. Энэхүү нэмэлт ажилд зориулж 2017 оны дундуур А/Х-т хоёр гишүүн шинээр нэмсэн байна.

Гэвч, шинээр нэмэгдсэн хоёр гишүүн нь 2018 онд шилжиж, тэдгээрийг орлох гишүүдийг хараахан томилоогүй байна. Нэмж боловсруулагдах хоёр заавар нь улсын хэмжээний гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зааврууд болох бөгөөд тэдгээрийг Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах байнгын хороо болон холбогдох яам, агентлагуудын үйл ажиллагаатай уялдуулах шаардлагатай юм. Энэ ажилд багагүй хэмжээний цаг зарцуулах төлөвтэй байгаа тул орлох гишүүдийг аль болох түргэн томилох шаардлагатай байна.

#### 2) 2018 оны Цагаан номны бэлтгэл ажил

2017 оны Цагаан номыг боловсруулж дууссан боловч 2018 оны Цагаан номны бэлтгэл ажил хараахан эхлээгүй байна. Цагаан номны 2018 оны хувилбарыг зохих хугацаанд нь нийтлэхийн тулд бэлтгэл ажлыг удахгүй эхлүүлэх шаардлагатай бөгөөд 2018 оны Цагаан номыг боловсруулах А/Х-ийг бүрдүүлэхийн тулд А/Х 1-ийн гишүүд гарын авлагын бэлтгэлийг хангаж, үүний талаар ОБЕГ-ын газар бүрт мэдэгдэх шаардлагатай байна. 2018 оны хувилбар нь Төслийн хугацаанд



боловсруулагдах тул ЖМБ ОБЕГ-тай хамтарч, сайжруулсан Цагаан номыг бэлтгэх шаардлагатай байна.

### **3) Сендайн үйл ажиллагааны хүрээний үзүүлэлтүүдийг харгалзан гамшгийн тохиолдлыг мэдээлэх одоогийн системийг шинэчлэх**

Сендайн үйл ажиллагааны хүрээний үзүүлэлтүүдийг харгалзан гамшгийн тохиолдлын мета-өгөгдлүүдийг цуглуулахад хэдэн бэрхшээл гарчээ. А/Х 1-ийн гишүүд энэ асуудлыг шийдэх хамгийн үр дүнтэй аргыг хоорондоо хэлэлцсэний үр дүнд, ОБЕГ-ын Гамшгийн шуурхай удирдлага, Зарлан мэдээллийн төвийн өдөр тутмын гамшгийн мэдээ мэдээллийн системийг шинэчлэхээр шийдсэн байна. Одоогоор дэд А/Х-ийн гишүүд системийн хэрэглэгчтэй харилцах хэсэг болон мэдээллийн сангийн нэгэн хэсгийг Сендайн үйл ажиллагааны үзүүлэлтүүдийн дагуу шинэчилж байна. Дэд А/Х-ийн гишүүд системийн шинэчлэлийн ажлыг цаг тухайд нь гүйцэтгэж, орон нутгийн гамшгаас хамгаалах хэлтсүүдийн мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтнүүдэд шинэчлэгдсэн системийн тухай зохих сургалтыг зохион байгуулахыг анхаарах шаардлагатай байна.

#### **(2) Үр дүн 2**

##### **1) Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ болон хүчитгэлийг хариуцсан албан тушаалтнуудын шилжилт**

6-р ХЗХ-ны хурлын өмнө А/Х 2-ын гишүүдийн тал орчим нь шилжсэнээс зарим нь голлох үүрэг гүйцэтгэж байжээ. Бүх гишүүд өөрсдийн хариуцсан ажил, үүргийг гүйцэтгэх аргачлалыг бэлтгэж, шинэ гишүүдийг шаардлагатай мэдээлэл, техникийн мэдлэгээр аль болох түргэн хангах шаардлагатай байна. Үүнд зориулж 2 өдрийн сургалт зохион байгуулжээ.

##### **2) Боловсруулсан аргачлалыг батлуулах ажил хойшлогдсон**

Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлалыг БХБЯ-ны ШУТЗ-өөр батлуулсанаас хойш арван (10) сар өнгөрсөн боловч өдий хүртэл сайдын тушаалаар батлагдаагүй байна. А/Х 2 энэ асуудлын талаар хоорондоо ярилцаж, Л. Билэгжаргалд батлуулах үйл явцыг хянаж шаардлагатай бол зохих арга хэмжээ авах үүргийг даалгасан байна.

#### **(3) Үр дүн 3**

##### **1) Веб хуудас хөгжүүлэлттэй холбоотой бусад төслүүдтэй хийх зохицуулалт**

Нэгдсэн график төлөвлөгөөний веб хуудас хийх ажил нь бусад хандивчлагчдын

санхүүжилтээр хэрэгжсэн ОБЕГ-ын мэдээлэл солилцох платформ ойр ойрхон өөрчлөгдөж байсны улмаас удаашралтай байсан. Эцэст нь ADPC байгууллагын боловсруулсан төсөл, хөтөлбөрүүдийн мэдээлэл солилцох веб платформ техникийн асуудлын улмаас зогсонги байдалд орсон тул ОБЕГ нь Дэлхийн зөн Монгол байгууллагын санхүүжилтээр тусдаа платформ хөгжүүлэлт хийсэн. Энэхүү өөрчлөлтийн тухай платформыг хийсний дараа ЖАЙКА-гийн мэргэжилтний багт дуулгасан бөгөөд мэдээлэл оруулах форматын талаар асуудал үүссэн. Веб платформыг ижил зорилгоор хөгжүүлэхэд холбогдох байгууллагуудын нэгдмэл алсын хараа, ГЭБ зорилго бүхий байгууллагын хувьд мэдээлэл солилцох зорилгын талаар ойлгуулах зэрэг зохицуулалт нэн чухал.

Холбогдох байгууллагуудын веб платформын системийн ялгаатай байдлыг олж мэдсэний дараа ОБЕГ болон ЖАЙКА-гийн мэргэжилтний багаас нэгдсэн график төлөвлөгөөний веб хуудас хөгжүүлэх талаар уулзаж ярилцах болгондоо тэдгээр байгууллагуудын төлөөллийг урьж оролцуулахыг хичээж ирсэн. Ингэснээр холбогдох гишүүн байгууллагууд үйл ажиллагааны зохицуулалтын давхардлыг бууруулахын тулд мэдээлэл солилцох нь чухал гэдгийг ойлгосон.

#### **1-6 ЖАЙКА-ын хариуцсан үйл ажиллагааны явц**

Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвд суурилуулах газар хөдлөлтийн чичирхийллийг биеэр мэдрэх тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн үйл явцыг ЖАЙКА-гийн төв эхлүүлсэн байна. Тоног төхөөрөмж 2018 оны 10-р сард УБ хотод ирсэн байна.

2017 оны 6-р сарын 26-ны өдөр зохион байгуулагдсан 3-р ХЗХ-ны хурлаар баталсан үйл ажиллагаа болон засвар үйлчилгээний (цаашид "ҮА/ЗҮ") төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлыг гүйцэтгэхийг Монголын талаас хүссэн байна. Улмаар, 2018 оны 9-р сарын эхээр хүчтэй борооны улмаас гамшгаас хамгаалах сургалтын төвийн зоорийн давхарт хөрсний ус нэвчсэн тул Японы тал ус нэвчихээс сэргийлэхэд шаардлагатай арга хэмжээ авахыг Монголын талаас хүссэн байна.

#### **1-7 Монгол Улсын Засгийн газрын хариуцсан үйл ажиллагааны явц**

Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвд суурилуулах газар хөдлөлтийн чичирхийллийг биеэр мэдрэх тоног төхөөрөмжийг суурилуулахаас өмнө Монголын тал газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхимын самбарыг сайжруулж, түүнд ус нэвтрэхээс хамгаалах арга хэмжээг авч, сургалтын төвийн суурийн давхар бүхэлд нь ус нэвчихээс сэргийлэх арга хэмжээ авах төсвийг гаргах үүрэгтэй байна.

**1-8 Байгаль орчны болон нийгмийн чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц (хэрэгжүүлсэн тохиолдолд)**

N/A

**1-9 Жендерийн эрх тэгш байдал/Энхийг дэмжих/Ядуурлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц (хэрэгжүүлсэн тохиолдолд)**

N/A

**1-10 Төсөлтэй холбоотой анхаарвал зохих бусад асуудал (жишээлбэл: ЖАЙКА-ын бусад төслүүд, төсөл хамтран хэрэгжүүлэгч байгууллага, бусад донор орнуудын хэрэгжүүлж буй төсөл, хувийн хэвшил, төрийн бус байгууллага гэх зэргийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа)**

N/A

**2. Ажлын төлөвлөгөөнд гарсан саатал ба/эсвэл асуудал (гарсан тохиолдолд)**

**2-1 Асуудлын талаарх мэдээлэл**

N/A

**2-2 Асуудал гарах болсон шалтгаан**

N/A

**2-3 Хариу арга хэмжээ**

N/A

**2-4 Хариуцаж буй ажилтан/байгууллагын үүрэг (ЖАЙКА, Монгол Улсын Засгийн газар, гэх мэт)**

N/A

**3. Төслийн хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөнд оруулсан өөрчлөлт**

**3-1 РО**

N/A

ОБЕГ

**3-2 Хэрэгжүүлэлтийн нарийвчилсан төлөвлөгөөнд орсон бусад өөрчлөлт**

(Жич: Х/Т болон ТТМ-д орох өөрчлөлтүүдийг (төслийн нэр, үргэлжлэх хугацаа, төсөл хэрэгжүүлэх газар(ууд), зорилтот бүлэг(үүд), хэрэгжүүлэлтийн бүтэц зохион байгуулалт, ерөнхий зорилт, төслийн зорилго, үр дүн, үйл ажиллагаа болон зохион байгуулалт) ЖАЙКА-ын Төв байгууллага батална. Хэрэв төслийн баг Х/Т болон ТТМ-д ямарваа нэгэн өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл, төслийн баг оруулах өөрчлөлтийн төслийг боловсруулж санал болгож болно.)

N/A

**4. Төсөл дууссаны дараа Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэх үйл ажиллагааны бэлтгэл ажил**

Энэ хугацаанд тодорхой бодлого, арга хэмжээний талаар хэлэлцэж санал солилцоогүй байна.

**II. Төслийн хяналтын хуудас**      *доор хавсаргав*

**Project Monitoring Sheet I Ver. 5.0 (Term: June, 2018 - November, 2018)**

**Project Title:** Project for Strengthening the National Capacity of Earthquake Disaster Protection and Prevention in Mongolia  
**Implementing Agency:** National Emergency Management Agency (NEMA)  
А/Х 1-ийн гишүүд нь туршилтын аймгуудад дагалдах програм хангамжийг танилцуулж, тухайн аймгуудын газар хөдлөлтийн гамшгийн үүсч болзошгүй хохирлын төсөөллийг тооцоолж гаргав.

## 2) Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар

А/Х 1-ийн гишүүд дараах дөрвөн (4) зааврын төслийг боловсруулж байна. Үүнд: Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах улсын албадын төлөвлөгөө боловсруулах заавар, Аймаг/сумын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар ба Нийслэл/дүүргийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, зэрэг юм.

Эдгээр заавруудаас "Улсын" болон "Улсын албадын" зааврууд нь улсын хэмжээний зааврууд болох бөгөөд эдгээрийг Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл болон холбогдох яам, агентлагуудын үйл ажиллагаатай уялдуулж, санал авах шаардлагатай юм. Юуны түрүүнд эдгээр заавруудыг ОБЕГ-ын Даргын зөвлөлөөр батлуулах шаардлагатай. Дээрх заавруудыг хариуцан ажиллаж байгаа А/Х 1-ийн шинэ гишүүд энэхүү 2 зааврыг нягтлаж 2019 оны 5-р сарын сүүл үеэр Даргын зөвлөлд танилцуулахаар бэлтгэлийг хангасан байна.

Үйл ажиллагаа 1.3.2-ын хүрээнд туршилтын аймаг, дүүргүүдийн Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж буюу шинэчлэн найруулж байна. Эдгээр туршилтын үйл ажиллагааны үр дүнд, тухайн аймаг, дүүргүүдийн гамшгаас хамгаалах төлөвлөлт хариуцсан мэргэжилтнүүдээс зааврын төсөл дээр санал авч, заавруудыг тодотгон сайжруулав. Тодотгосон заавруудыг Даргын зөвлөлд танилцуулж батлуулах төлөвлөгөөтэй байна.

## 3) Гамшгаас хамгаалах мэдээллийн сангийн заавар

Үйл ажиллагаа 1.3.3-ын хүрээнд “Гамшгийн орон зайн мэдээллийн системийн үйл ажиллагааг зохицуулах журам” (цаашид "ГОЗМС" гэх) 2019 оны 2-р сарын 20-ны өдрийн ОБЕГ-ын даргын А/47 тоот тушаалаар батлагдав. Уг журам нь “Гамшгийн кодчилол”, “Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн загвар” гэсэн 2 хавсралттай. Журам нь 9 бүлэгтэй бөгөөд тэдгээрийг доор хүснэгтээр үзүүлэв.

### Хүснэгт 2-1 Журмын агуулга ба хавсралтууд

<p><b>Гамшгийн орон зайн мэдээллийн системийн үйл ажиллагааг зохицуулах журам</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Нэг: Нийтлэг үндэслэл</li> <li>• Хоёр: Нэр томъёоны тайлбар</li> <li>• Гурав: Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн бүрдүүлэлт, түүнд тавигдах шаардлага</li> <li>• Дөрөв: ГОЗМС-ийн удирдлагын зохион байгуулалт</li> <li>• Тав: ГОЗМС-ийн ашиглалт</li> <li>• Зургаа: ГОЗМС-ийн хэрэглэгчийн чиг үүрэг</li> </ul>	<p><b>Хавсралт 1: Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн кодчилол</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• 1. Зорилго</li> <li>• 2. Гамшгийн кодчилол</li> <li>• 3. Суурь давхаргын буюу байршлын кодчилол</li> </ul> <p><b>Хавсралт 2: Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн загвар</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• 1. Танилцуулга</li> <li>• 2. Давхарга болон газрын зургийн нэршилд</li> </ul>
--	--

<ul style="list-style-type: none"> <li>• Долоо: ГОЗМС-ийн аюулгүй байдлыг хангах</li> <li>• Найм: Хориглох</li> <li>• Ес: Хариуцлага</li> </ul>	<p>тавигдах шаардлага</p> <ul style="list-style-type: none"> <li>• 3. Суурь болон сэдэвчилсэн давхаргад агуулга нэмэх, шинээр багана үүсгэх, текст мэдээлэл нэмэх, засварлахад тавигдах шаардлага</li> <li>• 4. Орон зайн мэдээллийн сангийн загварт нийтлэг хэрэглэх томъёолол</li> <li>• 5. Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн суурь давхаргуудын загвар</li> <li>• 6. Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн сэдэвчилсэн давхаргуудын загвар</li> </ul>
---	--

Журмын төслийг боловсруулах шатанд зааврын нэр нь “Интернэтэд суурилсан Гамшгийн орон зайн мэдээллийн системийг ашигласан Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн үйл ажиллагааг зохицуулах заавар” гэж байсан боловч эцсийн байдлаар дээр дурдсан нэрийг албан ёсоор ашиглах болсон.

**Үйл ажиллагаа 1.1.3 Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжүүлэлттэй холбоотой журам шинээр болон шинэчлэн сайжруулах журмын төслийг боловсруулах**

Энэхүү үйл ажиллагааг өмнөх хяналтын хугацаанд гүйцэтгэж дуусгасан байна.

А/Х 1-ийн гишүүд шинэчлэн найруулсан Гамшгаас хамгаалах тухай хуулийн гол төлөв эрсдэлийн үнэлгээ болон гамшгаас хамгаалах агуулгыг нягталсан бөгөөд шинэ дүрэм, журам боловсруулах эсвэл одоогийн дүрэм, журамд өөрчлөлт оруулах шаардлага байгаа эсэх талаар судалсан байна.

**Үйл ажиллагаа 1.2.1 ОБЕГ болон гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч байгууллагын харилцан ажиллагааг хангах гэрээ, санамж бичгийн төсөл боловсруулах**

Салбар тус бүрийн санамж бичиг боловсруулах үйл явцыг доор танилцуулав.

<Түр хорогдох байр, түр сууцанд шилжин ирсэн гамшигт нэрвэгдэгсдэд шаардлагатай ундны цэвэр ус, хоол, хүнсээр хангах>

Энэхүү санамж бичгийг 2018 оны 10-р сарын 16-ны өдөр ОБЕГ болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны (цаашид "ХХААХҮЯ" гэх) хооронд байгуулав.

<Гамшгийн үед эм, эмийн хэрэгсэл болон эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх>

Энэ санамж бичгийг өмнөх хяналтын хугацаанд Эрүүл мэндийн яам (цаашид "ЭМЯ" гэх) болон эм ханган нийлүүлдэг гурван том компанитай 2018 оны 11-р сарын 7-ны өдөр байгуулав.

ОБЕГ



<Барилгын материалын хангамжийн тогтвортой байдлыг хангах>

Барилга, хот байгуулалтын яам (цаашид "БХБЯ" гэх), Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо болон БХБЯ, Барилгачдын нэгдсэн холбоо хооронд байгуулах хоёр санамж бичгийг тус тус боловсруулж бэлтгэсэн. Санамж бичгүүдийг БХБ-ын сайд танилцаж зөвшөөрсөн бөгөөд ойрын хугацаанд байгуулахаар хүлээгдэж байна.

< Гамшгийн үеийн тээвэрлэлт, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах>

А/Х 1 дээр санамж бичгийн төслийг боловсруулж дууссан. Зам, тээврийн хөгжлийн яам (цаашид "ЗТХЯ" гэх) санамж бичгийн төслийг хянаж, саналаа тусгах шатанд явж байна.

<Гамшгийн үед түлш, шатахуунаар хангах>

А/Х 1-ийн гишүүд Ашигт малтмал, газрын тосны газартай (цаашид "АМГТГ" гэх) санамж бичгийн агуулгын талаар зөвлөлдсөн байна. 2018 оны 9-р сард ОБЕГ-ын тал шинэчлэн найруулсан санамж бичгийн төслийг АМГТГ-д хүргүүлсэн. АМГТГ нь санамж бичгийн төслийн агуулгыг судалж байна.

<Гамшгийн үед нэн тэргүүнд холбогдох телефон үйлчилгээ>

Нэн тэргүүнд холбогдох телефон үйлчилгээний техникийн асуудлыг шийдэх тал дээр үүрэн телефоны ЮНИТЕЛ компани судалж байна. Энэхүү асуудал шийдэгдсэний дараа санамж бичгийг эцэслэн байгуулах боломжтой юм. Гэвч, одоогийн байдлаар шийдэл гараагүй байна.

<Гамшгийн үеийн цэвэр усны хангамж>

А/Х 1 нь санамж бичгийн төслийг боловсруулж бэлэн болгов. ОБЕГ болон УСУГ нь

<Түр хоргодох байр>

А/Х 1 нь анх сургуулийн барилгыг түр хоргодох байр болгон ашиглах тухай НОБГ болон НЗДТГ-ын Боловсролын газрын хооронд байгуулах санамж бичгийн агуулгыг судалж байсан бөгөөд Япон Улсын буцалтгүй тусламжаар баригдаж буй сургуулийн барилгын гамшгаас хамгаалах зориулалт бүхий байгууламжуудыг ашиглах талаар санамж бичигт тусгасан байв. Үүний талаар хэлэлцсэний үр дүнд зөвхөн сургуулийн барилгыг түр хоргодох байр болгож ашиглахаас гадна бусад олон нийтийн барилга байгууламжийг түр хоргодох байр болгож ашиглах талаар санамж бичигт тусгаж НОБГ ба НЗДТГ-ын хооронд байгуулахаар шийдсэн болно. А/Х 1 нь тус санамж

бичгийн төслийг боловсруулаад байна.

<Бохир усны шугам сүлжээ>

А/Х 1 нь НОБГ болон НЗДТГ-ын Хот тохижилтын газрын хооронд байгуулах санамж бичгийн төслийг боловсруулав. Санамж бичгийн төслийг Хот тохижилтын газарт хүргүүлж санал авах ажил явагдаж байна.

**Үйл ажиллагаа 1.2.2** Үйл ажиллагаа 1.2.1-т заасан санамж бичгүүдийг олон нийтэд мэдээлэх болон гамшгаас хамгаалах байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог бэхжүүлэх сургалт зохион байгуулах

Энэхүү үйл ажиллагаа нь өмнөх хяналтын хугацаанд хийгдэж дууссан.

Газар хөдлөлтийн гамшгийн хариу арга хэмжээн дэх санамж бичгийн ач холбогдлын талаарх сургалтыг өмнөх хяналтын хугацаанд хэрэгжүүлэв. Сургалтыг хэрэгжүүлсэн туршлага дээр үндэслэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарын авлагын төслийг А/Х-1 боловсруулна.

**Үйл ажиллагаа 1.3.1** Улс болон орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хяналт, тайлан, үнэлгээ хийх болон нийтлэхтэй холбоотой асуудлыг тодорхойлох

Энэхүү үйл ажиллагаа нь өмнөх хяналтын хугацаанд хийгдэж дууссан.

Монгол улсад хэрэгжиж буй гамшгаас хамгаалах төлөвлөгөөнүүдийг судалсны үндсэн дээр Үйл ажиллагаа 1.1.2-т заасан дөрвөн (4) төрлийн Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зааврыг боловсруулахаар шийдсэн.

**Үйл ажиллагаа 1.3.2** 1.3.1-д дурдсан төлөвлөгөөг шинэчлэн сайжруулах гарын авлага боловсруулах

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэх/ шинээр боловсруулах туршилтын үйл ажиллагаануудыг туршилтын орон нутаг болох Дархан-Уул, Өмнөговь аймгууд болон УБ хотын Баянгол, Чингэлтэй дүүргүүдэд үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. А/Х 1 энэхүү үйл ажиллагааны хүрээнд хэд хэдэн сургалт зохион байгуулсан байна. Тус сургалтад хамрагдсан мэргэжилтнүүдийг Харилцаа холбоо, Хот байгуулалт-дэд бүтэц, Эрүүл мэнд-хүрээлэн буй орчин, Гамшгаас хамгаалах арга хэмжээ-боловсрол гэсэн 4 бүлэгт хувааж сургалтыг зохион байгуулав. Бүлэг тус бүр дээр газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ, тэдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага, хугацаа болон шаардлагатай төсөв хөрөнгийн талаар ярилцсан байна. Эдгээрийн үр дүнг “гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүснэгт”-д нэгтгэсэн болно.

Хүснэгтэд оруулсан агуулга нь газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг бүрдүүлэх юм. Сургалтын үйл ажиллагааны тоймыг Хүснэгт 2.2-т үзүүлэв.

Сургалтын үр дүнг зааврын төслүүдэд тусгана.

Хүснэгт 1.1 Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэх туршилтын үйл ажиллагаа

Туршилтын орон нутаг	Сургалтын нэр	Огноо	Оролцогчдын тоо	Үйл ажиллагаа
Дархан-Уул аймаг	Сургалт 3	2018 оны 11-р сарын 15, 16	18	<ul style="list-style-type: none"> <li>Гамшгийн эрсдэлийг бууруулах 10 жилийн зорилт дэвшүүлэх</li> <li>Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилтод тулгарч буй асуудлыг тодорхой болгох</li> <li>Тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг төлөвлөх</li> </ul>
	Сургалт 4	2019 оны 1-р сарын 28	19	<ul style="list-style-type: none"> <li>Тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг төлөвлөх (үргэлжлэл)</li> <li>Арга хэмжээг хэрэгжүүлэх гол байгууллагуудыг тогтоох</li> <li>Арга хэмжээг хэрэгжүүлэх хугацааг тогтоох</li> </ul>
	Сургалт 5	2019 оны 4-р сарын 19	13	<ul style="list-style-type: none"> <li>Хэрэгжүүлэх арга хэмжээг эрэмбэлэх</li> <li>Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг тооцоолох</li> </ul>
Өмнөговь аймаг	Сургалт 3	2018 оны 11-р сарын 28, 29	25	<ul style="list-style-type: none"> <li>Гамшгийн эрсдэлийг бууруулах 10 жилийн зорилт дэвшүүлэх</li> <li>Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилтод тулгарч буй асуудлыг тодорхой болгох</li> <li>Тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг төлөвлөх</li> </ul>
	Сургалт 4	2019 оны 2-р сарын 18	23	<ul style="list-style-type: none"> <li>Тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг төлөвлөх (үргэлжлэл)</li> <li>Арга хэмжээг хэрэгжүүлэх гол байгууллагуудыг тогтоох</li> <li>Арга хэмжээг хэрэгжүүлэх хугацааг тогтоох</li> </ul>
Баянгол дүүрэг	Хамтарсан сургалт 2	2019 оны 1-р сарын 31	8	<ul style="list-style-type: none"> <li>Гамшгийн эрсдэлийг бууруулах 10 жилийн зорилт дэвшүүлэх</li> <li>Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилтод тулгарч буй асуудлыг тодорхой болгох</li> <li>Тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг төлөвлөх</li> </ul>
Чингэлтэй дүүрэг			8	
Баянгол дүүрэг	Хамтарсан сургалт 2	2019 оны 5-р сарын 9	1	<ul style="list-style-type: none"> <li>Тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг төлөвлөх (үргэлжлэл)</li> <li>Арга хэмжээг хэрэгжүүлэх гол байгууллагуудыг тогтоох</li> <li>Арга хэмжээг хэрэгжүүлэх хугацааг тогтоох</li> </ul>
Чингэлтэй дүүрэг			7	

### **Үйл ажиллагаа 1.3.3 Гамшгаас хамгаалах мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх одоогийн системийг шинэчлэн сайжруулах**

Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын 14 дүгээр зүйл "Гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх"-д ОБЕГ нь гамшгийн мэдээллийн санг сайжруулах ажлыг хэрэгжүүлнэ гэж заасан. ОБЕГ-ын дээр дурьдсан хуулийн дагуу гүйцэтгэх чиг үүрэг болон "Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ"-ний тэргүүлэх чиглэлүүдийг Монгол улсад хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах зэрэг үйл ажиллагааны хүрээнд А/Х 1 дээр өнөөгийн системийг шинэчлэн сайжруулах бодлогын талаар санал солилцсоны үр дүнд одоогийн байдлаар дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэв. Үүнд:

#### **1) Гамшгийн орон зайн мэдээллийн системийн үйл ажиллагааг зохицуулах журам боловсруулах**

Журмын төслийг Ажлын дэд хэсгийн гишүүд болон шинээр байгуулагдсан тасгийн мэргэжилтнүүд боловсруулж, журмын төсөлд ОБЕГ-ын удирдлага, газрын дарга нарын саналын дагуу өөрчлөлт оруулж шинэчилсний дараа 2019 оны 2-р сарын 20-ны өдөр ОБЕГ-ын даргын А/47 тоот тушаалаар Гамшгийн орон зайн мэдээллийн систем (ГОЗМС)-ын үйл ажиллагааг зохицуулах журам батлуулсан болно.

#### **2) Шинээр суурилуулсан ГОЗМС-ийг сайжруулах, ОБЕГ-ын гамшгийн тохиолдлын бүртгэлийн мэдээллийг удирдах системийг шинэчлэх**

Сендайн үйл ажиллагааны дэлхийн хэмжээний зорилтуудын биелэлтийг хянаж, тайлагнах шалгуур үзүүлэлтэй холбогдуулан, дэд-А/Х-ийн гишүүд ГОЗМС-ийг ашиглаж орон нутгийн онцгой байдлын газар хэлтсүүдээс ирүүлсэн гамшгийн тохиолдлуудын мэдээллийг цууглуулах ажлыг сайжруулах талаар ярилцсан байна. Улмаар, А/Х 1-ийн гишүүд ОБЕГ-ын Гамшгийн шуурхай удирдлага, Зарлан мэдээллийн төвийн одоогийн удирдаж буй өдөр тутмын гамшгийн мэдээ мэдээллийн системийг сайжруулах ажлыг эхлүүлжээ. Мөн, Өдөр тутмын гамшгийн мэдээ мэдээллийн систем хоорондын уялдааг хангах зорилгоор Төслийн хүрээнд суурилуулсан ГОЗМС-ийг сайжруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. 2019 оны 5-р сарын эцсийн байдлаар дээрх 2 төрлийн ажил явагдаж байна.

#### **3) Холбогдох байгууллагуудтай орон зайн мэдээллийн санг хамтран ашиглах гэрээ байгуулах**

Дэд А/Х-ийн гишүүд Монгол Улсад хэрэгжүүлж байгаа гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хамтран ашиглах орчинг боловсронгуй болгох үүднээс ОБЕГ болон холбогдох байгууллагуудын хооронд орон зайн мэдээллийн санг хамтран ашиглах гэрээ байгуулах үйл ажиллагаанд анхаарал хандуулж

ажилласан.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (ГЗБГЗЗГ), ОБЕГ-ын хооронд техникийн болон удирдлага, зохион байгуулалтын асуудлуудаар санал солилцож хэлэлцсэний дараа 2018 оны 4-р сард (өмнөх хяналтын хугацаанд) орон зайн мэдээллийн санг хамтран ашиглах анхны гэрээг байгуулав.

Энэ удаагийн хяналтын хугацаанд ОБЕГ болон Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар (НХТЕТГ)-ын хооронд техникийн болон удирдлага, зохион байгуулалтын асуудлуудаар санал солилцож хэлэлцсэний дараа 2019 оны 3-р сарын 5-ны өдөр гэрээг байгуулав.

#### **4) ОБЕГ-т Гамшгийн орон зайн мэдээллийн системийг ашиглах талаар сургалт зохион байгуулах**

Гамшгийн орон зайн мэдээллийн системийг удирдаж ажиллуулах шинэ бүтэц зохион байгуулалтыг бий болгох үүднээс ОБЕГ, НОБГ болон 21 аймгийн онцгой байдлын газар, хэлтсийн хүний нөөцийн чадавхыг үнэлэх болон бэхжүүлэх нь чухал арга хэмжээний нэг болж байна. Улмаар, А/Х-ийн гишүүд болон шинээр байгуулагдсан тасгийн мэргэжилтнүүд онцгой байдлын албаны төв, орон нутгийн байгууллагын ГОЗМС-ийг ашиглах мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор 2018 оны 3-р сараас эхлэн сургалтуудыг зохион байгуулж байна.

Уг хяналтын хугацаанд А/Х-ийн гишүүд болон шинээр байгуулагдсан тасгийн мэргэжилтнүүд ГОЗМС-ийн удирдлага, үйл ажиллагааны талаарх 3 дахь сургалтыг зохион байгуулж ОБЕГ-ын Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв, НОБГ болон 21 аймгийн гамшгийн шуурхай удирдлага хариуцсан нийт 42 алба хаагчийг хамруулав. Сургалтын гол зорилго нь бүх төрлийн гамшиг ослын мэдээ мэдээллийг ГОЗМС-д бүртгэх аргачлалыг танилцуулж эзэмшүүлэх бөгөөд сургалтад оролцсон алба хаагч нар нь өөрийн компьютер дээр бодитоор дасгал сургууль хийв.

Мөн, ОБЕГ-ын даргын А/47 тоот тушаалаар батлагдсан ГОЗМС-ийн үйл ажиллагааг зохицуулах журмын талаар ОБЕГ-ын газар хэлтсийн алба хаагч нарт ойлголт өгөх зорилгоор сургалтуудыг төлөвлөсөн болно. А/Х-ийн гишүүд нь сургалтын хөтөлбөрийн төслийг боловсруулсан бөгөөд хөтөлбөрийг батлуулсны дараа сургалтыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.

**Үйл ажиллагаа 1.3.4 Үйл ажиллагаа 1.3.1 болон 1.3.2-т заасан улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт, үнэлгээ зэрэг үйл ажиллагааны талаар Монгол улсын иргэдэд мэдээлэх зорилго бүхий гамшгаас**

хамгаалах цагаан номыг боловсруулах

“Монгол Улсын Гамшгаас хамгаалах Цагаан ном 2017”-г 2018 оны 12-р сард хэвлүүлэв. Гамшгаас хамгаалах Цагаан номын агуулгыг Хүснэгт 2.3-т үзүүлэв.

## Хүснэгт 2.3 Цагаан номын агуулга

<p>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ШИНЭЧЛЭЛ</p> <p>1.1. Монгол Улсын гамшгаас хамгаалах тухай хууль, тогтоомж</p> <p>1.2. Гамшгаас хамгаалах бодлогын баримт бичиг</p> <p>1.3. Гамшгаас хамгаалах тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт</p> <p>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</p> <p>2.1. Монгол Улсад 2017 онд тохиолдсон аюулт үзэгдэл, гамшиг осол, хэрэгжүүлсэн арга хэмжээ</p> <p>2.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа</p> <p>2.3. Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа</p> <p>2.4. Гамшгийн бэлэн байдлыг хангах арга хэмжээ</p> <p>2.5. Гамшгийн үеийн зарлан мэдээлэл, шуурхай удирдлага зохицуулалт</p> <p>2.6. Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл</p> <p>2.7. Гамшгаас хамгаалах дадлага, сургууль</p> <p>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХ ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА</p> <p>3.1. Гамшгаас хамгаалах олон улсын хамтын ажиллагаа</p> <p>3.2. Гамшгаас хамгаалах албадын харилцан ажиллагаа</p> <p>3.3. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэний нийгэм, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо</p> <p>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ</p> <p>4.1. Галын аюулгүй байдлын талаарх баримт бичиг</p> <p>4.2. Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаа</p>	<p>ТАВДУГААР БҮЛЭГ. УЛСЫН НӨӨЦ, ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ</p> <p>5.1. Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн талаарх баримт бичиг</p> <p>5.2. Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаа</p> <p>ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</p> <p>6.1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл</p> <p>6.2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай баримт бичиг</p> <p>6.3. Улаанбаатар хотын ойр орчим дахь хагарлын судалгаа</p> <p>6.4. Улаанбаатар хотын газар хөдлөлтийн шуурхай арга хэмжээний төлөвлөгөө</p> <p>ДОЛООДУГААР БҮЛЭГ. ГАМШИГ СУДЛАЛ, ГАМШГААС ХАМГААЛАХ СУДАЛГААНЫ АЖИЛ</p> <p>7.1. Гамшиг судлалын хүрээлэнгийн судалгаа шинжилгээний ажлууд</p> <p>7.2. Гамшгийн мэдээллийн сан</p> <p>НАЙМДУГААР БҮЛЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</p> <p>8.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт</p> <p>8.2. Гадаадын хөрөнгө оруулалт</p> <p>8.3. Онцгой байдлын ерөнхий газарт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр</p> <p>8.4. Гамшигт нэрвэгдэгсдэд олгох нөхөн олговор</p> <p>ХАВСРАЛТ</p> <p>1. Гамшгаас хамгаалах эрх зүйн баримт бичгийн жагсаалт</p>
---	--

Мөн, А/Х 1-ийн гишүүд Цагаан ном боловсруулах гарын авлагыг боловсруулав. Энэхүү гарын авлагад 2017 онд Цагаан номыг боловсруулах явцын талаар дараах зүйлсийг тусгажээ. Үүнд:

- Цагаан ном боловсруулах ажлын хэсэг байгуулах
- Цагаан номын бүтэц болон агуулгыг хэлэлцэх
- Мэдээллийн эх үүсвэрийг тодорхойлох
- Материал цуглуулах
- Цуглуулсан материалыг цэгцлэх
- Цагаан номын төслийг бэлтгэх
- Цагаан номын төслийг хянан засах
- Англи хэл рүү орчуулах ажлын зохион байгуулалт
- Хэвлэлийн компаниар хянуулах ажлын зохион байгуулалт, гэх мэт.

Гарын авлагад туснасны дагуу, Гамшгаас хамгаалах Цагаан ном 2018-ын ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд бэлтгэл ажлуудыг эхлүүлсэн байна.

**Үйл ажиллагаа 1.3.5 Барилга, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн мэдээллийн сангийн системийг сайжруулах**

Үйл ажиллагаа 1.3.3-т тайлбарласны дагуу, ГОЗМС нь холбогдох байгууллагуудын гүйцэтгэх барилга, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний үр дүнг хуримтлуулж, удирдах боломжтой байхаар зохион байгуулж байна.

НХТЕТГ-тай байгуулсан мэдээлэл солилцох гэрээнд үндэслэн Нийслэлийн холбогдох байгууллагуудын хийсэн газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээний үр дүнгийн мэдээллийг солилцох орчинг бий болсон.

Мөн түүнчлэн, А/Х 1-ийн гишүүд ЖАЙКА-гийн өмнө хэрэгжүүлсэн "Монгол Улсын Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдлээс хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд гүйцэтгэсэн барилга, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээг ГОЗМС-д оруулах ажлын бэлтгэлийг хангаж байна. Орон зайн мэдээллийн сангийн агуулга зохих хэмжээгээр нэмэгдэж, гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахад ашиглах боломжтой болж байна.

**(3) Үр дүн 2****Үйл ажиллагаа 2.1.1 Гамшгаас хамгаалах тухай хуулийн хүрээнд, Барилга, Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнд газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ хийх журам, зааварт дүн шинжилгээ хийж шинэчилсэн заавар боловсруулах**

Энэхүү үйл ажиллагааг өмнөх хяналтын хугацааны эцэст гүйцэтгэсэж дуусгасан.

А/Х 2-ын гишүүд холбогдох байгууллагуудын албан тушаалтнуудтай хамтарч одоо мөрдөгдөж буй барилга, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтийн үнэлгээний норм, нормативыг судалсан бөгөөд энэхүү судалгаагаар тодруулсан асуудлуудыг Төслийн хүрээнд шинээр боловсруулсан БД-үүдэд тусгасан.

**Үйл ажиллагаа 2.1.2 Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлал, Үнэлгээнд хэрэглэгдэх хэмжилтийн багаж төхөөрөмжийг ашиглах заавар боловсруулах**

Энэхүү үйл ажиллагааг өмнөх хяналтын хугацааны эцэст гүйцэтгэсэж дуусгасан.

2018 оны 11-р сарын 06-ны өдрийн БХБС-ын 185-р тушаалаар Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлал, 2018 оны 12-р сарын 28-ны өдрийн БХБС болон ЗТХС-ын 174/303-р тушаалаар Дэд бүтэц ИШС-ний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлалыг тус тус батлуулсан. Зураг 2.1-т БХБС болон ЗТХС-ын 174/303-р тушаалыг үзүүлэв.



Зураг 2.1. БХБС болон ЗТХС-ын 174/303-р тушаал

**Үйл ажиллагаа 2.1.3: Барилга, байгууламж болон шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээг хийх мэргэжилтнүүдийн мэдлэг, үр чадварыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах**




БД-үүд батлагдсаны дараа холбогдох төрийн байгууллагын мэргэжилтнүүд болон хувийн хэвшлийн инженерүүдэд АХ2-ын зүгээс БД дэр аргачлалуудын агуулгыг танилцуулах сургалтуудыг зохион байгуулсан. Хүснэгт 2.1-т нэгтгэж харуулав.


Хүснэгт 2.1 Үнэлгээний аргачлалын тухай сургалтууд

Огноо	Сургалтын нэр	Оролцогчид	Газар	Тэмдэглэл
2019.1.30	Барилгын тэсвэрлэлтийн үнэлгээ г.х	Хувийн хэвшлийн ААН-үүдийн 30 инженер	МБИХ	МБИХ-ны хөтөлбөрийн дагуу
2019.3.21	Барилгын тэсвэрлэлтийн үнэлгээ г.х	Хувийн хэвшлийн ААН-үүдийн 28 инженер	МБИХ	МБИХ-ны хөтөлбөрийн дагуу
2019.3.28	Барилгын үнэлгээ ба хүчитгэл	Аймгуудын Барилгын г.х тэсвэрлэлтийн үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүд 31 хүн /БХБЯ болон БХТ/	БХТ	Сургагч багш нар заасан
2019.4.19	Барилгын тэсвэрлэлтийн үнэлгээ г.х	Хувийн хэвшлийн ААН-үүдийн 10 инженер	МБИХ	МБИХ-ны хөтөлбөрийн дагуу
2019.5.6 – аас үргэлжэн явагдан байна	ОБЕГ-ын сургагч багш нарт зориулсан сургалт (Барилгын үнэлгээ)	ОБЕГ-ын Эрсдэлийн удирдлагын газрын 3 мэргэжилтэн	ОБЕГ	Цуврал сургалт
2019.5.10	МХЕГ-ын сургагч багш нарт зориулсан сургалт (Барилгын үнэлгээ)	Барилга хариуцсан байцаагч нар /4 хүн/	БХБЯ	
2019.5.13	БХБЯ, БХТ, ГЗБГЗЗГ-ын сургагч багш нарт зориулсан сургалт (Барилгын үнэлгээ)	Холбогдох мэргэжилтнүүд /4 хүн/	БХБЯ	
2019.5.14	НХБХГ-ын сургагч багш нарт зориулсан сургалт (Барилгын үнэлгээ)	НХБХГ-н 5 мэргэжилтэн	НХБХГ	
2019.5.15	МХЕГ-ын сургагч багш нарт зориулсан сургалт (Дэд бүтэц, ИШС-ний үнэлгээ)	Дэд бүтэц, ИШС хариусан байцаагч нар /6 хүн/	МХЕГ	

Дээрх байгууллагуудын үйл ажиллагаа нь өөр тул байгууллага тус бүр дээр тус тусад нь сургагч багшид зориулсан сургалтыг зохион байгуулахаар АХ-2 зүгээс шийдвэрлэсэн. Сургагч багш нарт илүү дэлгэрэнгүй тайлбарлаж, үр дүнтэй технологи дамжуулалтыг хийхийн тулд цөөн тооны хүмүүст давтамжтайгаар тайлбарлах шаардлагатай.



ОБЕГ



БХБЯ, БХТ



МХЕГ



НХБХГ

Зураг 2.2 Сургагч багш нарт зориулсан сургалтууд

### Үйл ажиллагаа 2.2.1 Барилга байгууламжийг хүчитгэх, шинэчлэн барих тухай заавар аргачлал боловсруулах

Энэхүү үйл ажиллагааг өмнөх хяналтын хугацааны эцэст гүйцэтгэсэж дуусгасан.

2018 оны 11-р сарын 06-ны өдрийн БХБС-ын 185-р тушаалаар БД-үүд болон батлагдсан.


### Үйл ажиллагаа 2.2.2: Орон сууц, цэцэрлэг, сургууль, эмнэлэг, төрийн захиргааны барилга, хүчитгэх, загвар зураг төсөл боловсруулах

А/Х 2 нь хүчитгэлийн зураг төсөл боловсруулах барилгуудыг сонгох талаар хэлэлцэж, Хүснэгт 2.2-ын дагуу өөр өөр бүтээц, зориулалттай таван барилгыг сонгосон. Эдгээр барилгуудын байршил болон зургыг Зураг 2.3-т үзүүлэв.


Хүснэгт 2.2. Хүчитгэлийн зураг төсөл боловсруулахаар сонгогдсон барилга

Бүтээц	Зориулалт	Нэр	Байршил	Тайлбар
Тоосгон өрөгт бүтээц	Цэцэрлэг	105-р цэцэрлэг	Сонгино хайрхан дүүрэг	Нэг маягийн зургаар Улаанбаатар хотод хамгийн олон баригдсан цэцэрлэгийн барилга
	Сургууль	23-р сургууль	Чингэлтэй дүүрэг	Нэг маягийн зургаар баригдсан тоосгон бүтээцтэй том хэмжээний сургуулийн барилга
	Төрийн байгууллага	ОБЕГ-ын төв байр	Сүхбаатар дүүрэг	Гамшгийн үед шуурхай арга хэмжээ авах үүрэг бүхий төрийн байгууллагын барилга
Цутгамал төмөр бетон бүтээц	Эмнэлэг	1-р эмнэлгийн өргөтгөл	Сүхбаатар дүүрэг	Цутгамал төмөр бетон бүтээцтэй барилга бүхий цөөн тооны Улсын эмнэлгийн нэг


Угсармал хавтгаалжин бүтээц	Орон сууц	9 давхар барилга	Баянгол дүүрэг	Нэг маягийн зургаар Улаанбаатар хотод хамгийн олон баригдсан угсармал хавтгаалжин орон сууцны барилга
-----------------------------	-----------	------------------	----------------	---




Зураг 2.3 Хүчитгэлийн зураг төсөл боловсруулахаар сонгогдсон барилгуудын байршил болон зураг



Зураг 2.4. Цутгамал төмөр бетон хана нэмэх хүчитгэлийн жишээ зураг /ЦТБ бүтээцтэй барилга/



Зураг 2.5. Гадна талаас ган холбоос суурилуулах хүчитгэх /Угсармал том хавтгаалжин бүтээцтэй барилга/



Зураг 2.5. Цутгамал төмөр бетоноор өрөгт ханыг зузаалах хүчитгэл /Тоосгон өрөгт бүтээцтэй барилга/

БД-д тусгагдсан хүчитгэлийн бусад аргуудын дагуу хүчитгэлийн жишээ зургууд боловсруулагдсан болно.

**Үйл ажиллагаа 2.2.3: Барилгын хүчитгэл хийх ажилтнуудын мэдлэг чадвахийг дээшлүүлэх сургалт явуулах**


АХ-2-ын гишүүд нь Барилгын хүчитгэлийн тухай сургалтыг хүснэгт 2.3-т заасан хуваарийн дагуу зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

Хүснэгт 2.3. Барилгын хүчитгэл сэдэвт сургалтын ерөнхий хөтөлбөр

	05.01 /Лхагва/ Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв	5.2 /Пүрэв/ БХТ	5.3 /Баасан/ БХТ
Үдээс өмнө	<ul style="list-style-type: none"> <li>Нээлт</li> <li>Удиртгал лекц-1</li> <li>ОБЕГ-ын бодлого, үйл ажиллагаа</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Цутгамал төмөр бетон барилгын нарийвчилсан үнэлгээ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Цутгамал төмөр бетон барилгын хүчитгэлийн тухай лекц болон дадлага</li> </ul>
Үдээс хойш	<ul style="list-style-type: none"> <li>Японы туршлагын тухай лекц</li> <li>Удиртгал лекц-2</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Угсармал том хавтгаалжин барилгын нарийвчилсан үнэлгээний тухай лекц болон дадлага</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Угсармал хавтгаалжин болон тоосгон барилгын хүчитгэлийн тухай лекц болон дадлага</li> <li>Хаалт</li> <li>Сертификат гардуулах</li> </ul>



Дурсгалын зураг



Удиртгал лекц /Проф. Ганзориг/



ОБЕГ-ын бодлого, үйл ажиллагаа



Хүчитгэх аргачлалын тухай лекц

Зураг 2.7. Барилгын хүчитгэлийн тухай сургалт

Сургалтад төрийн байгууллагын мэргэжилтнүүдээс гадна хувийн хэвшлийн ААН-үүдээс 65 хүн оролцсон бөгөөд сургалтын дараах санал асуулгаар тус сургалт нь үр дүнтэй, хэрэгтэй мэдээллээ авч чадсан гэж дүгнэгдсэн. Мөн цаашид сайжруулах шаардлагатай хэсэг байгааг ч тэмдэглэсэн байв.

#### (4) Үр дүн 3

**Үйл ажиллагаа 3.1.1 Гамшгаас хамгаалах тухай хуультай үялдсан цэцэрлэг, сургуулийн гамшгаас хамгаалах боловсролын агуулга, арга зүй, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон удирдамж боловсруулах**

Энэхүү үйл ажиллагаа “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөр боловсруулагдан, 2018 оны 4 сарын 6-ны өдөр (өмнөх тайлангийн хугацаанд) батлагдсанаар бүрэн дуусгавар болсон.

**Үйл ажиллагаа 3.1.2 Цэцэрлэг, сургуулийн гамшгийн эрсдэлийг бууруулах сургалтад ашиглах сурах бичгийн нэмэлт материал, сургалтын материал зэргийг боловсруулах**

“Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн дагуу багш нар хичээл заахдаа ашиглах “Багшийн гарын авлага”-ыг боловсруулах, агуулгыг сайжруулах ажлын хэсгийн гишүүд үргэлжлүүлэн гүйцэтгэсэн. 2019 оны 3-р сараас 5-р сарын эх хүртэлх хугацаанд гишүүд тус бүрээс ирүүлсэн эцсийн хувилбарыг ижил форматанд оруулан нэгтгэж, СӨБ болон бага, суурь, бүрэн дунд боловсролын багшийн гарын авлага болгон нэгтгэн боловсруулав.

Багшийн гарын авлагын эцсийн төслийн гарчгийг дараах хүснэгтээр үзүүлэв.

<b>“Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн гарын авлага (Бага, суурь, бүрэн дунд боловсрол)-ын гарчиг</b>	
<b>Өмнөх үг</b> “Аюулгүй амьдрах ухаан” хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> <li>✧ Уур амьсгалын өөрчлөлт, түүнийг сааруулахад бидний оруулах хувь нэмэр</li> <li>✧ Байгалийн аюулт үзэгдэл: Газар хөдлөлтийн аюулаас өөрийгөө болон бусдыг хамгаалъя/ Аянга цахилгаанаас урьдчилан сэргийлье</li> </ul>
<b>Удиртгал</b> <ul style="list-style-type: none"> <li>✧ “Аюулгүй амьдрах ухаан” хөтөлбөр гаргах үндэслэл</li> <li>✧ “ААУ” сургалтын хөтөлбөрийн агуулга</li> <li>✧ Гарын авлагын бүтэц ба ашиглахад анхаарах зүйл</li> </ul>	<b>4-р бүлэг: Хичээлийн арга зүйн санаа (Бүрэн дунд боловсрол)</b> <ul style="list-style-type: none"> <li>✧ Байгалийн аюулт үзэгдэл: Өрхийн эрсдэлийн бэлэн байдлын төлөвлөгөө хийцгээе</li> <li>✧ Нийгмийн орчны аюулгүй байдал: Цахим гэмт хэргээс сэргийлье</li> </ul>
<b>1-р бүлэг: Гамшгийн тухай ерөнхий ойлголт</b> <ul style="list-style-type: none"> <li>✧ Гамшгийн нөхцөл байдал</li> <li>✧ Гамшиг, аюул, эмзэг байдал</li> <li>✧ Газар хөдлөлтийн тухай ойлголт</li> </ul>	<b>5-р бүлэг Сургалтыг дэмжих үйл ажиллагааны агуулга, арга зүй</b> <ul style="list-style-type: none"> <li>✧ Сургуулийн үйл ажиллагааны төлөвлөлтийн жишээ</li> <li>✧ Хичээлээс гадуурх үйл ажиллагааны зорилго</li> <li>✧ Бага боловсрол: Хичээлээс гадуурх үйл ажиллагааны цагаар хэрэгжүүлэх агуулга ба арга</li> </ul>
<b>2-р бүлэг: Хичээлийн арга зүйн санаа (Бага боловсрол)</b> <ul style="list-style-type: none"> <li>✧ Нийгмийн орчны аюулгүй байдал: Зүг чигээ зөв олж суръя</li> <li>✧ Нийгмийн орчны аюулгүй байдал: Уур амьсгалын өөрчлөлт</li> </ul>	

<ul style="list-style-type: none"> <li>✧ Байгалийн аюулт үзэгдэл: Газар хөдлөлтөд тэсвэртэй байшингийн загвар бүтээцгээ</li> <li>✧ Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах</li> <li>✧ Гал түймрийн гамшгаас хамгаалах</li> <li>✧ <b>3-р бүлэг: Хичээлийн арга зүйн санаа (Суурь боловсрол)</b></li> <li>✧ Ахуйн орчны аюулгүй байдал: Усны бохирдлоос өөрийн эрүүл мэндийг хамгаалах аргад суралцъя</li> <li>✧ Цаг уурын аюулт үзэгдэл: “Цаг уурч болъё</li> <li>✧</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>зүйн санаа</li> <li>✧ Суурь боловсрол: Хичээлээс гадуурх үйл ажиллагааны цагаар хэрэгжүүлэх агуулга ба арга зүйн санаа</li> <li>✧ Бүрэн дунд боловсрол: Хичээлээс гадуурх үйл ажиллагааны цагаар хэрэгжүүлэх агуулга ба арга зүйн санаа</li> <li>✧ <b>Нэр томъёоны тайлбар</b></li> <li><b>Ном зүй</b></li> </ul>
---	--

**“Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн гарын авлага  
(Сургуулийн өмнөх боловсрол)-ын гарчиг**

<p><b>Өмнөх үг</b></p> <p>“Аюулгүй амьдрах ухаан” хөтөлбөр</p> <p><b>Удиртгал</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✧ “Аюулгүй амьдрах ухаан” хөтөлбөр гаргах үндэслэл</li> <li>✧ “ААУ” сургалтын хөтөлбөрийн агуулга</li> <li>✧ Гарын авлагын бүтэц ба ашиглахад анхаарах зүйл</li> </ul> <p><b>1-р бүлэг: Гамшгийн тухай ерөнхий ойлголт</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✧ Гамшгийн нөхцөл байдал</li> <li>✧ Гамшиг, аюул, эмзэг байдал</li> <li>✧ Газар хөдлөлтийн тухай ойлголт</li> </ul> <p><b>2-р бүлэг: Цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрт гамшгаас хамгаалах үйл ажиллагааг тусгах нь</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✧ СӨБ-ын сургалтын цөм хөтөлбөр, аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийн уялдаа</li> <li>✧ “ААУ” сургалтын хөтөлбөрийг өдөр тутмын сургалт, үйл ажилагаагаар хэрэгжүүлэх арга зүйн санаа буюу хөгжүүлэх үйл ажиллагааны жишээ</li> </ul> <p><b>Нэр томъёоны тайлбар</b></p> <p><b>Ном зүй</b></p>
---

Багшийн гарын авлагын эцсийн төслийг 2019 оны 5-р сард БСШУСЯ-д өргөн барих бөгөөд БСШУСЯ-ны албан ёсны экспертээр хянуулж, экспертийн санал зөвлөмжийн дагуу засварлаж, эцэслэгдэнэ.

Багшийн гарын авлагыг хянаж, засварласны дараа 2019 оны 6-9-р сард хэвлэлтэд өгч, төрийн өмчит сургууль, цэцэрлэгүүдэд тараана.

**Үйл ажиллагаа 3.1.3 3.1.1 болон 3.1.2-д боловсруулсан удирдамж болон сургалтын материалыг ашиглан Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын арга зүйчид (тайлбар 3-1), аймаг нийслэлийн боловсролын газрын мэргэжилтнүүдэд сургалт явуулах.**

Энэхүү үйл ажиллагаа нь 2018 оны 9-р сарын 11-13-ны Үндэсний сургагч багшийн сургалт, 2018 оны 9-р сарын 18-21 болон 10-р сарын 8-11-ны өдрийн Орон нутгийн сургагч багшийн сургалт хэрэгжсэнээр 2018 оны 11-р сард (өмнөх тайлангийн хугацаанд) бүрэн дуусгавар болсон.

**Үйл ажиллагаа 3.1.4 3.1.3-ын сургалтад хамрагдсан арга зүйч, мэргэжилтнүүд багш нараар удирдуулан сургуулийн багш нарт сургалт явуулах**









2018 оны 12-р сарын 27-28-ны өдрүүдэд “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн дагуу НОБГ, АХЗ-1-ийн гишүүд болон Мэргэжилтний багийн дэмжлэгтэйгээр Баянзүрх дүүргийн цэцэрлэгүүдийн багш нарт заах аргын талаар сургалт явуулсан.

2019 оны 1-р сарын 16-нд Үйл ажиллагаа 3.1.3-ын сургалтад хамрагдсан арга зүйч багш нарын зүгээс БСШУСЯ-наас уламжлал болгон зохион явуулдаг 10 жил ажилласан багш нарт чиглэсэн сургалтаар “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн талаар хичээл заасан ба Мэргэжилтний баг дэмжлэг үзүүлж ажилласан.

Түүнчлэн “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн хүрээнд гамшгаас хамгаалах агуулгыг хичээлээр заахад сайн жишээ нэвтрүүлэх зорилго бүхий загвар сургуулийн үйл ажиллагааг УБ хотын 244-р цэцэрлэг, 13 болон 42-р сургуулиудад тус тус хэрэгжүүлсэн.

<b>Зорилго</b>	<ul style="list-style-type: none"> <li>◇ СӨБ болон бага, дунд боловсролд “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн хүрээнд гамшгаас хамгаалах агуулгыг хичээлээр заахад сайн жишээ нэвтрүүлэх</li> <li>◇ Сайн жишээний эцсийн хувилбараар видео хичээл боловсруулж, Багшийн гарын авлагын хавсралт материал болгон ашиглах</li> </ul>			
<b>Оролцогчид</b>	Сонгогдсон загвар сургууль, цэцэрлэгийн багш сурагчид, дүүргийн Боловсролын хэлтэс, Онцгой байдлын хэлтсийн мэргэжилтнүүд, АХЗ-1 гишүүд			
<b>Хугацаа</b>	2019 оны 3-р сарын 5-19-ний өдөр			
<b>Байршил</b>	Тус тусын сонгогдсон сургууль, цэцэрлэг			
<b>Гол үйл ажиллагаа, огноо (оролцогчдын тоо)</b>		<b>244-р цэцэрлэг</b>	<b>13-р сургууль (бага анги)</b>	<b>42-р сургууль (дунд анги)</b>
	1) Багш, ажилчдад зориулсан семинар	3/5 10:00~13:00 (43 хүн)	3/7 10:10~13:10 (53 хүн)	3/6 9:30~12:30 (38 хүн)
	2) Загвар хичээлийн талаарх воркшоп сургалт 1	3/11 10:00~13:00 (14 хүн)	3/12 10:15~13:10 (4 хүн)	3/11 14:00~17:00 (5 хүн)
	3) Загвар хичээлийн талаарх воркшоп сургалт 2	3/13 14:00~17:00 (16 хүн)	3/14 16:00~18:00 (4 хүн)	3/13 10:00~13:00 (5 хүн)
	4) “Аюулгүй амьдрах ухаан” судлагдахуун хичээл	3/15 9:30~10:30 (Хичээлийн дараах үнэлгээний уулзалт) (13 хүн)	3/19 10:15~11:40 (Хичээлийн дараах үнэлгээний уулзалт) (4 хүн)	3/18 12:20~14:00 (Хичээлийн дараах үнэлгээний уулзалт) (8 хүн)



	244-р цэцэрлэг	13-р сургууль (бага анги)	42-р сургууль (дунд анги)
Семинар			
Воркшоп			
Хичээл			

2019 оны 9-р сард БСШУСЯ-наас уламжлал болгон зохион явуулдаг Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын сургалтын хөтөлбөрт “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн Багшийн гарын авлагын агуулгыг багтаан сургалт явуулахаар төлөвлөж байна.

**Үйл ажиллагаа 3.2.1 Төв, орон нутгийн гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны нэгдсэн график төлөвлөгөө боловсруулах**


<Сургалтын төлөвлөгөөний мэдээлэл нийтлэх веб хуудас>

Энэхүү веб хуудсыг 2019 оны 1-р сард гарын авлагын хамт боловсруулж дууссан\*. 1-р сарын 31-ний өдөр уг системийг хэрхэн ашиглах талаарх уулзалтыг ОБЕГ-ын хурлын танхимд явуулсан. ОБЕГ, НОБГ, НҮБХХ, Японы Хүүхдийг ивээх сан, Дэлхийн зөн Монгол, МУЗН болон бусад хандивлагч байгууллагын төлөөлөл 21 оролцогч уулзалтад оролцсон. Түүнчлэн ОБЕГ-ын харьяа байгууллагуудад чиглэсэн онлайн сургалтад 57 ажилтан албан хаагч оролцсон.


(\*<http://ontsgoisur.gov.mn/pages/taylan-4w-programm-khangamzhiyn-taniltsuulga-garyn-avlaga-c> үзнэ үү.)

Веб хуудас (<http://4w.ontsgoisur.gov.mn/>) нь 2019 оны 2-р сарын 1-ний өдрөөс туршилтын журмаар ажиллаж эхэлсэн ба хэрэглэгчдийн санал, хүсэлт гарсан


тохиолдолд 2019 оны 4-р сар хүртэл боловсронгуй болгохоор төлөвлөсөн боловч томоохон засвар хийх санал гараагүй.



Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны мэдээллийн веб хуудасны эхний нүүр



Веб хуудасны системийн талаарх уулзалт



Харьяа байгууллагуудад чиглэсэн онлайн сургалт


**Үйл ажиллагаа 3.2.2 Гамшгаас хамгаалах боловсрол олгох сургалт, сурталчилгааны материал боловсруулж, зорилтот бүлгийн сургалтыг сонгогдсон бүс нутагт зохион байгуулах**

Энэхүү үйл ажиллагаа нь өмнөх тайлангийн хугацаанд бүрэн дуусгавар болсон (<http://ontsgoisur.gov.mn/pages/khen-ch-khezee-ch-khaana-ch-belen>).

**Үйл ажиллагаа 3.2.3 Сургалтын төвд гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн нөхцөл байдлыг биеэр мэдрүүлэх сургалт, сурталчилгааны хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах**

<Газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхимын самбар>

Самбар боловсруулах ажил 2019 оны 3-р сард эцэслэн дууссан ба НИГХСАЗТ-ийн Газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхимд бүх самбарууд болон барилгын газар хөдлөлтийн тэсвэржилт, хүчитгэлийн талаар суралцах макетын хамт дараах зурагт үзүүлсэн байдлаар байрлуулсан.



Түүнчлэн газар хөдлөлтийн магнитудын хүчийн талаар ойлголт өгөх самбарыг газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхимд нэмэлтээр байрлуулсан.



Газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхимд байрлуулсан самбар, макетууд

<Хүүхдийн өрөөний сургалтын материал>

Ажлын хэсгийн гишүүдтэй ярилцаж, Дэлхийн зөн Монгол ОУБ-тай зохицуулалт хийсний үндсэн дээр Хүүхдийн өрөөнд ашиглах гамшгаас хамгаалах сургалтын материал болох ширээний театр (камишибай)-г боловсруулсан. 2019 оны 4-р сарын 24-ний өдөр явуулсан цэцэрлэгийн хүүхдэд зориулсан гамшгаас хамгаалах загвар хичээлд уг ширээний театрыг сургалтын материал болгон ашигласан. Модон тайз бүхий ширээний театрыг НИГХСАЗТ-д байрлуулах ба хэвлэмэл ширээний театрыг

ОБЕГ, НОБГ, БСШУСЯ, БХ, БМДИ болон АХЗ.1-ийн загвар хичээлийн үйл ажиллагаанд оролцсон цэцэрлэгүүдэд хүлээлгэн өгсөн.



Хүүхдэд зориулсан гамшгаас хамгаалах сургалтын материал –  
Ширээний театр



Ширээний театр ашиглаж  
явуулсан хичээл

## 1-3 Хүрсэн үр дүн

### (1) Үр дүн 1

Төслийн төлөвлөлтийн матрицын (ТТМ) дагуу Үр дүн 1-ийн гүйцэтгэлийг дараах гурван шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

#### 1.1 Боловсруулсан заавар, дүрмийн тоо.

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

А/Х 1 нь хоёр (2) төрлийн Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний заавар, дөрвөн (4) төрлийн Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар болон нэг (1) Гамшгийн мэдээллийн санг ашиглах зааврыг тус тус боловсруулах төлөвлөгөөтэй байна.

Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний зааврын тухайд, А/Х 1-ийн гишүүд Газар хөдлөлтийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний заавар ба Газар хөдлөлтийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний зааврыг нэгтгэв. Түүнчлэн, А/Х 1-ийн гишүүд Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний аргазүйн зааварчилгааг боловсруулав. Хяналтын өмнөх хугацаанд газар хөдлөлтийн эрсдэлийн хялбарчилсан үнэлгээний програм хангамжийг боловсруулав. Эрсдэлийн үнэлгээний аргачлалыг газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний талаарх мэргэжлийн мэдлэггүй төв, орон нутгийн засаг захиргааны байгууллагын мэргэжилтнүүд ч үнэлгээ хийх боломжтой байдлаар боловсруулсан.

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавруудын тухайд, Аймаг/сумын болон Нийслэл/дүүргийн төвшний газар хөдлөлтийн гамшгаас

хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавруудыг боловсруулав. Улсын болон Улсын албадын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавруудыг боловсруулж байна.

Гамшгаас хамгаалах мэдээллийн санг ашиглах зааврын тухайд, ОБЕГ-ын даргын А/47 тоот тушаалаар Гамшгийн орон зайн мэдээллийн системийн үйл ажиллагааг зохицуулах журам 2019 оны 2-р сарын 20-ны өдөр батлагдсан.

### 1.2 Боловсруулсан санамж бичгийн төслийн тоо болон санамж бичгийн талаар санал солилцсон, холбогдох сургалтанд оролцсон байгууллагууд

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

Доор дурдсан дөрвөн (4) салбарын санамж бичгийг тус хяналтын хугацаанд байгуулав.

- Түр хорогдох байр, түр сууцанд шилжин ирсэн гамшигт нэрвэгдэгсдэд шаардагдах ундны цэвэр ус, хоол, хүнсээр хангах: Санамж бичгийг ОБЕГ, ХХААХҮЯ-ны хооронд 2018 оны 10-р сарын 16-ны өдөр байгуулав.
- Гамшгийн үед эм, эмийн хэрэгслээр хангах: Санамж бичгийг ОБЕГ болон эм ханган нийлүүлдэг 3 том компанийн хооронд 2018 оны 11-р сарын 7-ны өдөр байгуулав.
- Орон зайн мэдээлийн санг хамтран ашиглах: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (ГЗБГЗЗГ) болон ОБЕГ-ын хооронд 2018 оны 4-р сард хамтран ажиллах, орон зайн мэдээллийн санг хамтран ашиглах анхны албан ёсны гэрээг байгуулав.
- Орон зайн мэдээлийн санг хамтран ашиглах: ОБЕГ болон Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар (НХТЕТГ)-ын хооронд техникийн болон удирдлага, зохион байгуулалтын асуудлуудаар санал солилцож хэлэлцсэний дараа 2019 оны 3-р сарын 5-ны өдөр гэрээг байгуулав.

Дор дурдсан салбаруудын санамж бичгийн төслүүд одоогоор хэлэлцэх шатанд явж байна.

- Барилгын материал болон түр сууцаар хангах
- Гамшгийн үеийн тээвэрлэлт, замын хөдөлгөөнийг хангах
- Гамшгийн үед түлш, шатахуунаар хангах

- Гамшгийн үед нэн тэргүүнд холбогдох телефон үйлчилгээ
- Түр хорогдох байрны цэвэр усны хангамж
- Олон нийтийн барилга байгууламж, ялангуяа сургуулийн барилгыг түр хоргодох байр болгож ашиглах
- Нүүлгэн шилжүүлэх газар болон түр хоргодох байр дахь бохир усны зохицуулалт

Газар хөдлөлтийн гамшгийн үед авах хариу арга хэмжээний үр дүнтэй эсэхийг туршиж, эрүүл мэндийн болон бусад салбаруудын санамж бичгийг дэмжих үүднээс санамж бичгийн ач холбогдлыг танилцуулах зорилготойгоор 2018 оны 4-р сарын 9-ний өдөр УБ хотод хамтарсан сургалт зохион байгуулжээ. Олон салбаруудаас нийт 38 оролцогчид уг сургалтанд оролцсон байна.

### 1.3 Гамшгаас хамгаалах Цагаан ном

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

“Монгол Улсын гамшгаас хамгаалах Цагаан ном 2017”-ыг монгол, англи хэл дээр хэвлүүлэв. Цагаан ном боловсруулах гарын авлагыг болвсруулав.

### **(2) Үр дүн 2**

Төслийн төлөвлөлтийн матрицын (ТТМ) дагуу Үр дүн 2-ын гүйцэтгэлийг дараах хоёр шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

### 2.1 Барилгын Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргалчал: газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний сургалтанд оролцсон хүний тоо

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

БХБЯ-ны ШУТЗ-өөр аргачлалыг батлуулсны дараа А/Х 2 барилгын газар хөдлөлт тэсвэржилтийн үнэлгээний сургалтыг 2018 оны 6-р сарын 4-нөөс 6-ны өдөр хүртэл зохион байгуулж, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний үнэлгээний сургалтыг 2018 оны 6-р сарын 7-нд зохион байгуулжээ. Барилгын үнэлгээний сургалтанд 110 оролцогчид оролцсоны дотор МХЕГ-ын байцаагч нар байсан бөгөөд оролцогчдын тоо тамагласнаас олон байсан. Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний үнэлгээний сургалтанд 70 оролцогчид оролцсон нь мөн тамагласнаас илүү тоо байв.

Дээр дурдсан сургалтаас гадна 2018 оны 9-р сарын 8-ны өдөр МБИХ-ны хүсэлтийн дагуу Эрдэнэт хотод газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний сургалт явуулсан бөгөөд энэхүү сургалтанд Эрдэнэтийн 23 инженер оролцов. МБИХ-ын сургалтанд

амжилттай оролцсоноор мэргэшсэн инженер болоход шаардлагатай "кредит" авах боломжтой учир эдгээр сургалтуудад оролцогчид маш идэвхитэй оролцдог. Иймээс, МБИХ-ны сургалтаар дамжуулан газар хөдлөлт тэсвэрлэлт болон хүчитгэлийн технологийг дэлгэрүүлэх нь илүү үр дүнтэй аргын нэг байж болох юм.

Барилга байгууламжид үл эвдэх аргаар биет үзлэг хийх багажыг танилцуулах 2 өдрийн сургалтыг 2018 оны 11-р сарын 12, 13-ны өдрүүдэд зохион байгуулав. Энэхүү сургалтанд 64 оролцогчид оролцсон.

Барилгын дүрэмүүд хэвлэгдсэний дараа технологи дамжуулах зорилгоор сургагч багш нарт зориулсан сургалтыг зохион байгуулсан бөгөөд 53 хүн оролцсон. Мөн МБИХ-оос зохион байгуулсан сургалтуудад хувийн хэвшлийн 68 инженер хамрагдсан.

## 2.2. Барилгын хүчитгэлийн аргачлал: Барилгын хүчитгэлийн тухай сургалтад хамрагдсан хүний тоо

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

2019 оны 05-р сарын 01-03-ны өдрүүдэд барилгын хүчитгэлийн аргачлалын тухай сургалтыг зохион байгуулж нийт 65 хүн хамрагдсан бөгөөд таамагласанаас олон байсан.

Үр дүн 2	Цутгамал төмөр бетон бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал	БХБЯ	Аргачлалыг БХБЯ-ны сайд 2018 оны 11-р сарын 6-ны өдөр батласан.
	Угсармал том хавтгаалжин бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал	БХБЯ	Аргачлалыг БХБЯ-ны сайд 2018 оны 11-р сарын 6-ны өдөр батласан.
	Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал	БХБЯ	Аргачлалыг БХБЯ-ны сайд 2018 оны 11-р сарын 6-ны өдөр батласан.
	Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ	БХБЯ	Аргачлалыг БХБЯ-ны сайд болон ЗТХЯ-ны сайдын хамтарсан тушаалаар 2018 оны 12-р сарын 28-ны өдөр батласан.

### (3) Үр дүн 3

Төслийн төлөвлөлтийн матрицын (ТТМ) дагуу Үр дүн 3-ын гүйцэтгэлийг дараах гурван шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

### 3.1 Төслийн хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр зохион байгуулагдсан сургалтын тоо

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

Ажлын хэсэг 3-1 нь 2018 оны 4 сард сургалтын хөтөлбөрөө батлуулж, суралцахуйн удирдамж бэлтгэх, мэдлэг дээшлүүлэх сургалтын агуулгыг боловсруулах ажлыг хийж байгаа бөгөөд одоогийн байдлаар тоон үзүүлэлтээр үнэлэх шатанд хүрч чадаагүй байна.

### 3.2 Сургалтын төвөөр үйлчлүүлэгчдийн тоо

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

Ажлын хэсэг 3 нь Нийслэлийн Иргэдийн Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвийн боловсролын сургалтын хөтөлбөр болон сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсронгуй болгох, сургалтын төвийн чадавхыг дээшлүүлэх зэрэг ажлыг хийж байгаа бөгөөд, одоогийн байдлаар тоон үзүүлэлтээр үнэлэх шатанд хүрч чадаагүй байна.

### **1-4 Төслийн зорилтын хүрээнд хүрсэн үр дүн**

Төслийн төлөвлөлтийн матрицын (ТТМ) дагуу Төслийн зорилтын гүйцэтгэлийг дараах хоёр шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

#### 1. Батлагдсан заавар, санамж бичгийн тоо

#### 2. Шинээр боловсруулсан болон шинэчлэн сайжруулсан гамшгийн эрсдэлийг бууруулах мэдээллийн тоо

Тухайн хугацаанд хүрсэн үр дүн:

А/Х тус бүр заавар, санамж бичиг болон шаардлагатай баримт бичгийг боловсруулах ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэсэн байна. Төсөл дууссаны дараах тогтвортой залгамж байдлыг хангахын тулд Төслийн хүрээнд боловсруулсан заавар болон бусад үр дүнг ОБЕГ, БХБЯ болон БСШУСЯ-аар зохих журмын дагуу батлуулах зорилготойгоор Төслийн үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж байна. Холбогдох баримт бичгийн боловсруулалтын одоогийн байдлыг доорх хүснэгтэнд үзүүлэв.



	Үйл ажиллагаа бүрт боловсруулах баримт бичиг	Гүйцэтгэх байгууллага	Одоогийн байдал
Үр дүн 1	Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар	ОБЕГ	Зааврын төлийг боловсруулж дууссан. ОБЕГ-ын Даргын зөвлөлд оруулах зорилгоор эцсийн байдлаар хянаана.
	Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах улсын албадын төлөвлөгөө боловсруулах заавар	ОБЕГ	Зааврын төлийг боловсруулж дууссан. ОБЕГ-ын Даргын зөвлөлд оруулах зорилгоор эцсийн байдлаар хянаана.
	Аймаг/сумын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар	ОБЕГ	Зааврын төслийг боловсруулж дууссан. Туршилтын аймгуудаас ирүүлэх саналын үндсэн дээр шинэчилнэ.
	Нийслэл/дүүргийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар	НОБГ	Зааврын төслийг боловсруулж дууссан. Туршилтын дүүргүүдээс ирүүлэх саналын үндсэн дээр шинэчилнэ.
	Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний заавар	ОБЕГ	Ерөнхий үнэлгээний зааврын төслийг ЖМБ-ын саналын үндсэн дээр шинэчилсэн. Нарийвчилсан үнэлгээний зааврын төслийн бүтцийг гаргасан.
	Гамшгийн орон зайн мэдээллийн системийн үйл ажиллагааг зохицуулах заавар	ОБЕГ	2019 оны 2-р сарын 20-ны өдрийн ОБЕГ-ын даргын тушаалаар батлуулав.
	Санамж бичиг	ОБЕГ эсвэл холбогдох байгууллага	Хяналтын хугацаанд дөрвөн (4) салбарын санамж бичиг байгуулж, долоон (7) санамж бичгийн төслийг энэ хяналтын хугацаанд боловсруулсан байна.
	Цагаан ном	ОБЕГ	"Монгол Улсын гамшгаас хамгаалах Цагаан ном 2017"-г боловсруулж дууссан.
Үр дүн 2	Одоогийн цутгамал төмөр бетон бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ болон хүчитгэлийн аргачлал	БХБЯ	Аргачлалыг БХБЯ-ны сайд 2018 оны 11-р сарын 6-ны өдөр батласан.
	Одоогийн угсармал том хавтгаалжин бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ болон хүчитгэлийн аргачлал	БХБЯ	Аргачлалыг БХБЯ-ны сайд 2018 оны 11-р сарын 6-ны өдөр батласан.
